

“Тогтвортой Амьжиргаа-3” төсөл

Дэлхийн Банк

**БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

2019

Товчилсон Үгс

АХХААЖДҮГ	Аймгийн Хүнс Хөдөө Аж Ахуй Жижиг Дунд Үйлдвэрийн Газар
АБОАЖГ	Аймгийн Байгаль Орчин Аялал жуулчлалын Газар
АМХГ	Аймгийн Мэргэжлийн Хяналтын Газар
БОАЖЯ	Байгаль Орчин Аялал Жуулчлалын Яам
БОНБЕҮ	Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Ерөнхий Үнэлгээ
БОНБНҮ	Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Нарийвчилсан Үнэлгээ
БОНХМ	Байгаль Орчин Нийгмийн Хамгааллын Менежмент
БОНХМБ	Байгаль Орчин Нийгмийн Хамгааллын Менежментийн Бодлого
БОЭМАБ	Байгаль Орчин, Эрүүл Мэнд, Аюулгүй Байдал
БИНХ	Багийн Иргэдийн Нийтийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
БОХУБ	Байгаль Орчны Хяналтын Улсын Байцаагч
ДЭМБ	Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага
ДБ	Дэлхийн Банк
ЭМНХЯ	Эрүүл Мэнд Нийгмийн Хамгааллын Яам
МЭЭГ	Мал Эмнэлгийн Ерөнхий Газар
МЭҮТ	Мал Эмнэлэг Үржлийн Тасаг
ОУХА	Олон Улсын Хөгжлийн Агентлаг
СГШТ	Санал Гомдол Шийдвэрлэх Тогтолцоо
СГБҮ	Санал Гомдол Барагдуулах Үйлчилгээ
ТХН	Төсөл Хэрэгжүүлэх Нэгж
ТХГН	Тусгай Хамгаалалттай Газар Нутаг
ХОМУ	Хамтын Оролцоот Мониторинг Үнэлгээ
МАОЭШХ	Мал Аж Ахуйн Эрдэм Шинжилгээний Хүрээлэн
М&Ү	Мониторинг & Үнэлгээ
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ҮХҮА	Үйлдвэрлэл худалдаа үйлчилгээний алба

Гарчиг

А.1 Төслийн Тодорхойлолт	1
А.1.1 Төслийн Хөгжлийн Зорилго	1
А.1.2 Төслийн Бүрэлдэхүүн.....	1
Бүрэлдэхүүн хэсэг1: Орон нутгийн засаглал, амьжиргааг дэмжих чадавх бий болгох.....	1
Бүрэлдэхүүн хэсэг 2: Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан дэмжих хөтөлбөр.....	2
Бүрэлдэхүүн хэсэг 3: Төслийн удирдлага, хяналт шинжилгээ, үнэлгээ	2
А.2 Байгаль орчин, нийгмийн хамгаалалтын менежментийн төлөвлөгөөний зорилго ба хамрах хүрээ.....	3
Б.1 Дэлхийн Банкны байгаль орчин нийгмийн хамгааллын бодлого.....	3
Б.2 Монгол улсын хууль, журам, стандартууд	3
Б.2.1 Байгаль орчны бодлого, хууль, тогтоомж.....	3
Б.2.2 Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээний талаарх Үндэсний Шаардлага.....	5
Б.2.3 Байгаль орчны мониторингийн тогтолцоо.....	8
В.1 Байгаль орчны өнөөгийн байдал ба тулгамдсан асуудлууд.....	13
В.2 Нийгмийн Суурь Мэдээлэл.....	15
Г. Байгаль Орчин, Нийгмийн Хамгааллын Менежментийн Төлөвлөгөө	17
Г.1 Нэмэлт Санхүүжилтийн төслийн хүрээнд хэрэгжих магадлалтай дэд төсөл, үйл ажиллагаа	18
Г.2 Байгаль Орчин, Нийгэмд Учирч Болзошгүй Нөлөөлөл	18
Г.3 Байгаль Орчин Нийгмийн Нөлөөллийг Бууруулах Арга Хэмжээ	20
Д1.Мониторингийн Төлөвлөгөө	25
Д2.Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа (Сургалт)	26
Д3. БОНХМТ-ний хэрэгжилтийг зохион байгуулах зохицуулалт	30
Д5. Тайлагнах журам.....	32
Д6. Гомдол Шийдвэрлэх Механизм (ГШМ).....	32
Е.1 ТА-3 төслийн бэлтгэл үе шатанд хийсэн хэлэлцүүлэг.....	Error! Bookmark not defined.
Е.2 ТА-3 төслийн Нэмэлт Санхүүжилтийн төслийн бэлтгэл шатанд хийсэн хэлэлцүүлэг.....	33
ХАВСРАЛТ 1.ОНХС-аас санхүүжүүлэх БЭМ-ийн үйл ажиллагаанд Байгаль Орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийхэд баримтлах шалгуурууд	45
ХАВСРАЛТ 2.ОНХС-ийн төслүүдэд Хяналт шинжилгээ хийх маягт	49
ХАВСРАЛТ 3. Байгаль Орчны Жил Бүрийн Аудит Хийх Ажлын Удирдамж.....	59
ХАВСРАЛТ 4.Барилгын ажлын явцад байгаль орчин нийгмийн хамгааллыг сайжруулах талаар тавих шаардлага	61

А. Танилцуулга

А.1 Төслийн Тодорхойлолт

2002 онд Дэлхийн банк 3 үе шаттай Хөтөлбөрт зохицуулсан зээлийн эхний үе шатыг баталсан бөгөөд бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийн менежмент, мал аж ахуйн даатгалыг агуулсан санхүүгийн хүртээмжийг гүнзгийрүүлэх зорилгоор бичил санхүүжилтийг түгээн дэлгэрүүлэх, олон нийтийн саналаар бүтээн байгуулах дэд бүтэц, суурь үйлчилгээг хөгжүүлэх гэсэн 3 үйл ажиллагаанд анхаарлаа хандуулсан. Энэхүү төсөл нь дээрх төслийн гурав дахь буюу эцсийн үе шат болон хэрэгжиж байгаа билээ.

А.1.1 Төслийн Хөгжлийн Зорилго

Тогтвортой амьжиргаа-3 төсөл нь Хөдөө орон нутагт нэн чухал ач холбогдолтой хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэхэд засаглал, иргэд, олон нийтийн оролцоог сайжруулах зорилготой.

А.1.2 Төслийн Бүрэлдэхүүн

Бүрэлдэхүүн хэсэг1: Орон нутгийн засаглал, амьжиргааг дэмжих чадавх бий болгох

Тус бүрэлдэхүүн хэсгийн зорилго нь Засгийн газрын мөрийн хөтөлбөр болон орон нутгийн хөгжлийг дэмжих бүтэц, тогтолцоог цаашид боловсруулах, хэрэгжүүлэх орон нутгийн болон үндэсний түвшний чадавхыг бэхжүүлэхэд оршино.

Орон нутгийн түвшинд Улсын нэгдсэн төсвийн тухай хууль болон Сум хөтөлбөрийн хүрээнд засаглалын үүрэг хариуцлага, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд мэдэгдэхүйц өсөлтийг бий болгон үр дүнтэй удирдахад Сумын засаг захиргаа бэрхшээлтэй тулгарч байна.

Төсөл орон нутгийн удирдлага, олон нийтэд Орон нутгийн хөгжлийн сан, Сум хөтөлбөрийг хэрэгжүүлэх, дунд хугацааны төлөвлөлтөд олон нийтийн оролцоо, төсөв төлөвлөх, батлах түүнчлэн худалдан авалт, удирдлага, тайлагналт, хяналт шинжилгээ болон үнэлгээ, бэлчээрийн газрын төлөвлөлт болон удирдлага зэргийг агуулсан төсвийн гүйцэтгэл зэрэгтэй холбоотой сургалт, мэргэжлийн туслалцаа үзүүлэх юм. Сургалт, мэргэжлийн туслалцааг аймагт суурилсан Сумын дэмжих багаар дамжуулан хүргэнэ.

Эдгээр багуудад сургалтын хөтөлбөр, материал боловсруулах, сургагч нарт зориулсан сургалт зэрэгт дэмжлэг үзүүлэх Үндэсний мэргэжлийн зөвлөх үйлчилгээний баг мэргэжлийн туслалцаа үзүүлнэ. Энэ тогтолцоо нь аймгийн түвшний баг болон сумын удирдлага, иргэд хоорондоо ойр, байнгын холбоотой байх боломжийг бүрдүүлэх юм. Сумын дэмжих баг, мэргэжлийн туслалцаатай холбоотой үйл ажиллагааг Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны агентлагтай (SDC) хамтран санхүүжүүлнэ.

Үндэсний түвшинд төсөл, Сум хөтөлбөр хэрэгжүүлэх, Орон нутгийн хөгжлийн санг хөгжүүлэхтэй холбоотой эдийн засаг, санхүүгийн асуудал хариуцсан төвийн олон нийтийн засаг захиргааны байгууллагуудад мэргэжлийн туслалцаа үзүүлэн ажиллана.

Одоо ч туршилтын үе шатандаа байгаа Сум хөтөлбөрийн хувьд, хөтөлбөрийг боловсруулж, өргөжүүлэх зорилгоор Эдийн засгийн хөгжлийн яаманд мэргэжлийн туслалцлаа үзүүлж ажиллана. Үүнд Сум хөтөлбөрийн туршилтын үе шатыг үнэлэх, үүнийг өргөжүүлэхийн тулд хөтөлбөр хэрэгжүүлэх удирдамж, гарын авлага, дүрэм, журмыг боловсруулах мөн хөтөлбөрийн удирдлага, хяналт шинжилгээний үндэсний түвшний тогтолцоог бэхжүүлэх зэрэг багтаж болно.

Бүрэлдэхүүн хэсэг 2: Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан дэмжих хөтөлбөр

Component 2.1: Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт

Сайн засаглалд зориулсан урамшууллын тухайд, төсөл Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны санхүүжилтэд зориулж суманд Сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн дэмжлэг үзүүлнэ.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нь төсөв төлөвлөх, батлах, төсвийн гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэл, тайлагналт, дотоод, гадаад хяналт түүнчлэн олон нийтийн хяналт бүхий санхүүгийн болон бодлогын төлөвлөлтөөс эхлээд бүхэл бүтэн төсвийн төлөвлөлтийн үйл явц дахь сайн засаглалыг хангах зорилготой юм.

Сумын болон түүнээс доош түвшинд улсын хөрөнгө оруулалтын санхүүжилт, гүйцэтгэл нь төсөв боловсруулах үйл явцын чухал хэсэг байдаг. Иргэдийн оролцоо, сумын төсвийг багийн иргэдийн тэргүүлэх чиглэл болон Орон нутгийн хөгжлийн сангийн үйл явц, үр дүнг иргэдийн сэтгэл ханамжтай уялдуулахад онцгой ач холбогдол өгөх болно. Сумын гүйцэтгэлийн хяналт шинжилгээний системд суурилан бие даасан шинжээчид бүх сумдын гэрээнд тусгасан гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийг жил бүр үнэлнэ. Зорилтдоо хүрсэн болон давуулан биелүүлсэн сумууд дараагийн санхүүгийн жилийн Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтэд санхүүгийн дэмжлэг хэлбэрээр тодорхой хувь авна.

Одоогийн байдлаар энэхүү зардлыг өмнөх жилийн төсвийн хуваарилалтын дээд тал нь ойролцоогоор 25 орчим хувь байж болох санал дэвшүүлж байна. Гэвч төслийн хэрэгжилтийн явцад үүнийг дахин хянаж авч үзэх бөгөөд шаардлагатай бол өөрчлөлт оруулж болно.

Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг Орон нутгийн хөгжлийн сангийн хуваарилалтын дагуу Төрийн сангаар дамжуулан олгоно.

Бүрэлдэхүүн хэсэг 2.2: Жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ

Төсөл, сайн засаглалын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн хуваарилалтыг тодорхойлох зорилгоор сумын жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнүүдийг зохион байгуулна. Сумын гүйцэтгэлийн үнэлгээ болон зэрэглэлийг улс төрийн хувьд төвийг сахисан гуравдагч этгээд (сайн засаглалын гүйцэтгэлийн үнэлгээний баг)-ээр гүйцэтгүүлнэ.

Төсөл Жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний багийг сургах, чадавхжуулах үйл ажиллагааг санхүүжүүлнэ. Тус дэд бүрэлдэхүүн хэсгийг SDC –ийн дэмжлэгээр хамтран санхүүжүүлнэ.

Бүрэлдэхүүн хэсэг 3: Төслийн удирдлага, хяналт шинжилгээ, үнэлгээ

Төсөл хэрэгжүүлэх нэгж (ТХН) Сангийн яаманд байрлана. Гуравдугаар бүрэлдэхүүн хэсэг төслийн хэрэгжилтийн бүтцийг дэмжих бөгөөд , ажилчдын

зардал, холбогдох зардал ба ХШҮ, худалдан авалт, санхүүгийн менежментийн үйл ажиллагааг санхүүжүүлнэ.

Олон улсын хөгжлийн хамтын ажиллагааны агентлаг нь Орон нутгийн хөгжлийн сангийн Удирдлагын мэдээллийн системийг боловсруулж хөгжүүлэх, төслийн суурь судалгаа, дунд хугацаа, үр дүнгийн төгсгөлийн үнэлгээг зохион байгуулах зэрэг ХШҮ-ний дэмжлэг үзүүлнэ.

А.2 Байгаль орчин, нийгмийн хамгаалалтын менежментийн төлөвлөгөөний зорилго ба хамрах хүрээ

БОНХМТ нь төслийн үйл ажиллагаа болон аливаа дэд төсөл, үйл ажиллагаатай холбоотой байгаль орчин, нийгэмд учирч болзошгүй нөлөөллийг тодорхойлох, байгаль орчин, нийгэмд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, зохицуулахад чиглэсэн удирдамжуудаар төсөл хэрэгжүүлэгч талуудыг хангах зорилготой.

БОНХМТ нь төслийн зорилго, бүрэлдэхүүн хэсгүүдийн зорилтуудад тулгуурлан нөхцөл байдлыг ерөнхийлөн дүгнэж, төслийн хүрээнд байгаль орчинд болон нийгэмд сөргөөр нөлөөлж болзошгүй дэд төсөл, үйл ажиллагаануудад үнэлгээ хийх аргачлалыг тогтоож, тохиолдож болзошгүй сөрөг үр дагавруудыг төсөлд хамрагдах хүмүүс болон бусад оролцогч талуудын оролцоотойгоор тодорхойлох, түүнээс зайлсхийх, багасгах үйл явц, шаардлагуудыг тусгасан. Энэхүү БОНХМТ-өөг олон нийтийн төлөөлөл болон төслийн оролцогч талуудаар хэлэлцүүлэн зөвшилцөж сайжруулан, олон нийтэд ил тод мэдээлэх зорилгоор төвийн болон төсөлд хамрагдаж буй аймгуудын номын сан, ТХН-ийн болон ДБ-ийн цахим хуудаснуудад дэлгэн тавьсан болно.

Б. Хууль эрхзүй, Бодлого ба Зохицуулалтын Шаардлага

Б.1 Дэлхийн Банкны байгаль орчин нийгмийн хамгааллын бодлого

Төсөл нь Байгаль орчны Үнэлгээ (ҮАБ4.01), Байгалийн амьдрах орчин (ҮАБ 4.04), ба Уугуул Иргэдийн Бодлого (ҮАБ4.10) зэргийг багтаасан Дэлхийн банкны Байгаль Орчин, Нийгмийн Хамгааллын Бодлогыг дагаж мөрдөнө. Иймд, БОНХМТ-өөг боловсруулахдаа Дэлхийн банкны Байгаль Орчин, Нийгмийн Хамгааллын Бодлогыг мөрдлөг болгосон билээ. Эдгээр бодлогын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Дэлхийн банкны цахим хуудаснуудын холбогдох хэсгээс авах боломжтой.

Б.2 Монгол улсын хууль, журам, стандартууд

Б.2.1 Байгаль орчны бодлого, хууль, тогтоомж

Монгол Улс байгаль орчны үнэлгээ, менежментийн цогц бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Монгол Улс олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэдийн эрүүл мэнд, сайн сайхан амьдрах нөхцөлийг хангах, байгаль орчны чанарыг хадгалан хамгаалах зорилгоор бодлого, стратеги, хууль тогтоомжууд гаргаж, хэрэгжүүлж байна. Байгаль орчны менежментийн талаарх бодлого, хууль тогтоомжийн шатлал нь Үндсэн хуулиас эхлэн олон улсын гэрээ, байгаль орчин, байгалийн нөөцийг хамгаалах хууль тогтоомжууд зэрэг таван үе шатаас бүрдэнэ.¹

Бодлогын үндсэн баримт бичиг нь 1996 онд батлагдсан Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө, 1997 онд батлагдсан Төрөөс байгаль орчны

¹ НҮБХХ. 2008. *Монгол улсын байгаль орчны хууль эрх зүйн тогтолцоо*. Улаанбаатар ба Веллингтон хот.

талаар баримтлах бодлого, Цөлжилттэй тэмцэх үйл ажиллагааны төлөвлөгөө, Биологийн олон янз байдлыг хамгаалах үйл ажиллагааны төлөвлөгөө, Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгийг БОАЖЯ санаачлан боловсруулж батлуулсан байна. Түүнчлэн 21-р зууны Монголын үйл ажиллагааны хөтөлбөр, Байгаль орчны үйл ажиллагааны үндэсний төлөвлөгөө, Цаг уурын өөрчлөлтийн үйл ажиллагааны төлөвлөгөөг 2000 онд боловсруулж батлуулсан байна. 2010-2012 онд байгаль орчны талаар хэд хэдэн хөтөлбөр (тухайлбал, Усны үндэсний хөтөлбөр, Ойн үндэсний хөтөлбөр, Агаарыг хамгаалах хөтөлбөр, Байгаль орчны боловсрол, Тусгай хамгаалалттай газар нутаг, Озоны давхаргыг хамгаалах хөтөлбөрүүд) батлагдсан. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний талаар баримтлах төрийн бодлого 1998 оноос хэрэгжиж эхэлсэн. Түүнчлэн бусад яамдтай хамтран Замын Мастер Төлөвлөгөө, Эрчим Хүчний Салбарын Мастер Төлөвлөгөө, Аялал Жуулчлалын Мастер Төлөвлөгөө, Сэргээгдэх Эрчим Хүчний Мастер Төлөвлөгөө зэрэг баримт бичгүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна. Хүний хөгжлийн жилийн тайлан гэх мэт бусад баримт бичгүүдэд хүрээлэн буй орчны асуудлыг хамруулан баримтжуулж байна.

Монгол улсын байгаль орчны бодлогын үндсэн суурь зарчим бол эдийн засгийн хөгжил нь байгалийн нөөцийг олборлох, ашиглахын зэрэгцээ агаар, ус, хөрсний бохирдлыг хянаж хэвийн нөхцөлийг нь хадгалах явдал юм. 1996 оны 4-р сард, Монгол Улсын Тогтвортой Хөгжлийн Үндэсний Зөвлөл тус улсад тогтвортой хөгжлийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах үүрэгтэйгээр байгуулагдсан. Төрийн стратеги нь байгаль орчинд ээлтэй, эдийн засгийн хувьд тогтвортой, нийгмийн хувь хангалуун хөгжлийг зорих бөгөөд үүнд хүмүүсийг урт хугацааны тогтвортой хөгжлийн тодорхойлох хүчин зүйл гэж онцолдог.

Монгол Улсын Засгийн газар 1990, 2012 онд байгаль орчны хууль эрхзүйн томоохон шинэчлэл хийж, газрын тухай, тусгай хамгаалалттай газар нутгийн тухай, усны тухай, ойн тухай, ан амьтны тухай, ургамлын тухай хуулиудыг шинэчлэн батлуулжээ. МАААЧД төслийн хүрээнд мөрдөгдөх гол хуулиудын жагсаалтыг дараах, **Б.1-р хүснэгтэд** тусгасан.

Хүснэгт Б.1: Байгаль орчны гол хуулиуд

Но	Хуулийн нэр	Батлагдсан болон өөрчлөлт орсон он	Холбогдох журам
1	Байгаль Орчныг Хамгаалах тухай	1995, өөрчлөлт орсон он: 2006, 2008, 2012	4
2	Газрын тухай	6-р сар, 2002	-
3	Газрын кадастр ба зураг зүйн тухай	12-р сар, 1999	-
4	Газрын төлбөрийн тухай	4-р сар, 1997	-
5	Газар өмчлөх тухай	6-р сар, 2002	-
6	Газар өмчлөх тухай хуулийн журмыг хэрэгжүүлэх тухай	6-р сар, 2002	-
7	Геоземи, зураг зүйн тухай	10-р сар, 1997	-
8	Улсын Тусгай Хамгаалалттай Газрын тухай	11-р сар, 1994	16
9	УТХГН-ийн Орчны бүсийн тухай	10-р сар, 1997	-
10	Усны тухай	4-р сар, 2004	-
11	Ус, рашаан ус ашигласны төлбөрийн тухай	5-р сар, 1995, 2012	21
12	Ойн тухай	3-р сар, 1995	38

13	Ойгоос хэрэглээний мод түлээ ашигласны төлбөрийн тухай	5-р сар, 1995	-
14	Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах тухай	5-р сар, 1996	-
15	Байгалийн нөөц ашигласны төлбөрөөс байгаль хамгаалах, нөхөн сэргээхэд зарцуулах хувь хэмжээний тухай	1-р сар, 2000	-
16	Байгалийн ургамлын тухай	4-р сар, 1995	3
17	Байгалийн ургамал ашигласны төлбөрийн тухай	5-р сар, 1995	-
18	Ургамал хамгаалах тухай	3-р сар, 1996	-
19	Агаарын тухай	3-р сар, 1995	-
20	Ус цаг уурын тухай	11-р сар, 1997	-
21	Химийн хорт бодисоос хамгаалах тухай	4-р сар, 1995	18
22	Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай	1998, өөрчлөлт орсон он 2002	-
23	Хатуу хог хаягдлын тухай	11-р сар, 2003	-
24	Аюултай хог хаягдлыг экспортлох, импортлохыг хориглох тухай	11-р сар, 2000	-
25	Хөрс Хамгаалал болон Цөлжилтөөс Сэргийлэх тухай	2012	-

Ус ашиглалт болон бохир ус зайлуулах, хортой хог хаягдал, хортой химийн бодисын хэрэглээ, хамгаалах, зайлуулахтай холбоотой бусад тогтоол журмын **Хүснэгт Б.2**-д жагсаав.

Хүснэгт Б.2: Ус ашиглалт, бохир ус зайлуулахтай холбоотой гол дүрэм журам тогтоолууд

Тушаал, журам, удирдамжийн нэр	Батлагдсан Он
Усны бохирдлын төлбөрийн хэмжээ.	1992
Гол мөрний болон усны эх үүсвэрийг хамгаалах бүсийн журам.	1992
Бохир усыг септик танк доторлогооны журам.	1995
Усны нөөцийн бохирдол, усны хомсдол, нөхөн сэргээлтийг бүртгэх журам.	1996
Усны нөөцийг бохирдлоос хамгаалах журам.	1997
Булаг шандыг хамгаалах журам.	1998
Худаг, уст цэг байгуулах, засвар хийх журам	2005

Б2.2 Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Үнэлгээний талаарх Үндэсний Шаардлага

БОНБУ-ний шаардлагыг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиар зохицуулдаг. Энэ хууль 1998 батлагдсан ба түүнд 2002 онд нэмэлт өөрчлөлт оруулсан. Хуулийн нэр томьёо нь бүх шинэ төслүүд, түүнчлэн одоо байгаа үйлдвэр, үйлчилгээ, барилга байгууламжийг сэргээн засварлах, өргөжүүлэх, газар, байгалийн нөөцийг ашиглахтай холбоотой төслүүдэд хамаарна. Энэхүү хуулийн зорилго нь хүрээлэн буй орчныг хамгаалах, экологийн тэнцвэрийг алдагдуулахаас урьдчилан сэргийлэх, байгалийн нөөцийг ашиглахад хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг хамгийн бага байлгах, хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлэх, бүс нутгийн болон салбарын бодлого, хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө, төслүүдийн байгаль орчны

талаарх шийдвэрийг батлахтай холбоотой үүсэх харилцааг зохицуулахад оршино.. **Хүснэгт Б.3**-д Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Ерөнхий Үнэлгээ хийлгэх шаардлагатай төслүүдийн ангиллыг харуулав.

Хүснэгт Б.3 Байгаль Орчинд Нөлөөлөх Байдлын Ерөнхий Үнэлгээ хийлгэх шаардлагатай төслүүдийн ангилал (БОНБУ-ний тухай хуулийн дагуу)


#	Төслийн төрөл	Гүйцэтгэгч	
		Байгаль Орчны төрийн захиргааны төв байгууллага	Аймаг ба нийслэлийн БОАЖГ
1	Уул уурхай	Бүх төрлийн эрдэс баялаг олборлох үйл ажиллагаа	Орон нутагт түгээмэл тархацтай эрдэс баялаг ашиглах
2	Хүнд үйлдвэр	Бүх төрлийн	
3	Хөнгөн ба хүнсний үйлдвэр	Засгийн газрын өмчлөлийн хүнд үйлдвэрүүд	Орон нутгийн ЖДҮ эрхлэх
4	Хөдөө Аж ахуй	-Усан сан -услалтын систем -атар газар хагалах	Бусад үйлдвэрлэл, үйлчилгээ
5	Дэд бүтэц	- 1MW - аас дээш хүчин чадалтай эрчим хүчний үйлдвэр - 35 KV-аас дээш чадлын цахилгаан дамжуулах шугам -Дулаан дамжуулах хоолой -Усан цахилгаан станц -Төмөр зам -Нисэх буудал -Олон улсын болон хот хоорондын зам -Улс хоорондын болон хот хоорондын холбооны шугам	- 1MW хүртэлх хүчин чадалтай эрчим хүчний үйлдвэр - 35 KV хүртэлх чадалтай цахилгааны шугам - Орон нутгийн чанартай дулаан дамжуулах шугам - Орон нутгийн чанартай зам, холбоо
6	Үйлчилгээ	-50 ор хоногоос дээш хүчин чадалтай үйлчилгээний байгууллага, зочид буудал, амралт сувиллын газар -аялал жуулчлал	-50 ор хоног хүртэл хүчин чадалтай үйлчилгээний байгууллага, зочид буудал, амралт сувиллын газар
7	Бусад төсөл: - Хот төлөвлөлт -Цэрэг, батлан хамгаалахын -Ус хангамжийн систем -Ус цэвэрлэх байгууламж -Хуурай хог хаягдал	- 10000-аас дээш хүн амтай хотын ус хангамж, ус цэвэрлэх байгууламж ба хатуу хог хаягдал зайлуулах систем -Улсын өмчийн цэрэг иргэний хамгаалалтын байгууламж	10000 хүртэл хүн амтай хотын ус хангамж, ус цэвэрлэх байгууламж ба хатуу хог хаягдал зайлуулах систем -Орон нутгийн өмчийн цэрэг иргэний хамгаалалтын байгууламж
8	Биологийн төрөл зүйлийн	-Их хэмжээний загас агнуурын үйл ажиллагаа -Амьтан ургамал ашиглахтай холбоотой үйл ажиллагаа	- Ойн аж ахуй, ан агнуур - Орон нутгийн чанартай загас агнуур
9	Химийн, радио идэвхт	Химийн, радио идэвхт	

	бодис ба аюултай хог хаягдал	бодис ба аюултай хог хаягдлыг цэвэрлэх, ашиглах, тээвэрлэх, хадгалах, устгах, үйл ажиллагаа	
10	Улсын ТХГН-т явагдах аливаа үйл ажиллагаа	Улсын ТХГН-т явуулах үйл ажиллагаанууд	Орон нутгийн ТХГ-т явуулах үйл ажиллагаа.

БОНБУ-ний тухай хуулиар 2 төрлийн үнэлгээ хийхийг хуульчилж өгсөн:

- 1) БОНБЕУ (ерөнхий үнэлгээ) - БОНБЕУ-ийг хийлгэхийн тулд төсөл хэрэгжүүлэгч нь БОАЖЯ-нд (эсвэл аймгийн БОАЖГ-т) төслийн ТЭЗҮ, техникийн дэлгэрэнгүй мэдээлэл, зураг болон бусад мэдээллийг багтаасан төслийн товч танилцуулгыг хүргүүлнэ. БОНБЕУ нь дараах дөрвөн дүгнэлтийн аль нэгэнд хүргэж болно. Үүнд: (i) БОНБНУ шаардлагагүй, (ii) тухайн төслийг тодорхой нөхцөлтэйгөөр хэрэгжүүлж болно; (iii) БОНБНУ шаардлагатай, эсвэл (iv) төслийг хэрэгжүүлэхийг цуцлах. БОНБЕУ нь үнэ төлбөргүй хийгдэх бөгөөд ихэвчлэн 12 хоног үргэлжилдэг. **Зураг Б.1**-д БОНБЕУ ба БОХБНУ хийх журмын дэс дарааллыг харуулав.
- 2) БОНБНУ - хамрах хүрээг БОНБЕУ-ээр тодорхойлдог. БОНБНУ-ний тайланг БОАЖЯ-наас олгосон эрх бүхий аж ахуйн нэгж/компани тусгай журмын дагуу боловсруулж батлуулах ёстой. Уг аж ахуйн нэгж нь БОНБНУ-ний тайланг боловсруулж БОАЖЯ-нд хүргүүлнэ. Уг төслийн БОНБЕУ-г хийсэн шинжээч мэргэжилтэн 18 хоногийн дотор БОНБНУ-ний тайланг судлан тойм дүгнэлт гаргаж, БОАЖЯ-д танилцуулах ёстой. Шинжээчийн дүгнэлтийг үндэслэн БОАЖЯ уг төслийг батлах, эс зөвшөөрөх тухай шийдвэр гаргана.
- 3) БОНБНУ нь дараах бүлгүүдийг агуулна: (i) Байгаль орчны суурь мэдээлэл; (ii) төслийн хувилбарууд; (iii) нөлөөллийг багасгах, арилгах зөвлөмж; (iv) Сөрөг нөлөөлөл ба түүний үр дагаврын цар хүрээ, тархалтын дүн шинжилгээ; (v) Эрсдэлийн үнэлгээ; (vi) Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө; (vii) Байгаль орчны мониторингийн хөтөлбөр; (viii) Төслийг хэрэгжүүлэх эсэх талаар оршин суугчдын санал.

Зураг 4.1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол улсын хуулийн дагуу БОНБЕУ ба БОХБНУ хийх үйл явцын бүдүүвч



Эх сурвалж: Иргэдэд зориулсан Хуулийн эмхэтгэл ном (2001):

БОНБЕУ хийлгэх шийдвэр гаргах талаарх Байгаль орчин, аялал жуулчлалын яам / БОНБЯ / эсвэл аймаг (аймгийн ЗДТГ)-ын үүрэг нь тухайн төслийн төрөл, хэмжээнээс хамаарна.

Б.2.3 Байгаль орчны мониторингийн тогтолцоо

Байгаль орчны хяналт шинжилгээ хийх шаардлага нь хүрээлэн буй орчны агаар, ус, орчны дуу чимээ, хөрсний чанарын чиг хандлага, тэдгээрийн чанарт бохирдол, бусад антропоген үйл ажиллагаа, болон хог хаягдал хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох явдал юм. Төслийн үйл ажиллагаанаас бий болох хаягдал, бохирдуулагч төсөл хэрэгжих газрын ойр орчны агаар, газрын доорх ба гадаргын ус, нуурт хэрхэн нөлөөлж байгаад мониторинг хийх шаардлагатай. Мониторинг Хяналт нь нөлөөллийн хяналттай харьцуулах арга хэрэгсэл болж өгдөг тул төсөлтэй холбоотой аливаа төрлийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө орчны чанарыг тодорхойлох зорилгоор хийгддэг. Энэ нь энгийн нөхцөлд гэнэтийн өөрчлөлт гарсан эсэхийг шалгахад ашиглагдана.

Ус, Цаг Уур, Орчны Шинжилгээний Газар (УЦУОШГ) нь байгаль орчны чанарыг хянах зорилгоор ус, агаар, хөрс, хүрээлэн буй орчны цацраг, хүчиллэг, тоос

шороо, хүхрийн хий зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж байгаль орчны хяналт мониторинг хийх үүрэгтэй. Том хотууд дахь лабораториуд агаар, ус, хөрсний чанар, цацрагийн түвшнийг тогтмол хэмжиж, цахилгаан станц, тээврийн хэрэгслийн бохирдлын эх үүсвэрийг хянах; байгаль орчны үнэлгээний талаар шаардлагатай хяналт шинжилгээний ажлыг явуулах; бусад байгаль орчны хяналтын байгууллагуудтай хамтран үйлдвэрлэлийн хог хаягдлыг зайлуулах, устгах үйл явцыг хянах үүрэгтэй ажилладаг. **Хүснэгт Б.4-д** УЦУОШГ болон түүний харьяа аймгууд дахь УЦУОШГ-ын үүрэг хариуцлагыг харуулсан.

Хүснэгт Б.4: УЦУОШГ-ын байгаль орчны мониторингийн талаарх үүрэг

Хяналтын төрлүүд	Байршлууд
Хот суурин газрын агаарын чанар / SO ₂ , NO _x , CO, O ₃ , HC, PM ₁₀ , PM _{2.5} /	35 газарт
Хүчиллэг бороо / NH ₄ , SO ₂ , HCl, HNO ₃ , NH ₃ /-ны хяналт	2 газарт
Хүлэмжийн хийн хяналт	1 лаборатори
Элс / шар / шороон шуурганы ажиглалт / Тоос PM ₁₀ , PM 2.5 тархалтыг хэвтээ ба босоо чиглэлд тодорхойлох /	9 станцууд
Усны чанар	
Усны чанар / 91 гол, 16 нуур рН, ЕС, O ₂ гэх мэт. /	188 газарт
Саарал усны хяналт / Улаанбаатар хотод 5 ба хөдөө 28	33 ус цэвэрлэх байгууламжид
Хот суурин газрын хөрсний чанар	340 газарт
Байгаль орчны цацрагийн хяналт	35 газарт

Эх сурвалж: Ус цаг уур орчны шинжилгээний газрын танилцуулга, БОАЖЯ, 2016 он

В Байгаль Орчин ба Нийгмийн Суурь Мэдээлэл Baseline

Монгол Улс нь Хойд Азийн бүс дэх далайд гарцгүй орон бөгөөд, 1.56 сая хавтгай дөрвөлжин км нутаг дэвсгэртэй, гурван сая гаруй хүн амтай, үүнээс 2.2 сая нь хот суурин газарт амьдардаг. Хөдөө орон нутагт хүн амын нягтрал нэг хавтгай дөрвөлжин км тутамд 0.5 хүн амьдардаг бөгөөд хөдөөгийн амьжиргааны гол орлогыг нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйгаас бүрдүүлдэг. Засаг захиргааны хувьд Монгол улс нь Улаанбаатар хот болон 21 аймаг, 330 гаруй сумдаас бүрддэг.

Монгол орны газрын гадаргуу нь гол төлөв хойд ба баруун талын уулархаг хэсгээр 914-1524 м хүртэл өндөр далайн түвшнээс дунджаар 1580 метр өндөрлөг гадаргуутай. Монголын баруун, баруун өмнөд бүс нутгаар үргэлжилдэг Алтайн нурууны ноён оргил Хүйтний оргил нь хамгийн өндөр (4,375 метр) уул юм. Зүүн ба өмнөд хэсэг нь нам дор газар, тал хээрийн хэв шинжтэй. Монголд Азийн хамгийн том цэнгэг нууруудын нэг Хөвсгөл нуур байдаг бөгөөд ландшафтын хувьд давст нуур, намаг, элсэн манхан, өвсөрхөг тал, уулын ой, мөнх цас, мөсөн голууд зэрэг төрөл бүрийн хэв шинжийг агуулдаг. Монгол орны хойд ба баруун хэсэг нь газар хөдлөлтийн идэвхтэй бүс бөгөөд олон тооны халуун рашаан, унтарсан галт уул элбэг байдаг.

Цаг уур:² Монгол нь далайгаас алслагдсан, хойд ба баруун талаараа далайн түвшнээс дээш өндөрт өргөгдсөн өндөр уулсаар хүрээлэгддэг тул цаг агаарын эрс тэс уур амьсгалтай. Жилийн дундаж температур (45 градусын өргөрөгт) 2 хэм, нутгийн баруун хойд нутгаар -4 хэм дулаан байна, говийн өмнөд хэсгээр дунджаар 6 хэмээс илүү байна (**Зураг 5.1**). Өвлийн дундаж температур -8°C - 32°C хооронд, зуны температур 6°C-аас 24°C хооронд хэлбэлздэг. Жилийн нийт хур тунадас говийн өмнөд хэсгээр 50 мм-ээс хойд хэсгээр 450 мм-ийн хооронд хэлбэлздэг. Жилийн дундаж хур тунадас хойд болон баруун хэсгээр 300-400 мм, Алтайн болон төвийн, хойд ойт хээрийн бүсэд 250-300 мм, зүүн ба хээрийн бүсэд 150-200 мм байдаг. Болзошгүй ууршилтын тархалт ихэнх нутгаар 500 мм-ээс дээш байна.

Ургамалжилт: Монгол орны ургамалжилтыг нутгийн хойд хэсгээс өмнөд хэсэг рүү экологийн таван бүсийн онцлогийг харгалзан ангилж болно: өндөр уулын, ойт хээрийн, тал хээрийн, цөлөрхөг хээрийн болон цөлийн бүс (**Зураг 5.2**) гэж ангилна. Ойн талбай нийт нутаг дэвсгэрийн 9.2 хувийг эзэлдэг бөгөөд ой бүхий талбай ихэнхдээ нутгийн хойд хэсэгт тайга, ойт хээрийн бүсэд байдаг. Ойт хээр, хээрийн бүс нь нийт нутаг дэвсгэрийн талаас илүү хувийг эзэлдэг (30% ба 20%) бөгөөд хүн, малын хамгийн их төвлөрөл энэ бүсэд байдаг бөгөөд энэ нь биомассын харьцангуй өндөр бүтээмжтэй (600-1,800 кг / га) юм. Цөлөрхөг хээр, цөлийн бүс нь ургамлын ургац багатай (30-400 кг / га) ба ний газар нутгийн 37 орчим хувийг эзэлдэг.

Экосистем ба биологийн олон янз байдал: Монгол Улс нь ОХУ, БНХАУ-ын хооронд, Төв Азийн төв хэсэгт, Сибирийн тайга, Евроазийн тал, Төв Азийн говь цөлийн болон Арктикийн байгалийн бүс бүслүүрийн дамжсан хэсэгт байрладаг. Номхон далай, Төв Азийн дотоод ус цуглуулах сав газар, Сибирийн тайга, Төв Азийн тал нутаг, говь цөлийн экосистем нь өвөрмөц зүйлийн амьтан ургамлын төрөл зүйлээр элбэг байдаг нь даян дэлхийн ач холбогдолтой юм. Монголын байгаль экосистем нь дэлхийн болон олон улсын чухал ач холбогдолтой биологийн олон янз байдлыг хамруулдаг бөгөөд үүнд ДБХС-аас тодорхойлсон Даян Дэлхийн тэргүүлэх 35 эко-бүсийн хэсэг (Дорнод Монгол дахь Амур-Хейлун, Баруун Монгол дахь Алтай-Саян), ЮНЕСКО-гийн Дэлхийн байгалийн өвийн 2 газар, Рамсарын конвенцод хамрагдсан 11 газар, зэрлэг адуу-Тахь (*Equus ferus przewalskii*), Зэрлэг тэмээ (*Camelus ferus*), Азийн зэрлэг илжиг-Хулан (*Equus hemionus*), Говийн баавгай- Мазаалай (*Ursus arctos gobiensis*) зэрэг дэлхийд ховордсон хөхтөн амьтдын нутаг, бөхөн (*Saiga tatarica mongolica*) болон бусад ховор ховордсон амьтны нутаг болдог.

20-р зууны дунд үе хүртэл биологийн олон янз байдал болон улирлын чанартай, уур амьсгалын горим, ландшафтын өвөрмөц хэв маягтай хосолсон, байгаль экосистемд зохицсон бэлчээрийн мал аж ахуй нь Монгол улсын экосистемийн салшгүй хэсэг болж байв. Чухамдаа энэ нь газарзүйн болон уур амьсгалын онцлог нөхцөл байдалд тохирсон, тогтвортой амьжиргааны эх үүсвэр, биологийн олон янз байдлын бүрэн бүтэн байдлын хяналтын шугам болж байсан.

Монгол Улсын нутаг дэвсгэрт 16 төрлийн эко систем байдаг бөгөөд эдгээрийг байгаль хамгаалал, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн уялдааг нэмэгдүүлэх зорилгоор экологийн дөрвөн эко бүсэд хуваадаг, тухайлбал Даурын тал (нийт нутгийн 28.2%), Хангай (нийт нутгийн 16.4%), Төв Азийн говь цөл (нийт нутгийн

² Дагвадорж. (2010) Монгол улс: 2009 оны уур амьсгалын өөрчлөлтийн үнэлгээний тайлан. БОАЖЯ.

16.4%), Алтай-Саян (нийт талбайн 23.1%) **(Зураг 5.3)**. Эдгээр экосистемийн өвөрмөц бүрдэл бүхий эко бүсэд 138 зүйл хөхтөн амьтан, 79 зүйлийн загас, 22 зүйлийн мөлхөгч, 6 зүйлийн хоёр нутагтан, 476 зүйл шувуу, 13 мянга гаруй зүйл шавж, 516 зүйл нялцгай биетэн, 3127 зүйл ургамал, 1574 зүйл замаг, 495 зүйл хөвд, 838 зүйлийн мөөгөнцөр (Монгол Улсын Засгийн газар, 2015 он) байна. Нийтдээ 110 зүйлийн амьтан, 192 зүйлийн ургамлыг улсын хэмжээнд ховордсон гэж үзэн, нэн ховордсон амьтан ургамлын жагсаалтад болон Монгол Улсын Улаан номд оруулжээ.

Гэсэн хэдий ч цаг уурын өөрчлөлт, хүний сөрөг үйл ажиллагааны улмаас нийт нутаг дэвсгэрийн 72.3 хувь нь доройтолд орж, хөрсний шим тэжээл алдагдан, бэлчээрийн 70 гаруй хувьд бэлчээрийн даац хэтэрч, ургамлын ургалтын хэмжээ, найрлага бууран; олон зуун гол, горхи, байгалийн булаг, нуур, цөөрөм ширгээ, ойн нөөц 2 сая га-гаар буурч, 300 орчим зүйл амьтан, ургамал амьтан устах аюулд өртөж, цөлжилт улам бүр нэмэгдсээр байна. Иймээс байгаль орчны менежментийг олон улсын жишигт хүргэх, эрүүл, аюулгүй орчинд амьдрах хүний эрхийг хангах, хүрээлэн буй орчны нөхцөл байдал, экологийн тэнцвэрийг ирээдүй хойч үедээ бүрэн бүтэн үлдээх, нийгэм, эдийн засгийн ахиц дэвшил, хүрээлэн буй орчны тэнцвэрийг хадгалах замаар тогтвортой хөгжлийн зарчмыг баримтлах нэн тэргүүний зорилт тавьж байна.

Экологийн хувьд эмзэг газрууд: Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн (ТХГН) сүлжээ нь экологийн хувьд чухал ач холбогдолтой, экологийн хувьд эмзэг газар нутгуудыг хамруулсан байдаг. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь Монгол улсын нутаг дэвсгэрийн 17.4% (27.2 сая га талбай бүхий)-ийг хамруулсан 99 тусгай хамгаалалттай газар нутгаас бүрддэг. 1992 онд Монгол Улсын их Хурлаас нийт нутаг дэвсгэрийн 30 хувийг хамарсан тусгай хамгаалалттай газар нутгийн тогтолцоог бий болгох зорилтыг дэвшүүлсэн бөгөөд Тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөр (1998)-ийг баталснаас хойш тусгай хамгаалалттай газар нутгийн тоо, хэмжээ нэмэгдсээр байна. Одоогийн байдлаар улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээ нь дархан цаазат газар (12.4 сая га)-20, байгалийн цогцолборт газар (11.7 сая га)-32, байгалийн нөөц газар (2.9 сая га)-34, байгалийн дурсгалт газар (0.13 сая га)-13 зэрэг тусгайлсан хууль тогтоомж, үр ашигтай менежментээр зохицуулагддаг газруудаас бүрдэж байна.

Үүнээс гадна Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 10.4 хувийг буюу 16.3 сая га газар нутгийг хамарсан орон нутгийн тусгай хамгаалалттай 911 газар нутаг байна. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн нийт хэмжээ 44.3 сая га-д хүрч, нийт нутаг дэвсгэрийн 28.3 хувийг эзэлж байна (Монгол Улсын Засгийн газар 2015 он). Иймд Монгол Улсын Төрөөс тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн чадавх, хүчин чадлыг нэмэгдүүлэх, хамгаалагдсан газар нутгууд дахь хамгаалах үнэт зүйлс, биологийн олон янз байдлын амьдрах орчныг хадгалах, байгалийн нөөцийн зохистой ашиглалтыг дэмжин хөгжүүлэхэд ихээхэн анхаарч бодлого, хууль эрх зүй, санхүүгээр дэмжиж байна.³

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд бүх тусгай хамгаалалттай газар нутаг, орчны бүс (ОБ) -тэй байж болно гэж заасан байдаг. ТХГН-ийн

3

http://www.mn.undp.org/content/mongolia/en/home/operations/projects/environment_and_energy/SPAN.html

орчны бүсийн тухай Монгол лусын хуульд орчны бүс байгуулах, ОБ-ийн менежментийг хэрхэн зохицуулах асуудлыг тусгасан байдаг. Энэ хууль нь (i) хамгаалагдсан газрыг хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, (ii) орон нутгийн иргэдийн амьжиргааны орлогыг нэмэгдүүлэх, (iii) байгалийн нөөцийг зөв зохистой ашиглах замаар тухайн ТХГН-т учирч буй болон болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах, багасгах, урьдчилан сэргийлэх зорилготой. Одоогийн байдлаар дархан цаазат газар, байгалийн цогцолборт газруудад хуулийн дагуу орчны бүс байгуулж, энэ бүсэд байгалийн нөөцийн зөв зохистой тогтвортой ашиглалтыг дэмжин хөгжүүлж байна. Орон нутгийн ТХГ нь нутгийн иргэдийн санаачилга оролцоонд тулгуурласан хамгаалалт, зөв зохистой ашиглалтыг бий болгодог бөгөөд улсын тусгай хамгаалалттай газар нутагт хамрагдаагүй, экологийн хувьд чухал ач холбогдолтой газруудыг хамгаалахад хувь нэмэр оруулдаг.

Хүснэгт В.1 Монгол улсын тусгай хамгаалалттай газар нутгуудын жагсаалт

№	ТХГН-ийн нэр	ТХГН-ийн байрлаж буй аймагууд	Ангилал	Хэмжээ (га)
1	Их Говийн их ДЦГ /Б/	Баянхонгор	ДЦГ	927111.8222
2	Алаг хайрхан	Говь-Алтай	БЦГ	36723.16831
3	Их Говийн ДЦГ /А/	Говь-Алтай, Баянхонгор	ДЦГ	4633299.775
4	Ээж хайрхан	Говь-Алтай	ДГ	23095.9647
5	Хөх сэрхийн нуруу	Баян-Өлгий, Ховд	ДЦГ	75749.75203
6	Чигэртэйн голын ай сав	Баян-Өлгий	БЦГ	167190.6466
7	Богдхан уул	Төв	ДЦГ	41322.27316
8	Хасагт хайрхан	Говь-Алтай	ДЦГ	26760.57436
9	Монгол Элс	Говь-Алтай	БЦГ	271313.4184
10	Нөмрөг	Дорнод	ДЦГ	320982.1815
11	Дорнод Монгол	Дорнод	ДЦГ	589905.6506
12	Монгол дагуур /А/		ДЦГ	92880.45414
13	Монгол дагуур /Б/		ДЦГ	15273.1854
14	Яхь нуур		БНГ	251217.9575
15	Угтам		БНГ	46022.85092
16	Тосон хулстай	Дорнод, Хэнтий	БНГ	458509.7875
17	Увс нуур	Увс	ДЦГ	441223.2166
18	Цагаан Шувуут		ДЦГ	25537.7004
19	Түргэн уул		ДЦГ	130473.9754
20	Хан хөхий		БЦГ	221598.2789
21	Хяргас нуур	Увс Завхан	БЦГ	341301.7869
22	Алтан Элс		ДЦГ	150244.2014
23	Отгонтэнгэр уул		ДЦГ	90498.66441
24	Улаагчины хар нуур	Завхан	БЦГ	259403.3884
25	Цамбагарав	Баян-Өлгий	БЦГ	113749.2134
26	Алтай таван богд	Баян-Өлгий Архангай, Өвөрхангай Баянхонгор	БЦГ	656106.3865
27	Сийлхэмийн нуруу /А/		БЦГ	69935.4433
28	Сийлхэмийн нуруу /Б/		БЦГ	77942.5287
29	Дэвэлийн арал		БНГ	10618.72285
30	Хангайн нуруу		БЦГ	906604.5447
31	Хорго-Тэрх цагаан нуур	Архангай	БЦГ	76893.00337
32	Ноён хангай	Arkhangai	БЦГ	56657.98638
33	Онон - Балж /А/	Хэнтий	БЦГ	294079.7835
34	Онон - Балж /Б/	Хэнтий	БЦГ	106386.9926
35	Хар ямаат		БНГ	50690.8984

36	Өндөрхаан уул	Булган, Өвөрхангай	БЦГ	8820.03332
37	Хөгнө Тарна	Булган, Өвөрхангай Сүхбаатар	БЦГ	84143.05686
38	Дарьганга		БЦГ	64547.60536
39	Шилийн богд		ДГ	18136.91995
40	Хөргийн хөндий	Төв	ДГ	6104.313042
41	Хустайн нуруу	Төв	БЦГ	48400.56794
42	Говь гурван сайхан	Өмнөговь, Өвөрхангай	БЦГ	2697170.845
43	Хан Хэнтий	Төв, Сэлэнгэ, Хэнтий Төв	ДЦГ	1748103.891
44	Горхи - Тэрэлж		БЦГ	291838.556
45	Нагалхаан уул		БНГ	1860.721221
46	Хар ус нуур	Ховд	БЦГ	852997.2452
47	Манхан		БНГ	82807.37429
48	Тарвагатайн нуруу	Завхан	БЦГ	547629.8987
49	Говийн бага /А/	Өмнөговь	ДЦГ	1147812.066
50	Говийн бага /Б/	Дорноговь, Өмнөговь	ДЦГ	682617.3514
51	Их Богд уул	Баянхонгор	БЦГ	262855.8119
52	Заг Байдрагийн голын эхэн сав	Дорноговь, Өмнөговь	БЦГ	116308.5428
53	Тужийн нарс	Сэлэнгэ	БЦГ	70804.71976
54	Орхоны хөндий	Архангай, Өвөрхангай	БЦГ	92717.98585
55	Хүйсийн найман нуур	Архангай	ДГ	11149.06413
56	Их газрын чулуу	Дундговь	БНГ	175906.1387
57	Хөвсгөл	Хөвсгөл	БЦГ	1175602.174
58	Даяндээрхийн агуй	Дундговь	ДГ	31277.20524
59	Улаан тайга	Хөвсгөл	ДЦГ	431694.4634
60	Хорьдол сарьдаг		ДЦГ	226672.0417
61	Тэнгис-Шишгэд	Хөвсгөл Булган Ховд	БЦГ	875711.2729
62	Зэд-Хантай-Бүтээлийн нуруу		ДЦГ	604265.563
63	Мянган-Угалзат		БЦГ	303775.0681
64	Булган гол-Их Онгог	Ховд	БЦГ	92743.66388
65	Мөнххайрхан уул- Үенчийн хавцал	Ховд	БЦГ	506096.7014
66	Их Нарт	Дорноговь	БНГ	66752.0
67	Хар Ямаат	Дорнод	БНГ	50691.0
68	Их Говийн их ДЦГ /Б/	Баянхонгор	ДЦГ	927111.8222
69	Алаг хайрхан	Говь-Алтай	БЦГ	36723.16831

В.1 Байгаль орчны өнөөгийн байдал ба тулгамдсан асуудлууд

Агаарын чанар нь манай улсын томоохон хотууд болон аймгийн төвүүдийн байгаль орчны тулгамдсан асуудал болоод байна. Агаарын бохирдлын анхдагч эх үүсвэр болох дулааны цахилгаан станцууд, жижиг дунд оврын халаалтын зуух, уламжлалт халаалт бүхий гэр, байшин, 40000 гаруй автомашин агаарын бохирдол үүсгэсээр байна. Газрын гадаргын болон байгаль, цаг уурын эрс тэс нөхцөл байдал нь хүрээлэн буй орчны болон ялангуяа Улаанбаатар хотын орчны агаарын чанарын төлөв байдалд нөлөөдөг ба үүний үр дүнд хүрээлэн буй орчныг бохирдуулагч бодисын агууламж Монгол болон бусад олон улсын агаарын чанарын стандартын зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрсэн хэвээр байсаар байна. Хот суурин газрын гэр хорооллуудад түүхий нүүрс, бусад шатах боломжтой зүйлсийг их хэмжээгээр хэрэглэсээр байгаа нь агаарын бохирдлыг нэмэгдүүлж орчны агаарын чанар, хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж байна.

Усны хомсдол ба бохирдол: Усны хомсдол нь Монгол Улсын нийгэм, эдийн засаг, экологийн томоохон асуудлын нэг болж байна. Монгол орны хойд хэсэгт

гадаргын усны үндсэн нөөц эх үүсвэр болох гол мөрөн нуур элбэг боловч төвийн болон өмнөд хэсэгт болон хот суурин газар, ялангуяа Улаанбаатар хотод үйлдвэрлэл, үйлчилгээ эрчимтэй хөгжиж ус хангамжид зөвхөн газрын доорх усны эх үүсвэрийг ашиглаж байгаа нь байгаль орчин, эдийн засгийг тэнцвэртэй хөгжүүлэхэд ноцтой саад учруулж байна.

Улсын хэмжээнд бэлчээрийн ус хангамж, ус ашиглалтад анхаарал бага хандуулж байна. 1960-аас 1990 оны хооронд бэлчээрийн ус хангамж сайжирч нийт бэлчээрийн 60 гаруй хувийг усаар хангаж олон худаг гаргасан боловч одоогийн байдлаар тэдгээр 48000 худгийн дөнгөж 40 хувь нь л ажиллаж байна. Социализмын үед өрөмдөж гаргасан ихэнх худгууд эвдэрч ажиллагаанаас гарсан байна.

Арьс шир боловсруулах үйлдвэр, ахуйн, хог хаягдал, бохир ус зайлуулах шугам зэргээс үүдэн хүн ам, үйлдвэрлэл төвлөрсөн газруудын ойролцоох гол мөрөн, ялангуяа Туул, Ерөө, Сэлэнгэ, Орхон голуудын бохирдол ихсэж байна. 2002 оны байдлаар нийт бохир ус цэвэрлэх 102 байгууламжийн зөвхөн 35 нь л ашиглагдаж байгаа гэсэн баримт байна.

Бохирдлын эх үүсвэрт зөвхөн ахуйн хаягдлын бохирдлоос гадна арьс ширний боловсруулалтад ашигладаг хромын агууламж өндөр байгаа нь байдал хүнд байгааг харуулж байна.

Монгол Улсад бүртгэлтэй 5500 гол, 9600 горхи, 300 халуун рашаан, 4000 нуур, 30000 худаг байдаг хэдий ч 2000 оны тооллогоор 3000 гол, горхи ширгэж, 1200 худаг эвдэрч муудсан, буюу ашиглалтгүй болсон мэдээ байдаг. Үүний үр дүнд усны нөөц хомсдож ус хангамж муудсан байна.

Газрын доройтол: Мал аж ахуй эрхлэх уламжлалт арга өөрчлөгдсөн, газар тариалангийн хэт их ашиглалт, байгалийн нөөцийг хэтрүүлэн ашиглах, уур амьсгалын өөрчлөлттэй зэрэгцэн экосистемд дарамт үзүүлэх бусад эх үүсвэрүүд нь зэрлэг ан амьтны амьдрах орчин доройтох, тархац хүрээ багасаж ан амьтдын тоо цөөрөхөд хүргэж байна. Монгол Улсад газрын доройтлын шалтгааныг хүний үйл ажиллагааны болон байгалийн гэж хоёр төрөлд хуваан ангилж болно.

Байгалийн нөлөөлөлд 2-3 жилийн давтамжтай болж байгаа ган, байгалийн хуурайшилт, хөрсний чийгийн хомсдол, хавар, намрын хүчтэй салхи, шороон шуурганд хөрсний үржил шимтэй нимгэн давхарга хийсэж хөрсний найрлага өөрчлөгдөх зэрэг орно.

Хүний хүчин зүйлд уул уурхайн үйлдвэрлэл ба газар тариалангийн хурдацтай хөгжил, уламжлалт мал аж ахуйн өөрчлөлт, бэлчээрийн даац хэтрүүлэх, ялангуяа суурин газар болон уст цэгийн орчин тойронд үүсдэг талхлалын үр дагавар орно.

Хатуу хог хаягдлын хор уршиг: Манай улсад хатуу хог хаягдлыг хот, суурин, сумын төвийн ойролцоо задгай агаарт хаядаг. Эдгээр хог хаягдал тархаж, хөрсний бохирдолд ихээр нөлөөлдөг учир анхааралдаа авах нь зүйтэй. Ялангуяа Улаанбаатар, Эрдэнэт, Дархан хотуудад хот тэлэлт ба хот төлөвлөлт хоёрын хооронд маш том ялгаа байна. Түүгээр ч зогсохгүй сайн төлөвлөлтийн төсөл байхгүй. Зуны улиралд гэр ахуйн хог (33.8%), цаас (18.9%), хуванцар (15.2%) байдаг харин үнс нь өвлийн улиралд 60.2% -ийг эзэлдэг.

Манай улсад хог хаягдлыг цэвэрлэх боловсруулах шаардлага хангасан байгууламж байдаггүй. Тиймээс хог хаягдлыг хот суурин газарт хаядаг. Ялангуяа Улаанбаатар хотод хог хаягдлын ноцтой асуудал тулгарч байна. Хотын захиргааны байгууллагаас итгэмжлэгдсэн иргэний аж ахуйн нэгжийн өмчит компаниуд хотын хог хаягдлыг боловсруулах, устгах ажлуудыг гүйцэтгэж байна.

Үйлдвэр, худалдааны байгууламж, барилгын талбайгаас үүссэн хатуу хог хаягдлыг гуравдагч талын агентлагууд цуглуулдаг. Гэсэн хэдий ч хэт их хэмжээгээр үүссэн хатуу хог хаягдал нь хог хаягдлыг цуглуулах багтаамжаас хэтэрсэн байдаг.

Биологийн олон янз байдал алдагдах: Хүн амын өсөлт болох хотжилт, эдийн засгийн хөгжил, байгалийн баялгийн нэг хүнд ноогдох хэрэгцээ нэмэгдэж байгаа нь газар болон байгалийн нөөцөд асар их дарамтыг учруулж байна. Үүний зэрэгцээ, төвлөрсөн эдийн засгаас чөлөөт зах зээлийн эдийн засагт шилжсэн нь улс орны байгалийн баялгийг хувийн аж ахуй нэгжүүд, зах зээлийн бусад оролцогчдод нээлттэй болгосон. Уул уурхай, газар тариалан, мал амьтны аж ахуйгаас гаралтай бүтээгдэхүүн үйлдвэрлэх зэрэг эдийн засгийн өргөжилт нь байгалийн өвөрмөц бүс нутаг, ан амьтдын амьдрах орчин алдагдахад хүргэж байна. Хяналтгүй, хууль бус ан агнах, араатан амьтдыг их хэмжээгээр устгах хөтөлбөрүүд нь зэрлэг амьтдын болон байгалийн тэнцвэрт байдалд нөлөөлдөг.

В.2 Нийгмийн Суурь Мэдээлэл

Хүн ам: Монгол Улс дэлхийн хамгийн сийрэг хүн амтай орны тоонд тооцогддог бөгөөд 2017 оны байдлаар хүн амын тоо 3,177,899 байсан бөгөөд дундаж өсөлт нь 1.9% байна. Нийт хүн амын 67.5 орчим хувь (2,146,716) хотод амьдардаг бөгөөд үүний 68 орчим хувь (1,462,973) нь нийслэл Улаанбаатар хотод амьдардаг. Хөдөө орон нутагт хүн амын нягтрал нэг км квадрат тутамд 0.5 хүн амьдардаг бөгөөд энэ нь улс даяар орон нутагт бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн амьжиргаа түлхүү эзэлж байгааг харуулж байна. Хөдөө орон нутагт хүн амын нягтрал нэг км квадрат тутамд 0.5 хүн амьдардаг бөгөөд энэ нь улс даяар орон нутагт бэлчээрийн мал аж ахуйд түшиглэсэн амьжиргаа түлхүү эзэлж байгааг харуулж байна. Сүүлийн жилүүдэд хөдөө орон нутгаас хот газар руу шилжих хөдөлгөөн нэмэгдэж, сүүлийн 10 жилийн турш жилд дунджаар 20,000 орчим хүн шилжсэн нь Улаанбаатар хотын хүн амыг нэмэгдэхэд хүргэсэн. Одоогийн байдлаар Улаанбаатарт нийт хүн амын 40 хувийг суурьшин амьдарч байна. 2030 оны тооцоологдож буй хотын хүн ам 1.87 сая буюу 2008 оны хүн амаас 1.7 дахин их байна.

Уугуул иргэд, ястан, нийгмийн цөөнх бүлэг: Монгол улс нь нутгийн уугуул иргэдийн талаар ямар нэгэн тодорхой бодлого байхгүй ч гэсэн 1992 онд батлагдсан Үндсэн хуулийн 2-р бүлгийн 14-р зүйлд, “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна.” гэж заасан байдаг. Одоогийн байдлаар Монголд 30 орчим ястан байгаа бөгөөд Турк гаралтай Монголжсон зарим нэг үндэстэн байдаг. Монгол улсын хүн амын олонх нь буюу 84.5% нь Халх буюу нутгийн уугуул иргэд бөгөөд нь 3.9% нь Казак, 2.4% нь Дөрвөд, 1.7% нь Баяд, 1.3% нь Буриад, үндэстэн юм. Хэдий Монгол орны

үндэстэн ястны бүхий л бүлгүүд Монгол хэлээр ярьдаг боловч, зарим нэг нь өөрсдийн онцлог хэллэг, аялга, соёл, зан заншилтай бөгөөд энэ нь Монгол үндэстний нэгдмэл байдлыг харуулж байна. Үндэстэн ястнуудаас зөвхөн Казак үндэстэн өөрийн Казак хэлээр ярьж бичдэг ба хүн амын ихэнх нь Мусульман шашинтай. Үндэстэн ястны цөөнх болох цаа буга маллан амьдардаг Цаатнууд Хөвсгөл аймгийн Цагаан нуур суманд амьдардаг. Гэхдээ эдгээр үндэстний цөөнх болсон үндэстэн ястнууд нь эдийн засаг, нийгэм хууль эрхзүйн хувьд ялгаварлалд өртөгдөөгүй ба харин төслийн үйл ажиллагаанд оролцох чадамжаар дутмаг байж болох талтай. Иймд ҮЦОДТ-өөг Цаатан болон Казак үндэстний оролцоог дэмжих зорилгоор боловсруулан хэрэглэх болно.

Нийгмийн суурь судалгааны явцад хийсэн Олон нийтийн зөвлөлдөх уулзалтын явцад ТА-3 төслийн Нэмэлт Санхүүжилтийн хүрээнд төсөлд хамрагдах хүмүүст ямар нэг сөрөг нөлөөлөл учрахгүй гэж дүгнэж байсан. Гэхдээ Цаатан болон Казак хүмүүсийн зан хандлага нь төслийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, төслөөс ашиг хүртэх боломжийг хязгаарлаж магадгүй юм.

Цаатан ардууд:

Цаатнууд Хөвсгөл аймгийн Цагаан нуур суманд амьдардаг. Цагааннуур сумын нийт хүн ам 2019 онд 1995 байсан бөгөөд 901 нь төвийн багт, 1077 нь алслагдсан багт амьдардаг. Цаатнууд сумын төвийн оршин суугчдын 16.8%-ийг, алслагдсан багийн оршин суугчдын 34.7%-ийг эзэлж байна. 85 өрхийн (2013 онд 80) 335 цаатан иргэн Тайгын ойд цаа бугаа түшиглэсэн уламжлалт уулын амьдралын хэв маягаар амьдарч байна.

2017 оны мал тооллогоор нийт 2159 цаа буга тоологдсон байна. Цаатнууд байршлаараа “зүүн” ба “баруун” гэсэн үндсэн 2 отогт хуваагддаг. Сумын төв суурин, нам дор газар амьдардаг цаатнууд нь үндсэндээ Дархад ястнуудаас онцын ялгаагүй байдалтай амьдардаг.

Амьжиргааны үндсэн орлого нь цаа буга бөгөөд цаа бугын мах, сүү, арьс ширийг амьжиргаандаа хэрэглэж цаа буныг уналга болгон ашигладаг.

Цаатнууд тооны хувьд цөөн төдийгүй, амьдралын уламжлал, зан заншлаа алдсаар байгаа бөгөөд ядуурал, газар зүйн байршлын болон эдийн засгийн хувьд хязгаарлагдмал байдалтай байна. Түүнчлэн цаа бугын тоо толгой, өсөлт, ашиг шим, эрүүл мэнд буурсаар байгаа учраас онцгой эмзэг байдалтай болж байна.

ТА-3 төслийг хэрэгжүүлэх үеэр төслийн багийн гишүүд⁴ Орон нутгийн хөгжлийн сангийн болон ТА-3 төслийн үйл ажиллагааг танилцуулах, мэдлэг олгох, эрүүл мэнд боловсрол, амьжиргаатай холбоотой тэдний хэрэгцээний талаар хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах зорилгоор тайгад ажиллаж цаатан ард түмэнтэй уулзсан.

Энэ үеэр хөнгөлөлттэй үнээр зарагддаг эм хүрэлцээ муутай байдаг талаар өндөр настнууд дурдаж байлаа. Цаатнууд цаа бугын өвчний эмчилгээ үйлчилгээ, үржлийг сайжруулах зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар цааны тоо толгойг буурч байгаа байдлыг зогсоох, мал эмнэлэг, үржлийн мэргэжлийн туслалцаа хэрэгтэй байгааг илэрхийлж байв. Сумтай холбогдох харилцаа холбооны байдал ч бас авч үзэх асуудал байсан.

Цаатан иргэд Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжүүлэх дэд төсөл гэж үзэж болох өдөр тутамдаа тулгарч байгаа бэрхшээлийг тодорхойлох мэдлэг чадвар дутмаг учраас өөрсдийн хэрэгцээгээ илэрхийлэх чадваргүй байна.

⁴ 2019 оны 6 сар.

Үндэсний цөөнх иргэдийн оролцоог дэмжих тус төлөвлөгөөний заалтууд нь юуны түрүүнд баруун болон зүүн тайгын ойд амьдардаг алслагдсан цаатнуудад хамааралтай.

Казак үндэстэн:

Монгол Улсын хүн амын 3.9% -ийг эзэлж буй Казахууд нь хамгийн том Үндэсний цөөнх юм. Өөр хэл, лалын шашны итгэл үнэмшил нь Казак болон Монгол бусад ястнуудын хоорондох үндэстний ялгаатай байдлыг харуулж байгаа боловч Казак иргэдийн амьжиргаа эдгээр Монгол ястнуудаас төдийлөн ялгарахгүй.

Орон нутгийн статистик мэдээллээр (Баян-Өлгий аймаг ,2012) Казак иргэд Баян-Өлгий аймагт ойролцоогоор 75.6% , Ховд аймагт 8.9% , Дархан-Уул аймагт 2.4% , Төв аймагт 0.9%, Орхон аймагт 0.6%, Хэнтий аймагт 0.5% нь амьдарч байна. Казак иргэдийн төвлөрөл өөр газар төдийлөн байхгүй учраас Үндэсний цөөнх иргэдийн оролцоог хангах/дэмжих тус хөтөлбөр эдгээр хоёр аймагт хамааралтай.

Баян-Өлгий, Ховд аймагт амьдардаг ихэнх казахууд төслийн үйл ажиллагаанд оролцох хэмжээнд мэргэжлийн түвшинд Монгол хэлээр ярьж, уншиж чаддаггүй. Казак иргэдийг Орон нутгийн хөгжлийн сангийн тухай зохих мэдээллээр хангах, үүний үйл явцад оролцуулах, сумын тамгын газрын мэргэжилтнүүдэд, казах иргэдэд ТА-3 төслийн жилийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгийн талаарх мэдээллийг Монгол, Казак хэлээр бичгээр болон амаар сурталчлан түгээх , ойлголтыг нэмэгдүүлэх нөхцөл бүрдүүлэх зайлшгүй шаардлагатай байна.

Г. Байгаль Орчин, Нийгмийн Хамгааллын Менежментийн Төлөвлөгөө

Сангийн Яамны ТХН нь ТА-3 төслийн Нэмэлт Санхүүжилтийн төслийн БОНХМТ-г хэрэгжүүлэх, зохион байгуулах, гарч болзошгүй байгаль орчин, нийгмийн эрсдлийг зохицуулах үүрэгтэй. Ялангуяа, БОНХМТ-нд тусгасан үйл ажиллагаа, журмуудыг хэрэгжүүлэхэд Дэлхийн банкны хамгааллын бодлого, Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, зөвшөөрлийн болон бусад зохицуулалтын тогтолцоо, шаардлагад нийцүүлж байгаа эсэхэд мониторинг хийх үүрэгтэй.

Өмнөх хугацаанд хэрэгжүүлсэн төслийн үр дүнгээс харахад, төслийн хүрээнд байгаль орчинд нэлээд өргөн хүрээтэй эерэг үр нөлөө үзүүлсэн байна. Гэхдээ, нэмэлт санхүүжилтийн хүрээнд хэрэгжих төсөл нь газарзүйн хувьд өргөн уудам нутаг дэвсгэрийг хамрах байдал, бодлого, зохион байгуулалтын хөгжилд үзүүлэх ач холбогдлоороо өмнөх төсөлтэй ижил нөлөөтэй байх ба экологийн хувьд эмзэг газар нутаг, усны нөөцөд үзүүлэх нөлөө эрсдэл байх боломжтой. Ялангуяа, төсөл нь газрын доройтол бий болгох, газрын элэгдэл, төслийн хүрээнд засварласан буюу шинээр гаргасан худаг уст цэг, ус хуримтлуулах байгууламжийг зүй зохисгүй ашиглах, тэдгээрийн орчинд малын хэт төвлөрөл бий болохтой холбоотойгоор биологийн олон янз байдал болон усны эх сав газар, түүнчлэн гадаргын болон гүний ус бохирдох зэрэг сөрөг нөлөөлөл үүсэх магадлалтай. Мөн гүний усыг хэт их ашигласнаас худаг уст цэгүүдээс газрын доорх усны ундаргад хуримтлагдсан нөлөөлөл үзүүлж магадгүй юм. Хэдийгээр, малын тархцыг тогтвортой байлгахыг чухалчлах боловч малчид мал сүргийн тоо толгойг нэмэгдүүлэх эрсдэл байж болзошгүй. Малын тоо толгой өсөх нь байгаль орчинд нөлөөгүй мэт боловч, малын тархцыг тогтвортой зөв зохистой хэмжээнд хянахгүй, нэг дор хэт олон мал төвлөрүүлснээр газрын талхагдал ихсэх, биологийн олон янз байдал алдагдах, усны эх сав газар доройтох байдал бий болно.

Төслийн нийгмийн суурь судалгааны явцад хийсэн Олон нийтийн зөвлөлдөх уулзалтын явцад ТА-3 төслийн Нэмэлт Санхүүжилтийн хүрээнд төсөлд хамрагдах хүмүүст ямар нэг сөрөг нөлөөлөл учрахгүй гэж дүгнэж байсан. Гэхдээ Цаатан болон Казак хүмүүсийн зан хандлага нь төслийн үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, төслөөс ашиг хүртэх боломжийг хязгаарлаж магадгүй юм. Иймд төслийн нийгмийн хамгааллын менежмент нь Цаатан болон Казак иргэдийн асуудалд төвлөрөх ба энэ талаар авч хэрэгжүүлэх нарийвчилсан үйл ажиллагаануудыг ҮЦОДТ-өөнд тусгасан болно.

Г.1 Нэмэлт Санхүүжилтийн төслийн хүрээнд хэрэгжих магадлалтай дэд төсөл, үйл ажиллагаа

2013-2016 онд ТА-3 төслийн хүрээнд нийт 20800 дэд төсөл ОНХС-аас дэмжлэг авч хэрэгжсэнээс 583 төсөл буюу нийт төслийн 3%-ийг БОНБЕУ хийх шаардлагатай төслүүд эзлэж байна. Эдгээр төслүүдийг төрлөөр ангилвал:

- жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх 4 төсөл,
- цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж байгуулах сайжруулах 181 төсөл,
- хог хаягдалын нэгдсэн цэг байгуулах, тохижуулах чиглэлийн 83 төсөл,
- бохир ус цэвэрлэх байгууламжийн 29 төсөл,
- ус хуримтлуулах сан байгуулах, засварлах чиглэлийн 33 төсөл,
- цахилгаан дулаан дамжуулах шугам, эрчим хүчний станц байгуулах 198 төсөл байна.

Г.2 Байгаль Орчин, Нийгэмд Учирч Болзошгүй Нөлөөлөл

ТА-3 төслийн баримт бичгийг нягтлан үзэж, орон нутгийн засаг захиргааны удирдлагууд, малчид, төслийн оролцогч талуудын төлөөлөгчидтэй хийсэн ярилцлагын үр дүнгээс харахад ТА-3 төслийн Нэмэлт Санхүүжилтийн хүрээнд дэд төслүүдээр дамжуулан хэрэгжүүлэх үйл ажиллагаанууд нь биофизикийн орчинд эерэг нөлөө үзүүлэх боловч барилга, засварын ажлаас сөрөг нөлөөлөл үүсч болзошгүй гэж тайлбарласан. Үүсч болзошгүй нөлөөллийг тодорхойлж Г.1-р хүснэгтээр харуулсан болно.

Хүснэгт Г.1. Хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас үүсэх эерэг ба сөрөг нөлөөлөл

Бүрэлдэхүүн	Төслийн хүрээнд хэрэгжүүлэх боломжтой дэд төсөл, үйл ажиллагаа	Биофизикийн орчин				Нийгэм эдийн засгийн нөхцөл байдал			Хөдөлмөрийн нөхцөл, аюулгүйн байдал	
		Зэрлэг ан амьтан	Ус судлал	Ургамал ба хөрс	Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох	Амьдралын тогтвортой байдал	Байгалийн нөөцөд хүрч ашиглах	Уугуул ард иргэд	Хөдөлмөр эрхлэлтийн нөхцөл байдал	Хөдөлмөрийн аюулгүйн байдал
ҮҮ Н ХЭ СГ ИЙ	1.1 Бэлчээр, хадлангийн талбайг хаших	-	+	+	+	+	-	+/-		
	1.2 Мал угаах байгууламж барих ажиллуулах.		-	-	-	+		+		

	1.3 Шинээр худаг гаргах ашиглах	-	-	-	+	+	+	+/-		
	1.4 Хуучин худаг засварлах, ашиглах	-	-	-	+	+	+	+/-		
	1.5 Усны эх булгийг хашиж хамгаалах	-	+	+	+	+	-	+/-		
	1.6 Мал үржүүлэг, хээлтүүлгийг хашаа барих	-		-	+/-	+	-			
	1.7 Сайжруулсан үүлдэр угсааг нэвтрүүлж, малчдыг сайн үүлдрийн бүх, хуцаар хангах, зохиомол хээлтүүлгийн (ЗХ) чадавхийг сайжруулах.	+			+/-	+	+/-	+		
ОНХС-аас санхүүжүүлэх үйл ажиллагаа	2.1 Олон нийтийн үйлчилгээний байгууламжуудыг засах сайжруулах (сүргүүл, эмнэлэг, дотуур байр, багийн төв, соёлын төв гэх мэт)					+		+	+	+
	2.2 Давааны зам засах, гүүр засварлах барих	-	+/- -	+	+	+	+	+/-	+/-	
	2.3 ЖДҮ-ийн болон бага оврын боловсруулах цех байгуулах, ажиллуулах.		+/ -	+/ -	+	+	+	+/-	+	+/-
	2.4 Ус хуримтлууца цөөрөм, бэлчээр болон ногоо услах системийг сайжруулах.	+	+/ -	+	+	+	+	+/-	+/-	+/-
	2.5 Цахилгаан дамжуулах шугам, дэд станц барих.	+/ -		+/ -	+/-	+	+	+	+	+/-
	2.6 Сумын төвийн халаалтын зуух, систем барих, засварлах.				+/-	+			+	+
	2.7 Сумын төвд бохир ус цэвэрлэх байгууламж барих, засварлах.		+/ -	+	+	+			+	+/-
	2.8 Олон нийтийн зам талбайг тохижуулах, цэцэрлэгт хүрээлэн байгуулах.	+	+	+	+					+
	2.9 Хог хаягдлын цэгийг байгуулах, тохижуулах.	-	+/ -	+/ -	+/-				+	

Тайлбар: (+) : Эерэг нөлөө, (-) : Сөрөг нөлөө

Төслийн хүрээнд хэрэгжүүлэх барилгын ажлуудад олон нийтийн үйлчилгээний байгууламжуудыг засварлах, мал угаах байгууламж барих, бэлчээр, хадлангийн талбайг хаших, цахилгаан дамжуулах шугам тавих, усан сан байгуулах, нийтийн эзэмшлийн зам талбай тохижуулах, ногоон байгууламж цэцэрлэгт хүрээлэн байгуулах гэх мэт үйл ажиллагаанууд хамрагдах ба энэ хүрээнд газар ухах, барилга байшин барих, засварлах, суурь цутгах, бетон арматуурын ажил хийх, тоног төхөөрөмж суурилуулах, угсрах, талбайг тэгшлэх, шаардлагатай бол мод тарих, хөрс нөхөн сэргээх зэрэг үйл ажиллагаа хийгдэнэ. Төслийн хүрээнд бий болгосон байгууламжуудыг ашиглах үед барилгын ажлын үед гарсан нөлөөллүүдийг арилгасан байх ба тухайн байгууламжийг ашиглах, засвар үйлчилгээ хийхтэй холбоотой үүсэх сөрөг нөлөөллүүдийг тооцон урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах ёстой.

Төслийн хүрээнд бий болгосон байгууламжуудыг ашиглах үед ашиглалт засвар үйлчилгээг зөв зохистой эрхлээгүйгээс үүдэн дараах үндсэн нөлөөллүүд бий болох магадлалтай:

- Бордоо, цэвэрлэгээ ариутгалын бодис хадгалах зориулалтын агуулах байхгүй, тусгаарлагдаагүй ил газарт эдгээр бодисуудыг хадгалснаас үүдэн хүрээлэн буй орчин (агаар, хөрс, ус)-ны бохирдол үүсгэх аюултай.
- Шинээр гаргасан болон засварласан худгийг зөв зохистой ашиглахгүй тохиолдолд тэдгээрийн орчинд хөрсний элэгдэл үүсч болзошгүй бөгөөд ургамлын бүрхэвч, устах аюулд орж болзошгүй юм.
- Бэлчээрийн хомсдол, хадлангийн талбайн доройтол үүсч байгаль орчны шинж чанар алдагдах

- Худаг уст цэгийн эргэн тойронд малын ялгадас/аргал, хоргол гэх зэрэг хог хаягдал нэмэгдснээр метан ялгаруулалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлнө.
- Бага оврын боловсруулах үйлдвэр/цехээс гарах бохир уснаас хөрс, гадаргын усыг бохирдох
- Усны нөөцийг зохисгүй буруу хэрэглэснээс үүдэн бичил цаг уурын өөрчлөлт
- Усан хангамжийн байгууламжийг сайжруулах явцад усны нөөцөд үзүүлэх нөлөө (жишээ нь, малын тэжээл, хүнсний ногооны талбайг услах зорилгоор хөрсний/гүний худгийг ухах);
- Худгийн зохисгүй ашиглалтын улмаас худаг орчмын бэлчээрийн доройтол, хөрс, хүрээлэн буй орчны бохирдол үүснэ
- Худаг хэрэглэгчид болон бусад хөрш зэргэлдээ малчдын хоорондох зөрчилдөөн нэмэгдэх
- Мал угаах байгууламжид ариутгалын бодисын зохисгүй хэрэглээнээс болж хөрс, гадаргын усны бохирдол нэмэгдэх
- Хатуу хог хаягдал нэмэгдэх
- Бэлчээрийн менежмент, хадлан бэлтгэх талбайг хашаа барих ажлыг буруу зохион байгуулвал төсөлд хамрагдаж буй малчид ба төсөлд хамрагдаагүй малчдын хооронд зөрчилдөөнийг үүсэх

Г.3 Байгаль Орчин Нийгмийн Нөлөөллийг Бууруулах Арга Хэмжээ

Ашиглалтын үед үүсэх аливаа нөлөөллийг бууруулах асуудал нь барилга байгууламжуудын хийц төлөвлөлтөөс хөмөөрнө. Иймд: (i) ОНХС-ийн дэмжлэгтэй хэрэгжих барилга байгууламжуудын хийцийн зураг төсөлүүд нь Монгол улсын Засгийн газраас гаргасан холбогдох журам, стандартад нийцсэн, эрчим хүчний хэмнэлттэй байх, аюулгүйн нөхцөл хангасан байх, ялангуяа MNS 3838: 2008 ба Барилгын стандартын багц # 91.040-д нийцсэн байх; (ii) барилга байгууламжид доторх агаарын чанарын шаардлага хангахын тулд сайн чанартай, органик дэгдэмхий бодис хамгийн бага хэмжээгээр агуулсан материал (будаг, дулаалга, хивс, тавилга гэх мэт) хэрэглэх. Барилгын хананд усан суурьтай, хоргүй, харшил үүсгэдэггүй будаг, шал гэх мэт гадаргууд тосон суурьтай будагхэрэглэх; (iii) уурын зуухны халаалтын тогоо нь агаарын бохирдлоос хамгаалах шаардлага, (MNS 5457:2005) хангасан техникийн үзүүлэлттэй байх.

Хүснэгт Г.2 Төслийг хэрэгжүүлэх болон барилгын ажлын үе шатанд үүсэх Байгаль Орчин, Нийгмийн нөлөөлийг бууруулах арга хэмжээ

Төслийн үйл ажиллагаа	Тохиолдож болзошгүй нөлөөлөл	Нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Стандартууд	Хариуцах тал	Хэрэгжүүлэлтийн хуваарь
1.1, 1.5 болон 1.6, Бэлчээр, хадлан тэжээлийн талбай, худаг, булаг шандыг хаших	Зэрлэг ан амьтны шилжилт хөдөлгөөнд саад учруулах	<ul style="list-style-type: none"> • Хаших талбайн урт, өргөнийг 100м-ээс ихгүй байх, өргөст тор ашиглахыг хориглох • Хаших тайлбайн байршлыг багын хурлаар батлуулж гэрээ байгуулах 	Харж шалгах	БОБ-ын хяналтан дор нөхөрлөлүүд, багын засаг дарга	Барилгын ажлын үед
1.2 Мал угаах байгууламжийг барьж ашиглах.	Мал угаах Байгууламж болон ариутгалын бодисыг буруу ашигласнаас үүдэн хөрс болон гадаргын ус бохирдох	<ul style="list-style-type: none"> • Малыг хэт бөөгнөрөлөөс сэргийлж мал угаах байгууламжийн ашиглалтын цагийн хуваарийг олон нийтэд урьдчилан мэдэгдэх • Мал угаах 	Жилд хоёр удаа харж шалгах	Сумын Хөдөө Аж Ахуй Мал Эмнэлгийн Тасаг, Багийн засаг дарга	Төсөл хэрэгжих хугацаанд, жилд хоёр удаа

		байгууламжид болон хүрээлэн буй орчинд хохирол учирахаас сэргийлэн мэргэжлийн туршлагатай мал эмч нарыг ажиллуулах			
		<ul style="list-style-type: none"> • Бохирдол үүсэх болон олон нийтэд хүндрэл учирахаас даруй сэргийлж байгууламж болон орчин тойрны газрыг цэвэрлэж, нөхөн сэргээх 			
1.3,1.4 Хуучин худгийн үйл ажиллагааг сэргээж, шинээр худаг байгуулаж ашиглах	Худгийн зохисгүй менежментээс үүдэн хөрсөнд сөрөг нөлөө бий болох, хөрсний элэгдэл үүсэх	<ul style="list-style-type: none"> • Худаг ашиглах, засварлах болон худгийн зохистой хэрэглээний төлөвлөгөө боловсруулах зорилгоор худаг ашиглагчдын бүлэг байгуулах • Малын хэт бөөгнөрөлөөс сэргийлж худгийн ашиглалтын цагийн хуваарийг олон нийтэд урьдчилан мэдэгдэх 	Усны эх үүсвэрийг ариутгах, хамгаалах бүсийн улсын стандартын дагуу. Жилд нэг удаа	Орон нутгийн удирдах байгууллага болон худаг ашиглагчдын бүлгийн гарын үсэгтэй гэрээний заалт	Барилгын болон ашиглалтын үеийн турш
2.1 Олон нийтийн барилга байгууламжийг шинэчлэх, барих (сүргүүл, эмнэлэг, багийн төв, дотуур байр, соёлын төв) Нэмэлтээр газар шорооны ажил	<ul style="list-style-type: none"> • Барилга доторх хор, агаарын бохирдол, • Хатуу хог хаягдал, тоос шороо, дуу чимээнээс үүсэх сөрөг нөлөө • Хөрсний бохирдол, газар, байгаль орчны доройтол үүсэх, оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах 	<ul style="list-style-type: none"> • Хориотой бүсийн ус зайлуулах суваг, суурин газрын ойролцоох шороог хадгалах хадгалалтыг болон барилгын ажлыг нарийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэснээр байгалийн ус зайлуулах хоолой бөглөрөх, устахаас сэргийлнэ. • Сүүрь малтлагаас гарсан илүүдэл хөрсийг барилгын талбай дээр дахин ашиглах эсвэл барилгын талбайн менежментийн төлөвлөгөөний дагуу гүйцэтгэгч компани зайлуулна. • Талбайг чөлөөлөхөөс өмнө мод, ургамлын тэмдэглэгээг хийж, талбайгаас цөөн зүйл чөлөөлөхийн тулд цэвэрлэгээний ажилд хатуу хяналт тавих. 	Харж шалгах, Монголын Үндэсний Стандарт (MNS) 3838: 2008 болон Барилгын Стандартын Багц # 91.040. – жилд дөрвөн удаа	Сумын Засаг даргын хяналт дор гэрээний заалтаар гүйцэтгэгч, БОБ	Барилгын ажлын үед

		Барилгын компани нь баригдсан барилгын доторх модыг нөхөн эсвэл шилжүүлэн суулгана.			
Сумын төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх.	Газар, ус, агаар бохирдох	Барилгын ажилчдын байранд зохих ариун цэврийн, усан хангамжийн, хог хаягдлыг зайлуулах байгууламжийг.	Ариун цэврийн байгууламж, усан хангамж, хог хаягдлыг зайлуулах байгууламж байгаа эсэх - Нэг удаа шалгах.	Сумын Засаг даргын хяналт дор гэрээний заалтаар гүйцэтгэгч	Барилгын ажлын үед
Гүүр болон давааны шороон замыг засах, сайжруулах	Засварын явцад хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангагдахгүй байх	Засварын үед бусад замыг түр хугацаагаар ашиглуулах.	Орон нутгийнханы ашигладаггүй зам, гүүрний зураг төслийг боловсруулах.	Сумын Засаг даргын хяналт дор гэрээний заалтаар гүйцэтгэгч.	Барилгын ажлын үед
Хатуу хог хаягдал хаях цэгийг сайжруулах, байгуулах.	Газар, ус, агаар бохирдох.	Ариун цэврийн шаардлагыг хангах байршлыг тодорхойлох, усны урсац гэх мэт.	Ариун цэврийн байгууламж, усан хангамж, хог хаягдлыг зайлуулах байгууламж байгаа эсэх - Нэг удаа шалгах.	Байгаль Орчин Эрүүл Ахуйн Байцаагчийн хяналт дор гэрээний заалтаар гүйцэтгэгч	Барилгын ажлын үед

Хүснэгт Г.1 Байгаль орчин, нийгмийн нөлөөллийг бууруулах талаарх ерөнхий зөвлөмж

Байгаль орчин/Нийгмийн Нөлөөлөл	Бууруулах Арга Хэмжээ	Бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх үүрэг хариуцлага
Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл		
Бэлчээрийн эрсдэлийн менежмент бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд малын тархац байршил зүй зохисгүй хийгдсэнээс хамааран газрын талхагдал ихсэх, мөн газрын талхагдлаас үүдэн гадаргын усны чанарт сөрөг нөлөө үзүүлэх	<ul style="list-style-type: none"> - Бэлчээрийн Эрсдэлийн Менежментийн Төлөвлөгөө (БЭМТ)-нд БОНБУ хийлгэх; - БЭМТ төлөвлөлтөд сумын байгаль хамгаалагчид идэвхтэй оролцох; - Төслийн үйл ажиллагаа бүрд Байгаль орчны төлөв байдлын үнэлгээний шалгах хуудас (Хавсралт 2)-ыг бөглөсөн байх; - Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг (бэлчээрийн газрыг хамруулан) жил бүр тодотгон батлах; - Сум бүрийн төр захиргааны байгууллага, орон нутгийн иргэдийн нөхөрлөл ба байгаль орчны ажилтан хамтран БЭМТ боловсруулсан байх ба бэлчээрийн даацыг тооцоолсон байх; - ОНХС-аас дэмжих үйл ажиллагаанууд нь БЭМТ-д нийцсэн байх; - Сум бүрийн газрын даамал, мал эмнэлэг үржлийн тасгийн ажилтан, байгаль орчны улсын хяналтын байцаагчийн бэлчээрийн талхагдалд хяналт мониторинг хийх мэдлэг, чадварыг дээшлүүлэх; - Ургамал, биологийн олон янз байдал, бэлчээрийн талхагдлыг хяналт мониторингийг тогтмол хийх; 	<p>Сумын БОХУБ, аймгийн Байгаль орчны мэргэжилтэн</p> <p>Аймгийн БОНБУ хариуцсан Байгаль орчны мэргэжилтэн</p> <p>ЗДТГ</p> <p>Гэрээт зөвлөх</p> <p>Сумын БОХУБ</p> <p>Сургагч багш</p> <p>Мэргэжлийн байгууллага</p> <p>Аргазүйн зөвлөх</p>
Худгууд хөрсний усны нөөцөд нөлөөлөх	<ul style="list-style-type: none"> - Сумд байгаль орчны үнэлгээний хуудсыг бөглөж (Хавсралт 2) даган мөрдөх; - Худаг засварлах, шинээр гаргах ажлын БОНБУ-ээг аймгийн байгаль орчны байцаагчаар хийлгэх; - Худаг болон хөрсний ус хуримтлуулан ашиглах байгууламжуудын усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгахад чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээнд хөрөнгө оруулалт хийх; - Сумын БОХУБ-чид БЭМТ боловсруулахад оролцох; 	Сумын БОХУБ
Худгууд гүний усны нөөцөд нөлөөлөх	<ul style="list-style-type: none"> - Сумд байгаль орчны үнэлгээний хуудсыг бөглөж (Хавсралт 2) даган мөрдөх; - Худаг засварлах, шинээр гаргах ажлын БОНБУ-ээг аймгийн байгаль орчны байцаагчаар хийлгэх; - Шинээр гаргах, сэргээн сайжруулах худгуудын байршлыг тодорхойлоход нь Сумдын засаг дарга нарт дэмжлэг үзүүлэх 	<p>Сумын БОХУБ</p> <p>Аймгийн БОНБУ хариуцсан Байгаль орчны мэргэжилтэн</p>
Бог мал угаах байгууламжаас хөрсний усанд сөрөг нөлөө үзүүлэх	<ul style="list-style-type: none"> - Сумд байгаль орчны үнэлгээний хуудсыг бөглөж (Хавсралт 2) даган мөрдөх; - Мал эмнэлэг, үржлийн тасгийн ажилтан зохих стандартыг мөрдүүлэх; - Хортой хаягдал, газрыг ариутгах; 	<p>Сумын БОХУБ</p> <p>Сумын мал эмнэлгийн ажилтан</p>
Үерийн давтамж ба эрчим	<ul style="list-style-type: none"> - БЭМТ-нд газрын талхагдлыг бууруулах арга хэмжээг тусгах; - Сумын БОХУБ-чид БЭМТ боловсруулахад оролцох; - Гадаргын ус хуримтлуулах байгууламж барихдаа БОНБУ хийлгэж үерийн аюулыг бууруулах арга 	<p>ЗДТГ</p> <p>Аймгийн БОНБУ хариуцсан Байгаль орчны мэргэжилтэн</p>

	хэмжээг сайжруулах	
Экологийн хувьд эмзэг газруудад үзүүлэх нөлөө	<ul style="list-style-type: none"> - Сум бүр өөрсдийн нутаг дахь экологийн хувьд эмзэг газар (талхлагдсан газар, ховордсон зэрлэг амьтан бүхий газар, ундны усны эх сав газар гэх мэт)-ын байршлыг тогтоож зураглал гаргасан байх. - БЭМТ-нд экологийн хувьд эмзэг газруудыг тусгах, малчдын нутаг сэлгэх, нүүдэллэх, худаг гаргах газруудын байршил тогтоох, зураглал хийхэд нь Засаг даргад дэмжлэг үзүүлэх. - Бэлчээрийн Эрсдлийн Менежментийн Төлөвлөгөө (БЭМТ)-нд БОНБУ хийлгэх; - Сумын БОХУБ-чид БЭМТ боловсруулахад оролцох; - Холбогдох байгууллагуудын үүргийг тодорхойлж, хариуцлагыг сайжруулах - Сум бүр байгаль орчны үнэлгээний хуудас (Хавсралт 2)-ыг бөглөж байгалийн өвөрмөц газар, усны эх үүсвэр, соёлын өв болон тусгай хамгаалалттай газар болон экологийн эмзэг газруудад нөлөөлж болзошгүй дэд төслүүдийг хэрэгжүүлэхээс зайлсхийх; 	ЗДТГ Сумын БОХУБ МУ-ын Засгийн газар, БОАЖЯ, ХХААХҮЯ
Худаг уст цэг, барилга байгууламжийг сэргээн засварлах, шинэчлэх гэх мэт барилгын үйл ажиллагаануудаас үзүүлэх нөлөө	-Барилгын ажлын явцад мөрдөх байгаль орчны менежментийн зааварчилга (Хавсралт 4)-ыг дагаж мөрдөх.	ЗДТГ Барилгын гэрээт байгууллага
Барилгын ажлын үе дэх аюулгүй ажиллагаа	-Барилгын ажлын үед болзошгүй ослоос урьдчилан сэргийлэхийн тулд, барилгын ажлыг гэрээлэгч байгууллага ажилчдадаа Монгол улсын ХХААЭМ-ийн стандартын байнгын сургалт хийж хамгаалах хувцас хэрэглэлээр хангах. Дэлхийн банкны группийн БОЭМХ зааварчилгын ХХААЭМ-ийн шаардлагуудыг барилгын ажлын БОНХМТ-нд тусган хэрэгжүүлдэг байх.	Барилгын гэрээт байгууллага
Нийгэмд үзүүлэх нөлөөлөл		
Цаатан зэрэг газар нутгийн хувьд алслагдмал, цөөн тоотой ястнууд үйл ажиллагаанаас хоцрох	<ul style="list-style-type: none"> - Цаатан иргэдийг ТА төслийн болон ОНХС-ийн үйл ажиллагаанд оролцуулах, хүртэх ашгийг нэмэгдүүлэхийн тулд ҮЦОДТ-өөнд тусгай арга хэмжээнүүдийг тусган хэрэгжүүлэх. - Цаатан иргэдэд ОНХС-ийн үйл ажиллагааны талаар хүргэх мэдээллийг сайжруулж, мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулах. 	АЧБ-ийн гишүүд ОНТА ТХН Цагааннуур сумын Засаг дарга
Монгол хэлээр сайн ярьж, ойлгож чаддаггүй Казак хүмүүс оролцож чадахгүй байх	<ul style="list-style-type: none"> - ТА-3 төслийн мэдээлэл болон төслийн жил бүхий гүйцэтгэлийн тайланг Казак хэлээр хэвлэн тараах. - Аймгийн түвшин дэх Чадавхжуулах Багийн гишүүдийн ОНХС ба ТА-3 төслийн үйл ажиллагаа, жил бүрийн гүйцэтгэлийн тайлангийн үйл явц, үр дүнгийн талаах мэдлэг ойлголтыг сайжруулах. 	ТХН АЧБ ОНТА

Д1.Мониторингийн Төлөвлөгөө

N о.	Мониторингийн шалгуурууд	Мониторингийн төрөл/ Мониторингийн аргазүй	Мониторинг хийх давтамж	Үүрэг хариуцлага	Төсөв/эх үүсвэр
1	Замаар болон хорооллын дундуур барилгын материалыг аюулгүй тээвэрлэх	Хяналт шалгалт	Барилгын явцад тогтмол хийх	Барилгын гэрээт байгууллага	Гэрээт байгууллага гаргана
2	Барилгын ухлагаас гарсан шороог тэгшилж булах, зайлуулах.	Хяналт шалгалт	Барилгын явцад тогтмол хийх	Сум\Барилгын гэрээт байгууллага	Гэрээт байгууллага гаргана
3	Ажлын байрны эрүүл мэнд аюулгүй ажиллагааны дүрэм, ажилчдын нэг бүрийн хамгаалах хувцас хэрэгслийг ашиглуулах.	Хяналт шалгалт	Барилгын явцад тогтмол хийх	Барилгын гэрээт байгууллага	Гэрээт байгууллага гаргана
4	Иргэд олон нийтийн аюулгүй байдлыг хангах	Бүртгэгдсэн осол	Барилгын явцад тогтмол хийх	ЗДТГ	Орон нутгийн төсвөөс
5	Хатуу хог хаягдлыг ялган ангилах, зайлуулах	Хяналт шалгалт	Барилгын явцад тогтмол хийх	Барилгын гэрээт байгууллага	Гэрээт байгууллага гаргана
6	ОНХС-аас санхүүжүүлэх дэд төслүүдийн 90% нь аймгийн БОАЖГ-аар БОНБЕҮ хийлгэсэн байх	БОНБҮ-ний бүртгэл	Хэрэгжүүлэх явцад тогтмол хийх	ТХН	шаардлагагүй
7	ОНХС-аас санхүүжих дэд төслүүдэд БОМТ хийгдсэн ба ЗДТГ хэрэгжүүлсэн байх.	БОНБҮ-ний бүртгэл	Хэрэгжүүлэх явцад тогтмол хийх	Сумын БОХУБ ба аймгийн БОАЖГ	Дэд төсөл хэрэгжүүлэгч
8	Үндэстний цөөнх амьдардаг сумдад ОНХС-ийн үйл ажиллагаанд цөөнх хамрагдаж байгаа байдлыг шалгах мониторингийн хяналт хийсэн байх.	Уулзалт ба Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг	Жилд 2 удаа	ТХН АЧБ/ОНТА	Жилд 35'000 ам.доллар / төслийн менежментийн зардлаас

Д2. Чадавх бэхжүүлэх үйл ажиллагаа (Сургалт)

ОНХС-ийн дэд төслүүдийг орон нутагт хэрэгжүүлэхийн өмнө төслийн орон нутгийн бүх ажилтнууд зохих ёсоор бэлтгэгдсэн байх ёстой. Төслийн Үндэсний Зохицуулагч болон БО-ны мэргэжилтэн төслийн холбогдох ажилтнуудын БОНХМТ-өөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд шаардлагатай үр чадварыг тэдний үүрэг хариуцлагатай нийцэх эсэхийг хянан тодруулна. Ажилтан бүрт төслийн аймаг / сумдад БОНХМТ-гөөний хэрэгжилтийг хангах, хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдлэг чадварыг дээшлүүлэхэд ямар нэмэлт сургалт шаардлагатайг тодорхойлно.

ТА-3 төслийн үйл ажиллагаа болон БОНХМТ-ний хэрэгжилтэд хяналт тавихад оролцох оролцоог сайжруулах зорилгоор аймгийн ХХААГ болон сумын захиргааны ажилтнууд, тэр дундаа Хөдөө аж ахуйн тасгийн ажилтнууд, Байгаль Орчны Байцаагчид, Аймгийн Мэргэжлийн Хяналтын Газар (АМХГ)-ийн холбогдох байцаагчдын чадавхыг төслийн зүгээс дээшлүүлэх болно.

Байгаль орчны мэргэжилтэн, Хяналт Мониторинг Үнэлгээний ажилтан нь БОНХМТ-г танилцуулж дараах асуудлуудаар чиглүүлэг өгнө:

- ТА-3 төслийн явц ба өнөөгийн байдал.
- Төслийн сумдын нийгэм, эдийн засаг, байгаль орчны байдал,
- ТА-3 төслийн зорилго болон төлөвлөсөн үйл ажиллагаа, ОНХС-аас дэмжих боломжтой төсөл, үйл ажиллагаа, төслийн хүрээнд төлөвлөсөн хөрөнгө оруулалт, зохицуулалт, хяналт, тусламж гэх мэт.
- Ажилтнууд, зөвлөхүүдийн үүрэг, хариуцлага
- Чухал стандартууд болон тэдгээрийг ашиглах, хяналт тавих
- БОНХМБ-той холбоотой ажлын тодорхой үүрэг, чиглэл.
- Хяналт, хяналтын үйл явцын талаархи танилцуулга
- БОНХМТ болон ҮЦОДТ-өөг хянан сайжруулсан ажлын үр дүн.
- Хяналтын хуваарь болон бусад мэдээллийн танилцуулга.

Сургалт бүр хамгийн багадаа 1-2 хоног үргэлжилж, тодорхой програмтай, асуудлыг чөлөөт хэлэлцүүлгийн аргаар шийдвэрлэх даалгавруудыг багтаасан байх ёстой. Сургалтын хөтөлбөрийг төсөл хэрэгжүүлэх явцад гэрээт зөвлөх ТХН-тэй гэрээ байгуулан боловсруулна.

Хүснэгт Д.4 БОНХМТ-г хэрэгжүүлэх чадавхи бэхжүүлэхэд шаардлагатай сургалтууд

Сургалтын сэдэв:	Сургалтын зорилгын хураангуй ба агуулга	Хүлээн авагч / Оролцогч	Давтамж болон зорилтот он сар өдөр	Сургалтын тооцоолсон зардал (ам. доллар)
БОНХМТ-өөг танилцуулах	<i>Төсөл хэрэгжүүлэх газруудын талаарх мэдээлэл, бохирдлын эрсдэл ба хяналт, хөтөлбөрүүд зэрэг БОНХМТ-ний тойм, .</i>	<i>ТА төслийн оффисын бүх ажилчид / АЧББ-ын гишүүд, БОАЖГ, ХХААГ-ын ажилтнууд</i>	<i>Төслийн эхэнд</i>	<i>10000</i>

ОНХС-ийн журам, ОНХС-ийн талаарх сургалт	<i>ОНХС-аас дэмжих төслүүдэд БОНБУ хийх журам, санал болгож байгаа төслүүдэд БОНБУ хийлгэх шаардлага, ОНХС-ийн дэмжлэгээр хэрэгжих төслүүдэд тавигдах байгаль орчны хамгааллын шаардлага</i>	<i>Сумын ЗДТГ-ын бүх ажилтан / иргэд, багийн засаг дарга ТББ-ын төлөөлөгчид</i>		5000
Бохирдлын эрсдэл ба хяналт -ын сургалт				
Нөлөөллийн хяналт ба мониторинг	Хяналт Мониторинг болон Үнэлгээний зарчим, аргачлал Хамтын Оролцоотой арга зам болон хэрэгслийг ашиглах,	ТА төслийн оффисын бүх ажилтан / Сумын БОХУБ, газрын даамал, ХААТ-ийн ажилтнууд,	Төсөл эхлэхэд	10000
Агаарын Чанарын Мониторинг	Байгаль орчны агаарын чанар, ерөнхий хандлага, Доройтсон эсвэл экологийн эмзэг бүсэд хэрэгжих төслүүд, бохирдлын эх үүсвэр, жижиг шатаалтын байгууламжийн хүлэмжийн хийн ялгаруулалтын талаарх удирдамж, Түр зуурын эх үүсвэр, Дэгдэмхий органик нэгдлүүд (ДОН), Тоосонцор, Озоны Давхарга Задлах Бодис (ОДЗБ), Хүлэмжийн хий, Жижиг халаалттай үйлдвэрүүдийн ялгаруулалтыг хянах	<i>АБОАЖГ, АМХГ-ын ажилтнууд Сумын төрийн албан хаагчид, БОХУБ, байгаль хамгаалагчид</i>	<i>Төслийн эхэнд нэг удаа</i>	5000
Усны нөөц Хамгаалах	Усны хяналт шинжилгээ ба менежмент, аргачлал, усыг дахин ашиглах ба дахин боловсруулах, Хөргөлтийн болон халаалтын барилга байгууламж	<i>АБОАЖГ, АМХГ-ын ажилтнууд Сумын төрийн албан хаагчид, БОХУБ, байгаль хамгаалагчид</i>	<i>Төслийн эхэнд нэг удаа</i>	6000
Бохир ус ба орчны усны чанар	Хэрэглээ ба аргачлал, бохир усны ерөнхий чанар, гадаргын ус руу хаях, Ариутгах татуургын системд хаях, цэвэршүүлсэн бохир усыг газарт шингээх, септик систем, бохир усны менежмент, үйлдвэрлэлийн бохир ус, бохир усны цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал, бохир ус цэвэрлэх байгууламжаас гарах хаягдал, ажлын байрны эрүүл ахуй ба бохир усны цэвэршүүлэлтийн аюулгүй байдал.	<i>АБОАЖГ, АМХГ-ын ажилтнууд Сумын төрийн албан хаагчид, БОХУБ, байгаль хамгаалагчид</i>		13000

Аюултай материал, хог хаягдлын менежмент	Хэрэглээ ба аргачлал, Аюултай материал, хог хагдлын ерөнхий менежмент, Аюулын Үнэлгээ, Менежментийн Арга Хэмжээ, Ялгаруулалтаас Урьдчилан Сэргийлэх ба Хяналт Төлөвлөгөө, Ажлын байрны Эрүүл Ахуй ба Аюулгүй Байдал, Үйл Явцын Мэдээлэл ба Баримтжуулалт, Урьдчилан Сэргийлэх арга хэмжээ, Аюултай Материал Дамжуулах, Хэт Дүүргэлтээс Хамгаалах, Урвал, Галын Аюул, Дэлбэрэлтээс Урьдчилан Сэргийлэх Арга Хэмжээ, Хяналтын Арга Хэмжээ, Асгаралтаас Сэргийлэн хамгаалах, Хадгалах Сав ба Дамжуулах Хоолойн Алдагдлыг Илрүүлэх, Газар Доорх Хадгалах Сав (ГДХС), Их Хэмжээний Аюулыг Зохицуулах, Менежментийн Арга Хэмжээ, Урьдчилан Сэргийлэх Арга Хэмжээ, Онцгой Байдлын Бэлтгэл ба Хариу Арга Хэмжээ. Олон Нийтийн Оролцоо ба Мэдлэг.	<i>АБОАЖГ, АМХГ-ын ажилтнууд Сумын төрийн албан хаагчид, БОХУБ, байгаль хамгаалагчид</i>	<i>Төслийн эхэнд нэг удаа</i>	3000
Хог хаягдлын боловсруулалт	Хог Хаягдлын Ерөнхий Боловсруулалт, Хог Хаягдлын Боловсруулалтын Төлөвлөлт, Хог Хаягдлыг Дахин Боловсруулах ба Дахин Ашиглах, Цэвэрлэх болон Устгах, Аюултай Хог Хаягдлын Боловсруулалт, Хог Хаягдлыг Хадгалах, Тээвэрлэх, Цэвэрлэх, Устгах Хувийн Болон Төрийн Өмчит Хог Хаягдлыг Цэвэрлэх Гэрээлэгчид Жижиг Хэмжээний Аюултай Хог Хаягдлын Хяналт	<i>Бүх Оролцогч талууд</i>	<i>Төслийн хүрээнд</i>	5000
Бохирдсон газар	Эрсдлийн Үзлэг, Завсрын Эрсдлийн Менежмент, Эрсдлийн Нарийвчилсан Үнэлгээ, Эрсдлийг Бууруулах Байнгын Арга Хэмжээ, Хөдөлмөрийн Эрүүл Мэнд ба Аюулгүй Ажиллагаа	<i>Малчид болон нутгийн ард иргэд</i>	<i>Төслийн хүрээнд</i>	4000
Малчдад зориулсан тусгай сургалт				

Нөлөөллийн хамтын оролцоотой мониторинг, Үнэлгээ	Байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг таних энгийн аргууд <i>Усны чанарт үнэлгээ ба үнэлгээ хийх аргачлал</i>	<i>Малчид болон нутгийн ард иргэд</i>	<i>Төслийн хүрээнд</i>	6000
Төслийн менежмент ба хэрэгжүүлэх	Төсөл гэж юу вэ? Төслийн саналыг бичих, төлөвлөх ба хэрэгжүүлэх, хянах ба төслийн судалгаа, судалгааны ажил, хөтөлбөрийн үнэлгээ. Орон нутгийн ашиг хүртэгчдэд хандивлагч байгууллагуудын дэмжлэг үзүүлэх зарчим.	<i>Төслийн зорилтот бүлэг / малчид</i>	<i>Төслийн эхэн үед</i>	5000
НИЙТ				64000

Д3. БОНХМТ-ний хэрэгжилтийг зохион байгуулах зохицуулалт

No.	Оролцогч талууд	Үйл ажиллагаа	Эрх, Үүрэг Хариуцлага	Төсөв
1.	Сангийн Яам	Сумын ОНХС байгуулах ба хөрөнгө хуваарилах	<ul style="list-style-type: none"> - Төсөв боловсруулах - Хөрөнгө хуваарилах - Санхүүгийн хяналт 	-
2.	ТА төслийн баг	ОНХС-ийн хөрөнгө оруулалтын БОНБҮ-ний заалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none"> - ОНХС-ийн санхүүжүүлэх үйл ажиллагаануудын байгаль орчны үнэлгээний ажилд хяналт мониторинг хийх - БОНХМТ-ний талаар чадавх бэхжүүлэх сургалт - БОНХМТ-ний хэрэгжилтэд хяналт тавих - БОНХМТ-ний хэрэгжилтийн явцын тайланг ДБ-нд жилд нэг удаа гаргаж өгөх 	150000 (including the budget for training USD 64000\$)
3.	АЧББ	ОНХС-ийн хөрөнгө оруулалтын БОНБҮ-ний заалтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх	<ul style="list-style-type: none"> - ОНХС-ийн хөрөнгө оруулалтын БОНБҮ-ний зааварчилгыг ашиглаж байгаа байдалд мониторинг хийх - Сумын хэмжээнд ОНХС-ийн хөрөнгө оруулалтын БОНБҮ-ний заалтыг хэрэгжүүлж байгаа байдлын талаар ТА төслийн оффист тайлагнах 	21000
4.	Зөвлөх (Байгаль орчны аудит, Жил бүрийн гүйцэтгэлийн үнэлгээ)	Үнэлгээ, сургалт, зөвлөх	<ul style="list-style-type: none"> - Байгаль орчны хууль тогтоомжуудын хэрэгжилтийн байдалд үнэлгээ хийх - Гүйцэтгэлийг сайжруулах талаар зөвлөх - Жил бүрийн байгаль орчны аудит хийх 	4000
5.	Сумын ЗДТГ	ОНХС-ийн хөрөнгийн хуваарилалтыг зохион байгуулах	<ul style="list-style-type: none"> - Мэдээлэл түгээх - ОНХС-ийн менежментийг хариуцах - ОНХС-ийн хөрөнгө оруулалтын БОНБҮ-ний зааварчилгыг ашиглаж байгаа байдалд мониторинг хийх - ОНХС-ийн дэд төслүүдийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх 	10000
6.	Сумын ИТХ	ОНХС-ийн хөрөнгийн хуваарилалт,	<ul style="list-style-type: none"> - Олон нийтийн хяналт, үнэлгээ 	10000

		хэрэгжүүлэлтэд хяналт тавих	<ul style="list-style-type: none"> - Багийн ИНХ-ыг зохион байгуулж шийдвэр гаргуулах - ОНХС-г хэлэлцэн батлах 	
7.	Барилгын гэрээт гүйцэтгэгч байгууллага	Гэрээт ажлыг гүйцэтгэх	<ul style="list-style-type: none"> - Хууль хэрэгжүүлэх - Гарсан ололт сургамжийн талаарх мэдээллээр ЗДТГ-ыг хангах - Хавсралт-4-т заасан барилгын ажлын явцад дагаж мөрдөх байгаль орчны менежментийн зааварчилгыг дагаж мөрдөх 	3000
8.	Сумын БОХУБ	ОНХС-ийн санхүүжүүлэх үйл ажиллагаануудын байгаль орчны үнэлгээ хийх	<ul style="list-style-type: none"> - БОНБУ хийх шаардлагатай бүх үйл ажиллагаануудын байгаль орчны бүртгэлийн хуудсыг бөглөх - Үйл ажиллагаануудаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллүүдэд байгаль хамгаалагчидтай хамтран мониторинг хийх 	-
9.	Сумын байгаль хамгаалагчид	Байгаль, экологийн хувьд эмзэг газруудын талаар мэдээлэл түгээх	<ul style="list-style-type: none"> - ОНХС-аас санхүүжүүлэх үйл ажиллагаануудын байгаль орчны үнэлгээний ажилд оролцох - Сумын хэмжээнд байгаа Байгаль, экологийн хувьд эмзэг газруудын талаар мэдээлэл түгээх - ОНХС-ийн үйл ажиллагаануудаас үзүүлж болзошгүй нөлөөллүүдийг хянах 	-
10.	Аймгийн байгаль орчны ажилтан\ байцаагч	БОНБЕУ хийлгэх шаардлагатай ОНХС-ийн үйл ажиллагаанд БОНБЕУ хийх	<ul style="list-style-type: none"> - БОНБЕУ хийлгэх шаардлагатай ОНХС-ийн үйл ажиллагаанд БОНБЕУ хийх - Уул уурхайн ажиллагаа гэх мэт томоохон хэмжээний барилга угсралт, засварын ажлаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг хянах 	-
11.			-	198000

Д5. Тайлагнах журам

Энэхүү БОНХМТ-ний хэрэгжилтийн тайланг ТА-3 төслийн нэгжээс жил бүр гаргаж Дэлхийн Банканд тайлагнана. ТА-3 төслийн нэгж нь энэхүү төлөвлөгөөний хэрэгжилтийн талаарх мэдээллийг дараах 2 эх сурвалжаас авч нэгтгэнэ. Үүнд:

- 1) Төслийн Менежментийн Мэдээллийн Системээс оролцооны талаарх мэдээллийг авах
- 2) Төслийн жил бүрийн үнэлгээний тайлан

Д6. Гомдол Шийдвэрлэх Механизм (ГШМ)

ГШМ нь нөлөөлөлд өртсөн хүмүүсийн асуудал, гомдлыг цаг тухайд нь, хурдан шуурхай, ойлгомжтой, ил тод байдлаар шийдвэрлэх бөгөөд жендерийн мэдрэмжтэй, соёл ёс заншлын хувьд зохистой, төслийн нөлөөнд өртсөн хүмүүст үнэ төлбөргүй хандах боломжтой байна.

ГШМ нь нөлөөлөлд өртсөн хүн/олон нийтийн гаргасан гомдол, асуудлыг шийдвэрлэх үр ашигтай аргазүйтэй байх ёстой ба ТА-3 төслийн ТХН нь ГШМ-ийг хэрэгжүүлэх журам гаргаж мөрдөнө. ТХН гомдол гаргах, хүлээн авах, бүртгэх, шийдвэрлэх, хариу өгөх бүх үйл явцуудыг тайлбарласан мэдээллийн тараах материалыг бэлтгэж ашиглана.

Нөлөөлөлд өртсөн хүн/олон нийтээс гаргасан гомдлыг эхлээд ТХН-ийн Харилцааны асуудал хариуцсан зөвлөхөд өргөн барих ба гомдлыг дараах сувгуудаар мэдээлж болно:

Утас: 70009828

Е-шуудан: info@slp3.mn

Цахим хуудас: <http://tusuv-oronnutag.mof.gov.mn>

Фэйсбүүк: [facebook.com@LDFMongolia](https://www.facebook.com/LDFMongolia)

Твиттэр: <https://twitter.com/MongoliaSlp3>

Захиа явуулах хаяг: Тогтвортой амьжиргаа -3 төслийн нэгж, Улаанбаатар-15160, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Анкарагийн гудамж -23, Тод тавэр, 8-р давхар.

Аймаг бүрд байдаг төслийн орон нутаг дахь ажилтантай шууд уулзаж болно.

Хэрэв гомдол гаргагчид ТХН-ээс гомдлыг барагдуулах талаар гаргасан шийдвэр таалагдахгүй бол Засгийн газрын холбогдох байгууллага, ялангуяа төслийн хэрэгжүүлэгч агентлаг-Сангийн Яаманд эсвэл Дэлхийн Банкны Гомдол Шийдвэрлэх Албанд дараах хайгаар хүргүүлж болно:

Сангийн яам	Дэлхийн Банкны Гомдол Шийдвэрлэх Алба
Хаяг: С.Данзангийн гудамж, засгийн газрын байр-II, Улаанбаатар-15160, Монгол улс Утас: 51-267468	ДБГША нь иргэд, олон нийтийг ДБ-нд шууд гомдол гаргах нэмэлт арга замыг санал болгодог. ДБГША нь Дэлхийн Банкны хариу үйлдэл, хариуцлагыг дээшлүүлж, гомдлыг цаг алдалгүй

<p>Твиттэр: https://twitter.com/MOFMongolia/</p> <p>Фэйсбоок: https://www.facebook.com/MOFMongolia/</p> <p>Вэбсайт: https://mof.gov.mn/feedback</p>	<p>шалгаж, хариу арга хэмжээ авах болон хамтарч ажилласнаар асуудал, шийдлийг хурдан шуурхай тодорхойлоход нөлөөлдөг.</p> <p>ДБГША нь гомдлыг англи хэл дээр эсвэл гомдол гаргасан хүний тухайн улсын албан ёсны хэл дээр хүлээн авдаг. (ДБ-ийн Гомдлыг шийдвэрлэх үйлчилгээний гомдлын хуудсыг Хавсралт 3-т хавсаргасан болно). СГША-т мэдүүлгийг дараах хаягаар илгээнэ үү:</p> <p>Email: grievances@worldbank.org Fax: +1-202-614-7313 Letter: The World Bank Grievance Redress Service (GRS) MSN MC 10-1018 1818 H St NW Washington, DC 20433, USA</p>
--	--

Тайлагнах: ТА-3 төслийн ТХН нь ирүүлсэн гомдлыг хүлээн авч бүртгэн, судлаад зохих арга хэмжээ аваад хариу мэдэгдэх ба үр дүнг тайлагнана. ТХН-ээс гаргасан ГШМ-ийн тайланг төслийн цахим хуудсанд 6 сар тутамд байрлуулж олон нийтэд нээлттэй болгоно.

Е. Мэдээллийг Ил Тод Болгох ба Олон Нийтийн Хэлэлцүүлэг

Е.1 ТА-3 төслийн Нэмэлт Санхүүжилтийн төслийн бэлтгэл шатанд хийсэн хэлэлцүүлэг

Нэмэлт санхүүжилтийн төслийн бэлтгэл шатанд БОНХМТ ба ҮЦОДТ-өөг хэлэлцүүлэх зорилгоор 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотод, 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр Улаанбаатар хотод Олон Нийтийн Хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Хэлэлцүүлгүүдийг дараах хөтөлбөрийн дагуу зохион байгуулсан. Үүнд:

- Нээлт. (Хэлэлцүүлгийг нээж Х.Ган-Очир, *Хөвсгөл Аймгийн ЗДТГ-ын дарга, Энхбат, ТА төслийн ТХН-ийн ахлах мэргэжилтэн* нар үг хэлсэн.)
- Уулзалт зөвлөгөөний зорилго, гарах үр дүнг танилцуулах, (*Г.Гансүх, төслийн Үндэсний Зөвлөх* танилцуулсан)
- “Тогтвортой Амьжиргаа-3 төслийн явц, үр дүн ба ТА-3 төслийн нэмэлт санхүүжилтийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зорилго, зорилтууд” танилцуулга, (*М.Энхбат, ТХН-ийн ахлах мэргэжилтэн* танилцуулсан)
- Төслийн нэмэлт санхүүжилтийн хүрээнд баримтлах БОНХМ-ийн бодлого, төлөвлөгөө ба ҮЦОДТ, тэдгээрийг мөрдөн хэрэгжүүлэхэд орон нутгийн төрийн захиргааны байгууллага иргэдийн үүрэг, зорилт, оролцоо. (*Г.Гансүх, төслийн Үндэсний Зөвлөх* танилцуулсан.)

-Танилцуулгатай холбоотой асуулт хариулт, ярилцлага. (Г.Гансүх, төслийн Үндэсний Зөвлөх хөтөлж явуулсан.)

Е.2.1. Хөвсгөл аймгийн Мөрөн хотод хийсэн хэлэлцүүлэг

- **Өдөр:** 2020 оны 1 дүгээр сарын 08-ны өдөр
- **Байршил:** Хөвсгөл аймгийн Мөрөн хот, аймгийн ЗДТГ-ын хурлын заал.
- **Оролцогчид:** Хэлэлцүүлэгт Мөрөн хот, Хатгал тосгон, Алаг-Эрдэнэ, Арбулаг, Цагааннуур сумдын ЗДТГ-ын ажилтан, орон нутгийн иргэдийг төлөөлсөн нийт 28 хүн оролцсон. Оролцогчдын нэрийн жагсаалтыг Хүснэгт Е2.4-д хавсаргав.
- **Хэлэлцүүлэгт оролцогчдын гаргасан санал ба дэвшүүлсэн асуудлууд:**

Уулзалтын үеэр хийсэн дээрх танилцуулгуудтай холбогдуулан оролцогчид дараах санал гаргаж байсан. Үүнд:

Х.Ган-Очир, Хөвсгөл Аймгийн ЗДТГ-ын дарга

Уулзалт хэлэлцүүлэгт оролцогчдод талархал илэрхийлж, ТА-3 төслийн үр дүн, ололт, сургамжийн талаар дүгнэж, энэ төсөл цаашид үргэлжлэн хэрэгжвэл аймаг, суманд улам илүү их үр нөлөө үзүүлэх болно гэдгийг онцлон тэмдэглэсэн. Тэрээр олон нийтийн хэлэлцүүлэгт амжилт хүсээд, БОНХМТ-нд тодорхой санал тусгаж оруулахад хувь нэмэр оруулах, өөрсдийн амьдрал, байгаль орчинд сөргөөр нөлөөлж болзошгүй нөлөөллийг сайтар тодорхойлж нөлөөллийг бууруулах, арилгах талаар тодорхой үйл ажиллагааг санал болгохыг оролцогчдоос хүсэв.

Ц.Маралмаа, Хатгал тосгоны санхүү албаны дарга.

БОНХМТ болон ҮЦОДТ-д тусгасан асуудлуудтай санал нэг байна. Шаардлагатай асуудлууд тусгагдсан байна.

ОНХС ил тод байдаг өгөөжтэй сан. 2013 оноос олон төсөл хэрэгжүүлсэн. Өнгөрсөн хугацаанд хэрэгжсэн төлүүдээс БОНийгмийн сөрөг нөлөө гараагүй.

1.Иргэдээс санал аваад эрэмбэлээд дахиад багийн хурлаар хэлэлцүүлдэг. Гэхдээ багийн хуралд цөөн хүн ордог учир хөдөөгийн хүмүүсийн гаргасан саналыг үгүйсгэдэг. Иймд багийн хурлаар дахин хэлэлцүүлдэг нь буруу байна.

2.Багийн төвшинд саналаа гаргаад сумын ажлын хэсэг дээр эрэмбэлдэг.

Хатгал тосгон аливаа сургалт сурталчилгаанаас хоцордог учир нь төслийн бүх асуудал Алаг-эрдэнэ сумаар дамжин явдаг. Төслийн тайлангууд Алаг-Эрдэнэ сумаар гардаг учир үнэлгээний хувьд Хатгал тосгоны үнэлгээ доошоо орчихдог.

3. Хог хаягдлын менежментийг сайжруулах асуудал Хатгал тосгон болон Хөвсгөл нуурын эрэг орчимд байгаль орчны тулгамдсан асуудал болоод байна.

Д.Ялалт, Цагааннуур сум ЗДТГ-ын дарга

Манай сумын 90 гаруй % нь ТХГ-т хамрагддаг учир ТА төслийн үйл ажиллагааг ТХГ-т хэрэгжүүлэхэд БО-ны талаас нь харж үзэж экологийн эмзэг газарт нөлөө үзүүлэх үйл ажиллагааг дэмжихгүй гэсэн заалтыг өөрчилж өгнө үү.

Зуны улиралд тайга руу очиход их хэцүү байдаг учир сургалт сурталчилгаа хийхэд хэцүү. Өвөл 4 сар хүртэл цаатан эрчүүд нь оторт явж эмэгтэйчүүд нь үлдсэн байдаг учир санал авахад хүндрэлтэй. Иймд ОНХС хариуцсан мэргэжилтэн болон БОХУБ,

төслийн ажилтан хамтран явж уулзалт хийх боломжийг тодорхой хугацаанд бүрдүүлж өгнө үү.

ОНХС-ийн үйл ажиллагаануудыг багаар хэлэлцүүлэхээр цаатан иргэдийн санал хойш тавигддаг. Иймд цаатан иргэдээс гарсан саналыг тусгайлан эрэмбэлэх журам байх боломжийг дэмжиж өгөөч.

Цаатан иргэдийг мал эмнэлгийн үйлчилгээнд хамруулах үйл ажиллагаа их хэрэгтэй. Цаа бугын вакцинжуулалтыг төслийн хүрээнд дэмжиж хийхэд анхаарч өгөөч. Цаа бугын тоо өсөх хандлагатай байна. Одоогоор 2600 гаруй цаатай болсон. ТА төслөөс цаа бугыг эрүүлжүүлэх, цус сэлгэх талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ их үр дүнтэй болсон учир энэ арга хэмжээг үргэлжлүүлэн дэмжих хэрэгтэй байна.

Цаатан иргэдийн Тува хэлний сургалтын асуудал хэрэгтэй байна. Ном материалаар хангах.

Я.Эрдэнэжав, Цагааннуур сумын БОХУБ

БЭМТ-нд цаа бугын бэлчээрийн нөөцийг судалж үндэслэлтэй тодорхойлох хэрэгцээ их байна. Баруун Зүүн тайгад бэлчээрийн талхагдал ихсэх хандлагатай байгаа.

АЖ-аас үүсэж байгаа хог хаягдал, бие засах газрын асуудалд анхаарах энэ чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх

Аялал жуулчлалын бүс нутагт ирж байгаа жуулчдаас орох орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх

Цаа бугын гол бэлчээр нутаг нь ТХГ-т орсон учир ТХГ-ын хамгаалалтын бүсүүдийн онцлогт нийцүүлэн цаатан иргэдийн нүүдэллэх боломжийг нэмэгдүүлэх талаар ТХГ-ын хамгаалалтын захиргаа, сум, баг хамтран хэлэлцэж төлөвлөн хэрэгжүүлэх
Хог хаягдлын цэгийн байршил болон тохижуулалтыг стандартын дагуу шинэчлэн сайжруулах. БОНХМТ болон ҮЦОДТ-д гол асуудлуудыг тусгасан байна.

Энхбаяр, Алаг-Эрдэнэ сум

Цаа бугыг зарж үзүүлбэр болгодгийг зогсоох, цаа бугыг үзүүлэх зорилгоор ашиглаж байгаа хүмүүс амьтны амьдрах нөхцөлийг хангахгүй, зөвхөн бизнесийн ашиг олоход зориулж байгаад анхаарах.

Бямбасүрэн, Арбулаг, ЗДТГ-ын дарга

ОН-т аялал жуулчлал хөгжсөнөөр нутгийн иргэдэд орлого олох боломж нэмэгдэж байна. Иймд аялал жуулчлалд чухал ач холбогдолтой зам үер усанд идэгдэж эвдрэх, хүн машин явах боломжгүй болж байна. Иймд аялал жуулчлалын зам засах, ус хангамжийг сайжруулах зорилгоор худаг уст цэгийг засаж шинээр гаргах асуудлыг дэмжиж өгөөч.

Батдорж, Алаг-Эрдэнэ сум, ЗДТГ-ын дарга

ОНХС нь орон нутагт санхүүгийн боломж олгож байгаа ганц сан юм. Энэ сан нь ТА төслийн үр нөлөөг дээшлүүлдэг. ОНХС-аас дэмжиж санхүүжүүлсэн аливаа үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд сөрөг нөлөө үзүүлэхгүй байгаа. Иймд БОНХМТ ба ҮЦОДТ-ийг дэмжиж байна. Бид үүрэг хариуцлагаа биелүүлж ажиллахын төлөө байна.

Сүүлийн жилүүдэд сангийн хөрөнгө оруулалт багасч байгаа үүнд анхаарч нэмэгдүүлж өгөөч. Орон нутгийн ЗДТГ-ыг ОНХС-аас дэмжих шаардлага их байдаг. Энэ нь дүрэм журмаараа хоригдсон байдаг.

Сумын удирдлага, мэргэжилтнүүд, Багийн ЗД, иргэд малчдыг чадавхжуулах сургалтыг их явуулмаар байна. ОНХС-ийн дэмжлэгээр хэрэгжүүлэх төсөл үйл ажиллагааг санаачлах, төслийн санал боловсруулах аргазүйн сургалтыг иргэдэд өгөх.

Баттулга, Хөвсгөл аймгийн ХХААГ -ын дарга

Сум дахь МЭҮТ-ийн нэр нь өөрчлөгдөөд ХААТасаг гэж нэртэй болсон. ХААТ нь Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, үржил, бүртгэл, хариуцсан мэргэжилтэн, Хүнс, ЖДҮ, хоршоо хариуцсан мэргэжилтэн, Бэлчээр газар тариалан ус хангамж хариуцсан мэргэжилтэн гэсэн 3 орон тоотой бий болсон. Энэ ажилтан БЭМТ-өөг хариуцаж ажиллана. Иймд БОНХМТ-нд энэ албан тушаалаар нь нэрийг өөрчлөн оруулах хэрэгтэй. Хөвсгөл аймгийн сумдад ХААТ-ийн энэ асуудал хариуцсан мэргэжилтэн одоогоор ажиллахгүй байна. Мэргэжилтнүүдэд зориулсан чадавхжуулах сургалтыг хийхдээ тэр сурсан ажилтан иргэд малчдадаа сургалт зөвлөгөө өгөх чадвартай болтол нь сургах хэрэгтэй байна. Малчдад бэлчээрийн даац, нөөцийг тохируулах, талхагдлаас урьдчилан сэргийлэх аргазүйн талаар сургалт явуулдаг чадварыг тэр хүмүүст олгох шаардлагатай.

С.Ганбат, Цагааннуур сумын цаатан иргэн

УТХГ-ыг байгуулахдаа цаатан иргэдийн нутаг, амьдралын онцлогийн талаар нарийн судалгаа хийгээгүйгээс цаатан иргэд нүүдэллэх нутаг сэлгэхэд их хүндрэл учирч байна. Экологийн эмзэг газрууд болон ТХГ-ын хамгаалалтын бүс, горим дэглэмийн талаар цаатан иргэдэд мэдээлэл, танилцуулга муу хийж байна. Амьдралын уламжлал онцлогийг харгалзан үзэхгүйгээр хууль зөрчсөн гэж торгох, хориглох асуудал их гарч байна. Цаатан иргэд байгалиа сайн хамгаалж ирсэн, байгальтайгаа зохицон амьдарч байна. Гэтэл Улаан Тайгын ДЦГ-ын Хамгаалалтын Захиргаа биднийг байгалиа сүйтгэж байна, хохирол учруулж байна гэж үздэг, хамгаалалттай газрын гүн рүү нүүдэллэн зусах, намаржих, буу авч явахыг зөвшөөрдөггүй ба хамтарч ажиллахгүй байна. Цаа өсөж байгаагийн хэрээр нутаг бэлчээр сэлгэх тэлэх шаардлага их гарч байна. Үүнийг анхаарч дэмжиж өгөх хэрэгтэй байна.

Оролцогчдын гаргасан саналуудаас БОНХМТ болон ҮЦОДТ-өөнд хамааралтай асуудлуудыг доорх байдлаар нэгтгэн гаргав. (Хүснэгт Е-2.1)

Хүснэгт Е-2.2. Мөрөн хотод болсон хэлэлцүүлэгт оролцогчдын гаргасан санал

Хэлэлцүүлэг хийсэн огноо	Хэлэлцүүлгийг цүүлгийг хаана хийсэн	Оролцогчид	Хэлэлцүүлэгт оролцсон талууд, төлөөлөгчдийн санал, дүгнэлт	ТА-3 төслийн Нэмэлт санхүүжилтийн төслийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн явцад эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар гаргасан санал
2020 оны 1 сарын 08	Хөвсгөл аймгийн төв Мөрөн хотод	Нийт 28 хүн Мөрөн хот, Хатгал тосгон, Цагааннуур, Алаг-Эрдэнэ,	<ul style="list-style-type: none"> ОНХС-аас дэмжиж санхүүжүүлсэн аливаа үйл ажиллагаанаас байгаль орчин болон нийгэмд сөрөг нөлөө үзүүлэхгүй байгаа. Иймд БОНХМТ ба ҮЦОДТ-ийг дэмжиж байна. 	<ul style="list-style-type: none"> Өмнөх үе шатанд хэрэгжүүлсэн БОНХМТ-г хэрэгжүүлж ажиллах боломжтой

		<p>Арбулаг сумдын ЗДТГ, иргэд, цаатан иргэдийн төлөөлөл. Нэрсийг хавсаргав.</p>	<ul style="list-style-type: none"> • Аялал жуулчлалын бүс нутагт ирж байгаа жуулчдаас орох орлогыг нэмэгдүүлэх зорилгоор дэд бүтцийг сайжруулах арга хэмжээг дэмжиж хэрэгжүүлэх • АЖ-аас үүсэж байгаа хог хаягдал, бие засах газрын асуудалд анхаарах энэ чиглэлээр үйл ажиллагаа хэрэгжүүлэх • Хог хаягдлын цэгийн байршил болон тохижуулалтыг стандартын дагуу шинэчлэн сайжруулах. • Хог хаягдлын менежментийг сайжруулах асуудал Хатгал тосгон болон Хөвсгөл нуурын эрэг орчимд байгаль орчны тулгамдсан асуудал болоод байна. 	<ul style="list-style-type: none"> • ТА төслийн хүрээнд ОНХС-аас аялал жуулчлалын дэд бүтцийг дэмжихдээ хог хаягдлын менежмент, ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг илүү дэмжих • Гол, нуур цөөрмийн ойролцоох хот сууринд хог хаягдлын менежментийг холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу явуулж байгаад тавих хяналтын сумдын БОХУБ хариуцан ажиллана • Усны эх үүсвэрийн ариун цэврийн хамгаалалтын бүсэд төслийн аливаа үйл ажиллагаа явуулахыг дэмжихгүй
			<ul style="list-style-type: none"> • БЭМТ-нд цаа бугын бэлчээрийн нөөцийг судалж үндэслэлтэй тодорхойлох хэрэгцээ их байна. • Цаа өсөж байгаагийн хэрээр нутаг бэлчээр сэлгэх тэлэх шаардлага их гарч байна. Баруун Зүүн тайгад бэлчээрийн талхагдал ихсэх хандлагатай байгаа. 	<ul style="list-style-type: none"> • Сумын БЭМТ-нд цаа бугын бэлчээрийн даац нөөцийг судлан менежментийг хэрхэн зохион байгуулах асуудлыг нэмж оруулах.
			<ul style="list-style-type: none"> • Сум дахь МЭҮТ-ийн нэр нь өөрчлөгдөөд Хөдөө Аж Ахуйн Тасаг (ХААТ) гэж нэртэй болсон. ХААТ нь Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, үржил, бүртгэл, хариуцсан мэргэжилтэн, Хүнс, ЖДҮ, хоршоо хариуцсан мэргэжилтэн, Бэлчээр газар тариалан ус хангамж хариуцсан мэргэжилтэн гэсэн 3 орон тоотой бий болсон. 	<ul style="list-style-type: none"> • Иймд БОНХМТ-нд энэ албан тушаалаар нь нэрийг өөрчлөн оруулах хэрэгтэй. • ХААТ-ын Бэлчээр газар тариалан ус хангамж хариуцсан мэргэжилтэн төслийн хүрээнд хэрэгжүүлэх БЭМТ-өөг хариуцаж ажиллана.

			<ul style="list-style-type: none"> Сумын удирдлага, мэргэжилтнүүд, Багийн ЗД, иргэд малчдыг чадавхжуулах сургалтыг их явуулмаар байна. ОНХС-ийн дэмжлэгээр хэрэгжүүлэх төсөл үйл ажиллагааг санаачлах, төслийн санал боловсруулах аргазүйн сургалтыг иргэдэд өгөх. Малчдад бэлчээрийн даац, нөөцийг тохируулах, талхагдлаас урьдчилан сэргийлэх аргазүйн талаар сургалт явуулах шаардлага их байна. 	<ul style="list-style-type: none"> Мэргэжилтнүүдэд зориулсан чадавхжуулах сургалтыг хийхдээ тэр сурсан ажилтан иргэд малчдадаа сургалт зөвлөгөө өгөх чадвартай болтол нь сургах хэрэгтэй байна.
			<ul style="list-style-type: none"> ОНХС-ийн үйл ажиллагаануудыг багаар хэлэлцүүлэхэд олонхын саналаар цаатан иргэдийн санал хойш тавигддаг. Иймд цаатан иргэдээс гарсан саналыг тусгайлан эрэмбэлэх журам байх боломжийг дэмжиж өгөөч. 	<ul style="list-style-type: none"> Үндэстний цөөнхийн эрх ашигт хамааралтай үйл ажиллагааг дэмжих журам нэмж оруулах асуудлыг судлан хэрэгжүүлэх

Хүснэгт Е2.2. Хөвсгөл аймгийн Мөрөн хотод хийсэн хэлэлцүүлэгт оролцогчдын нэр

№	Нэр	Сумын нэр	Албан тушаал	Утас
1	Х.Ган-Очир	Хөвсгөл Аймаг	ЗДТГ-ын дарга	99996838
2	Ч.Батдорж	Хөвсгөл Аймаг	ТА-3 зохицуулагч	99049922
3	Г.Баттулга	Хөвсгөл Аймаг	ХХААГ-ын дарга	88103568
4	Б.Нарантуяа	Хөвсгөл Аймаг	ХХААГ, мэргэжилтэн	95402616
5	Б.Догсомжав	Хөвсгөл Аймаг	БОАЖГ, мэргэжилтэн	86927972
6	Б.Ариунсумъяа	Хөвсгөл Аймаг	ЗДТГ-ын мэргэжилтэн	88094537
7	З.Батдорж	Алаг-Эрдэнэ	ЗДТГ-ын дарга	92116855
8	Г.Түмэнбаяр	Алаг-Эрдэнэ	Бизнесмэн	98383553
9	Ч.Хишигдэлгэр	Алаг-Эрдэнэ	БОХУБ	98389696
10	Д.Майннэгэн	Алаг-Эрдэнэ	ЗДТГ-н НБ ажилтан	98388060
11	Л.Энхбаяр	Алаг-Эрдэнэ	Багийн ИНХ-ын дарга	93372333
12	Ц.Маралмаа	Хатгал	Тосгоны Ня-бо	88021144
13	Б.Баярмаа	Арбулаг	Татварын байцаагч	80086322
14	С.Аюушжав	Арбулаг	БАгийн ЗД	88017677
15	Т.Цолмон-Эрдэнэ	Арбулаг	ЗДТГ-ын ажилтан	91333369
16	Ц.Ганхуяг	Арбулаг	БОХУБ	99978087
17	Л.Бямбасүрэн	Арбулаг	ЗДТГ-ын дарга	95384180
18	П.Цэвээндулам	Арбулаг	Иргэн	95386323
19	Б.Ичинхорлоо	Цагааннуур	ЗДТГ-ын ажилтан	89966695
20	Я.Эрдэнэжав	Цагааннуур	БОХУБ	88519048
21	Д.Ялалт	Цагааннуур	ЗДТГ-ын дарга	95729913

22	С.Ганбат	Цагааннуур	Цаатан иргэн	86774605
23	Б.Саяана	Цагааннуур	Цаатан иргэн	80662554
24	Т.Ганбат	Цагааннуур	Цаатан иргэн	80621141
25	Г.Өнөрсайхан	Цагааннуур	Цаатан иргэн	98181645
26	Б.Ганбаатар	Хатгал	Захирагч	99796030
27	С.Бат-Эрдэнэ	Цагааннуур	иргэн	99227337
28	Н.Лхагвасүрэн	Цагааннуур	иргэн	89922321

Е.2.2. Улаанбаатар хотод хийсэн хэлэлцүүлэг

- **Өдөр:** 2020 оны 1 дүгээр сарын 15-ны өдөр
- **Байршил:** Улаанбаатар хот, “Корпрэйт энд Конвэншн” төвийн хурлын заал.
- **Оролцогчид:** Хэлэлцүүлэгт Улаанбаатар хот дахь ТА-3 төслийн ТХН-ийн ажилтнууд, Баян-Өлгий, Дундговь, Төв, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын ажилтнууд, зарим сумдын захиргаа, орон нутгийн иргэдийг төлөөлсөн нийт 25 хүн оролцсон. Оролцогчдын нэрийн жагсаалтыг Хүснэгт Е2.4-д хавсаргав.
- **Хэлэлцүүлэгт оролцогчдын гаргасан санал ба дэвшүүлсэн асуудлууд:**

Уулзалтын үеэр хийсэн дээрх танилцуулгуудтай холбогдуулан оролцогчид дараах санал гаргаж байсан. Үүнд:

1. Тогтвортой амьжиргаа төслийн хүрээнд байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийн талаар

Сэлэнгэ аймгийн төлөөлөгчдийн санал.

- Хавар намрын хуурайшилттай улиралд бэлчээр хадлангийн газарт түймэр гарч байгаль бэлчээрт хохирол учруулах
- Хүнсний ногоо тариалахад химийн бордоо, пестицидийн хадгалалт хамгаалалт, ашиглалтын горимын журам зөрснөөс сөрөг нөлөө үүсэх
- Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах асуудал байхгүйгээс хаягдлын хэмжээ нэмэгдэх
- Аялал жуулчлалын газар болон төв замын дагуу ариун цэврийн байгууламж байхгүйгээс бохирдол бий болох
- Хадлангийн талбайг их хэмжээтэй хашиж хамгаалах тохиолдолд зэрлэг амьтан нүүдэллэх боломж алдагдах
- Сумын төв суурин газруудад үерээс хамгаалах далан суваг байхгүйгээс газрын элэгдэл эвдрэл ихсэх

Баян-Өлгий аймгийн төлөөлөгчдийн санал

- Газар, бэлчээрийн талхагдлаас шалтгаалан хөрсний бохирдол бий болох
- Сумын төв суурин газрын хог хаягдлын цэг шаардлага хангахгүй байгаагаас агаарын болон хөрс усны бохирдол үүсэж байна
- Бие засах газар ариун цэврийн байгууламжууд шаардлага хангахгүй байгаагаас хөрсний болон ундны усны эх үүсвэр бохирдох
- Үерийн далан суваг шуудууны ашиглалтын үеийн журам зөрчигдөх, мониторинг муугаас газар эвдрэх нөхцөл байдал ихсэх

- Мал угаах ванны ойролцоох газарт ургамлын бүрхэвч устаж хөрс талхлагдах

Дундговь аймгийн төлөөлөгчдийн санал

- ТА-3 төслийн нэмэлт санхүүжилтийн төслийг өмнөх үе шатны төслүүдтэй уялдуулж цогцолбор байдлаар хэрэгжүүлэн өмнө бий болгосон хүчин чадлын тогтвортой байдлыг сайжруулахад чиглүүлэх
- Иргэдэд төслийн талаар мэдээлэл сайн өгч зөв ойлголт бий болгох
- Малын ашиг шимийн нэмэгдүүлэх зорилгоор гаднаас шинэ үүлдрийн мал, амьтан оруулж ирэхэд малын шинэ төрлийн өвчин, паразит нэмэгдэх магадлалтай
- ТА төслийн хүрээнд ОНХС-аас дэмжих төслүүдэд хог хаягдлыг ялган ангилах, дахин ашиглах шаардлага тавьдаг болох
- Булаг шандыг хашиж хамгаалах, ундаргыг сэргээх ажлыг нарийн зураг төсөлгүйгээр хийж байгаа нь тухайн булгийн ундаргыг ширгээх, сөрөг нөлөөлөх боломж бий болгож байна.
- Аймгийн болон сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг байгаль орчны үнэлгээ, Мониторингийн чиглэлээр дахин сургах шаардлагатай байна

Төв аймгийн төлөөлөгчдийн санал

- Малын бууц, барилгын хог хаягдлыг хаях цэгүүдийн байршлыг нарийн тогтоож, тохижуулах асуудал нэн шаардлагатай байна. Хог хаягдлын цэгийн байршил тодорхойгүй, буруу газар байрласнаас үүдэн хөрс, ус, агаарын бохирдол үүсгэдэг.
- Тухайн аймаг суманд байгаа соёлын өвийг сайн тодорхойлж зурагт тэмдэглээгүйгээс тэдгээрт сөрөг нөлөө учрах эрсдэл их байна.
- ТА төслийн хүрээнд ОНХС-аас санхүүжүүлж байгаа барилгын үйл ажиллагаанд хэрэглэж байгаа материалын чанар стандартад тавих шаардлага сул байгаагаас байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлдэг.
- Шинээр хэрэгжүүлэх төслийн үйл ажиллагаанууд өмнөх үе шатны үйл ажиллагаануудын үр нөлөө, үр дүнг тогтворжуулах, үргэлжлүүлэхэд хэр нөлөөлөх вэ? гэдгийг анхаарч үзэх.

Дундговь аймгийн төлөөлөгчдийн санал

- Малын үүлдрийг сайжруулах сургалтыг малчдад зориулан явуулах хэрэгтэй байна.
- Хогийн менежмент муу байгаагаас орчны бохирдол үүсэх
- Иргэдэд мэдээлэл, сургалт, сурталчилгаа сайн хийх
- ЗДТГ-ын ажилтнуудыг байгаль орчны болон нийгмийн нөлөөллийг үнэлэх аргачлалд сургах
- Сумын хэмжээний байгаль орчин, байгалийн нөөц, дэд бүтцийг зураглалд сайн тусгах
- Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх талаар БОНХМТ болон ҮЦОДТ-г хэрэгжүүлэх зардал төсвийг аймаг сумдад тодорхой төлөвлөж өгөх хэрэгтэй
- АЧББ-т байгаль орчны зөвлөх мэргэжилтэн ажиллуулах

Сэлэнгэ аймгийн төлөөлөгчдийн санал

- АЧББ шиг үүрэгтэй багийг сум бүрд байгуулж ажиллуулах

- Энэ онд бүх сумын ИТХ шинээр сонгогдох учраас шинээр томилогдох Засаг дарга, Багийн ИНХ-ын дарга, Багийн засаг дарга нарыг сургалтад хамруулж ТА төслийн талаар мэдээлэл ойлголт, аргазүйг нь сайжруулах шаардлагатай
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг төслийн үйл ажиллагаанд хамруулах тал дээр анхаарч тэдний мэдлэг мэдээллийг сайжруулах
- ТА-3 төслийн хүрээнд байгаль орчин нийгмийн хамгааллын сайжруулах талаар хуримтлуулсан сайн туршлагыг дэлгэрүүлэх
- БОНБУ хийлгэхэд бүрдүүлэх шаардлагатай материалын жагсаалтыг хэвлэж олон нийтэд тараах
- ОНХС-аас санхүүжүүлэх үйл ажиллагааны санал гаргах, боловсруулах талаар иргэд олон нийтийн мэдлэг ойлголтыг сайжруулах сургалт сурталчилгаа хийх

Баян-Өлгий аймгийн төлөөлөгчдийн санал

- Газар, хөрс, усны бохирдлын өнөөгийн байдлыг тодорхойлох судалгаа хийлгэх
- Үерийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалтыг иргэдийн дунд хийх
- Барилга барих зорилгоор түгээмэл тархацтай ашигт малтмал (элс хайрга шавар, чулуу) авч ашигласан газрыг нөхөн сэргээх шаардлагыг ОНХС-аас хэрэгжүүлж буй бүх үйл ажиллагаанд тавьж мониторинг хийх
- Мах, арьс шир боловсруулах үйлдвэрээс гарах хог хаягдлыг дахин боловсруулах асуудал чухал байна.
- Сум бүрд байдаг Тогтвортой Хөгжлийн Хэсгийн гишүүдийг сургах
- Сумдын Багийн ИНХ-ын дарга, Багийн засаг дарга нарыг сургаж чадавхжуулах
- Иргэдийг омгийн ахлагчаар дамжуулан мэдээллээр хангах
- ИТХ-ын төлөөлөгчдийг сургаж чадавхжуулах

Төв аймгийн төлөөлөгчдийн санал

- БОНХМТ болон ҮЦОДТ-ний талаар иргэдийн мэдлэг, ойлголтыг сайжруулах
- Төслийн хүрээнд үүсч болох сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний талаар иргэд олон нийтэд мэдээлэх
- ОНХС-ийн дэмжлэгтэй баригдах аливаа барилгын орчин тойрныг тохижуулах, цэцэрлэгжүүлэх шаардлага тавих
- Дэд төслүүд эхлэхийн өмнө болон дууссаны дараа байгаль орчны байдалд үнэгээ хийдэг болох
- Дэд төслийн цаашдын тогтвортой байдлын үнэлгээ хийдэг болох
- БЭМ төлөвлөгөө боловсруулахын өмнө бэлчээрийн нөөц даацын судалгаа хийх
- Дэд төслүүдийн хэрэгжилт үр нөлөөг иргэдэд тайлагнах
- Сумын БОХУБ-ыг БОНХМТ-ний хэрэгжилтэд хяналт мониторинг хийх чадвартай болгон сургах

Оролцогчдын гаргасан саналуудаас БОНХМТ болон ҮЦОДТ-өөнд хамааралтай асуудлуудыг доорх байдлаар нэгтгэн гаргав. (Хүснэгт Е-2.3)

Хүснэгт E2.3.Улаанбаатар хотод болсон хэлэлцүүлэгт оролцогчдын санал санал

Хэлэлцүүлэг хийсэн огноо	Хэлэлцүүлэг хийсэн газар	Оролцогчид	Хэлэлцүүлэгт оролцсон талууд, төлөөлөгчдийн санал, дүгнэлт	ТА-3 төслийн Нэмэлт санхүүжилтийн төслийн төлөвлөлт, хэрэгжүүлэлтийн явцад эдгээр асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар гаргасан санал
2020 оны 1 сарын 15	Улаанбаатар хот, Корпорейт энд Конвеншн төв тод	Нийт 25 хүн ТА-3 төслийн ТХН-ийн ажилтнууд, Баяг-Өлгий, Дундговь, Төв, Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын ажилтнууд, зарим сумдын захиргаа, орон нутгийн иргэдийг төлөөлөл. Нэрсийг хавсаргав.	<ul style="list-style-type: none"> Хавар намрын хуурайшилттай улиралд бэлчээр хадлангийн газарт түймэр гарч байгаль бэлчээрт хохирол учруулдаг 	<ul style="list-style-type: none"> БЭМТ-нд бэлчээрийг түймрээс урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээг тусгах
<ul style="list-style-type: none"> Аялал жуулчлалын газар болон төв замын дагуу ариун цэврийн байгууламж байхгүйгээс бохирдол бий болох Хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах асуудал байхгүйгээс хаягдлын хэмжээ нэмэгдэх Сумын төв суурин газрын хог хаягдлын цэг шаардлага хангахгүй байгаагаас агаарын болон хөрс усны бохирдол үүсэж байна Малын бууц, барилгын хог хаягдлыг хаях цэгүүдийн байршлыг нарийн тогтоож, тохижуулах асуудал нэн шаардлагатай байна. Хог хаягдлын цэгийн байршил тодорхойгүй, буруу газар байрласнаас үүдэн хөрс, ус, агаарын бохирдол үүсгэдэг. 			<ul style="list-style-type: none"> ТА төслийн хүрээнд ОНХС-аас аялал жуулчлалын дэд бүтцийг дэмжихдээ хог хаягдлын менежмент, ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу сайжруулахад чиглэсэн үйл ажиллагааг илүү дэмжих Хог хаягдлын менежментийг холбогдох хууль, тогтоомж, стандартын дагуу явуулж байгаад тавих хяналтыг сумдын БОХУБ хариуцан зохион байгуулах ТА төслийн хүрээнд ОНХС-аас дэмжих төслүүдэд хог хаягдлыг ялган ангилах, дахин ашиглах шаардлага тавьдаг болох 	
<ul style="list-style-type: none"> Хадлангийн талбайг их хэмжээтэй хашиж хамгаалах тохиолдолд зэрлэг амьтан нүүдэллэх боломж алдагдах 			<ul style="list-style-type: none"> Сумын БЭМТ-нд хадлангийн талбайн байршлыг тодорхой тусгаж хашилгүйгээр хамгаалах арга хэмжээг тусган зохион байгуулах асуудлыг нэмж оруулах. 	
<ul style="list-style-type: none"> Бие засах газар арун цэврийн байгууламжууд шаардлага хангахгүй байгаагаас хөрсний болон ундны усны эх үүсвэр бохирдох 			<ul style="list-style-type: none"> ОНХС-аас санхүүжүүлэх аливаа байгууламжуудын дэргэд бие засах газар ариун цэврийн байгууламж, бохир ус зайлуулах, цэвэрлэх асуудлыг хэрхэн шийдвэрлэхийг тусгаж хэрэгжүүлдэг байх. 	
			<ul style="list-style-type: none"> Булаг шандыг хашиж хамгаалах, ундаргыг сэргээх ажлыг нарийн зураг төсөлгүйгээр хийж байгаа нь тухайн булгийн ундаргыг ширгээх, сөрөг нөлөөлөх боломж бий болгож байна. 	<ul style="list-style-type: none"> Булаг шандыг хашиж хамгаалах, ундаргыг сэргээх үйл ажиллагаанд БОНБУ хийж ажлын зураг төсөл тооцоог тусгайлан хийдэг байх.

		<ul style="list-style-type: none"> • Аймгийн болон сумын ЗДТГ-ын холбогдох мэргэжилтнүүдийг байгаль орчны үнэлгээ, Мониторингийн чиглэлээр дахин сургах шаардлагатай байна • ЗДТГ-ын ажилтнуудыг байгаль орчны болон нийгмийн нөлөөллийг үнэлэх аргачлалд сургах • Энэ онд бүх сумын ИТХ шинээр сонгогдох учраас шинээр томилогдох Засаг дарга, Багийн ИНХ-ын дарга, Багийн засаг дарга нарыг сургалтад хамруулж ТА төслийн талаар мэдээлэл ойлголт, аргазүйг нь сайжруулах шаардлагатай • ТА-3 төслийн хүрээнд байгаль орчин нийгмийн хамгааллын сайжруулах талаар хуримтлуулсан сайн туршлагыг дэлгэрүүлэх 	<ul style="list-style-type: none"> • БОНХМТ ба ҮЦОДТ-нд сургалтын хуваарь төлөвлөгөөг нэмж тусгах • Мэргэжилтнүүд, удирдлага, албан тушаалтнуудад зориулсан чадавхжуулах сургалтыг хийхдээ тэр сурсан ажилтан иргэд малчдадаа сургалт зөвлөгөө өгөх чадвартай болтол нь сургах хэрэгтэй байна.
--	--	--	--

Хүснэгт E2.4. Улаанбаатар хотод хийсэн хэлэлцүүлэгт оролцогчдын нэр

№	Нэр	Сумын нэр	Албан тушаал	Утас
1	М.Энхбат	Улаанбаатар	ТА-3,ТХН-ийн мэргэжилтэн	99996838
2	Г.Одсүрэн	Улаанбаатар	ТА-3 ТХН-ийн мэргэжилтэн	88098020
3	А.Мөнхбаяр	Улаанбаатар	ТА-3 ТХН-ийн мэргэжилтэн	88058877
4	Б.Үржинханд	Дундговь аймаг	ЗДТГ, ҮХҮА-ны дарга	88593230
5	С.Хулан	Дундговь аймаг	ЗДТГ, Нийгмийн бодлогын мэргэжилтэн	99059830
6	Ж.Түмэндэлгэр	Дундговь аймаг	ИТХ-ын ахлах ажилтан	99049453
7	Э.Уянга	Дундговь аймаг	БОАЖГ-ын мэргэжилтэн	88138901
8	Б.Энхтуяа	Дундговь аймаг	ТА-3 зохицуулагч	99038493
9	Ж.Мөнхсаруул	Дундговь аймаг	ЗД-ын орлогч	88090107
10	С.Эрдэнэцогт	Төв аймаг	БОАЖГ-ын мэргэжилтэн	88044188
11	Б.Тунгалаг	Төв аймаг	ЗДТГ-ын мэргэжилтэн	96007737
12	Г.Болдбаатар	Төв аймаг	Алтанбулаг сум, Баг ЗД	88076792
13	Л.Эрдэнэбаатар	Төв аймаг	Эрдэнэ сум, Засаг дарга	99258698
14	Н.Батмөнх	Төв аймаг	Алтанбулаг сум, ИТХ-ын дарга	96620375
15	Ц.Отгонтулга	Сэлэнгэ аймаг	ЗДТГ-ын ажилтан	99172704
16	Т.Пүрэвсүрэн	Сэлэнгэ аймаг	ИТХ-ын НБ дарга	99499682
17	Н.Эрдэнэсүрэн	Сэлэнгэ аймаг	БОАЖГ-ын мэргэжилтэн	99156434
18	Н.Захиралбаатар	Сэлэнгэ аймаг	Хушаат сум, ЗДТГ-ын дарга	99074351
19	Б.Ганзориг	Сэлэнгэ аймаг	иргэн	91631099
20	Э.Мөнх-Од	Сэлэнгэ аймаг	Баруунбүрэн сумын иргэн	89131320

21	Д.Майра	Баян-Өлгий	ЗДТГ-ын НБ мэргэжилтэн	99425109
22	Т.Ариунцэцэг	Баян-Өлгий	ЗДТГ-ын байгаль орчны мэргэжилтэн	99425600
23	А.Сэрыкболат	Баян-Өлгий	ИТХ-ын НБ-ийн дарга	99422455
24	А.Ерболат	Баян-Өлгий	ЗДТГ-ын мэргэжилтэн	94981727
25	Г.Гансүх	Улаанбаатар	Үндэсний зөвлөх	99159694

Мэдээллийг ил тод болгосон:

Энэхүү төлөвлөгөөг дараах байдлаар нээлттэй болгосон:

1.Бүх аймгууд дахь төслийн оффист байрлуулах зорилгоор аймгууд дахь төслийн зохицуулагчдад 2020 оны 1 сарын 20-ны өмнө Е-мэйлээр явуулсан.

2.Улаанбаатар хот, Аймгуудын номын сан, Иргэний танхимд 2020 оны 1 дүгээр сарын 28-нд олон нийтэд нээлттэй ил тод тавьж байрлуулсан.

3.www.slp.mn. Вебсайтад тавьсан

4.АЧББ-ийн болон БЭМ-ийн ажлын хэсгийн гишүүдэд е-мэйлээр явуулсан.

ХАВСРАЛТ 1.

ОНХС-аас санхүүжүүлэх БЭМ-ийн үйл ажиллагаанд Байгаль Орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийхэд баримтлах шалгуурууд

Нэр томьёо

(Монгол Улсын Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд заасны дагуу 2008 он)

"Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ" гэдэг нь тухайн иргэн, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, үйлчилгээнээс байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүний нөлөөллийг бууруулах арга хэмжээг бий болгох үйл явцыг хэлнэ.

Ерөнхий үнэлгээ гэдэг нь төлөвлөлтийн эхэн үеийн хууль эрх зүйн зохицуулалт, судалгааны материал, технологи, стандарт, хэм хэмжээ, анхан шатны тоон мэдээлэлд үндэслэн хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг урьдчилан тодорхойлох; сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах үндсэн арга хэмжээг тодорхойлох, үүний хэрэгжилтийн зохих арга хэрэгслийг санал болгох үйл явц юм.

Нарийвчилсан үнэлгээ нь арга зүйн болон эдийн засгийн үндэслэлийг боловсруулах, ажлын төлөвлөгөө, төслийг боловсруулах шатанд үүсэж болзошгүй сөрөг нөлөөлөлд тулгуурлан үйл ажиллагааны улмаас учирсан нөлөөллийн цар хүрээ, хэмжээ, хохирлыг тооцох; сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах хамгийн оновчтой арга хэмжээ, технологийг бий болгох.

БЭМ-ийн үйл ажиллагаанд тавигдах Байгаль Орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний заавар

Бэлчээрийн эрсдэлийн менежментийн үйл ажиллагаа нь орон нутгийнхны амьжиргаанд сөргөөр нөлөөлж буй байгаль орчны, санхүүгийн, нийгмийн болон бусад төрлийн эрсдэлийг зохицуулах чадварыг малчид болон хөдөөгийн өрхүүдэд эзэмшүүлж дээшлүүлэх зорилготой. Эдгээр үйл ажиллагаанууд нь аймаг, сумдын захиргааны байгууллага, малчид, зөвлөхүүдийн оролцоонд үндэслэн бэлчээрийн менежмент болон эрсдэлийн менежментийн төлөвлөгөө боловсруулахад чиглэгдэж байгаа бөгөөд байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийхэд орон нутгийн чадавх шаардагдах болно

I. Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ нь дараах зүйлсийг агуулна:

- Үйл ажиллагааны тодорхойлолт:
 - Үйл ажиллагааны нэр;
 - Үйл ажиллагааны зорилго;
 - Түүхий эд болон бусад нэмэлт материал;
 - Бүрэн боловсруулсан болон хагас боловсруулсан бүтээгдэхүүний төрөл;
 - Бий болсон чадавх;
 - Ашигласан технологи, тоног төхөөрөмж

- Үйл ажиллагааны байршил:

- Аймаг, сум, хороо;
 - газарзүйн бүс;
 - газарзүйн координатууд;
 - үйл ажиллагаа явж буй газар;
 - хүрээлэн буй орчны зураг төсөл
- Сонгогдсон газруудын байгаль орчны анхны төлөв байдал
 - газрын төрөл;
 - Тусгай хамгаалалттай газар;
 - Цаг уур, уур амьсгалын шалгуур;
 - Гадаргын усны нөөц, чанар, горим, бохирдол;
 - Геоморфологи, ландшафт;
 - геологийн тогтоц;
 - гидрогеологийн тогтоц, гүний усны нөөц, чанар, горим, бохирдол;
 - криогенийн нөхцөл байдал;
 - геотехникийн нөхцөл байдал;
 - газар хөдлөлт;
 - хөрсний бүтэц, элэгдэл, газрын хөрс, бохирдол;
 - ойн нөөц;
 - ургамлын төрөл зүйл, биологийн олон янз байдал;
 - амьтны аймгийн байршил, тархац;
 - бэлчээр, тэжээлийн талбай, нөөц;
 - агаарын бохирдол;
 - сонгогдсон газарт явуулах бусад үйл ажиллагаанууд
- Сөрөг нөлөөлөл-байгалийн нөөцийн хомсдол;
 - бодисын нөөцийн хомсдол;
 - ашигт малтмал, түүхий эдийн нөөцийн хомсдол;
 - усны нөөц, горим, чанарын өөрчлөлт, бохирдол;
 - ойн нөөцийн хомсдол;
 - хөрс эвдрэл, бохирдол;
 - амьтны аймгийн нөөцийн хомсдол, байршил болон тархалт өөрчлөгдөх;
 - цаг уурын өөрчлөлт, агаарын бохирдол;
 - ургамлан бүрхэвч устах, биологийн төрөл зүйлийн хомсдол
- Дэд бүтцийн хөгжил:
 - эрчим хүч, цахилгаан хангамж;
 - усан хангамж;
 - бохир ус зайлуулах, цэвэрлэх систем;
 - хог хаягдлын далан;
 - тээвэр;
 - шуудан, харилцаа холбооны хэрэгсэл;
 - үйлдвэрийн байгууламжууд;
 - Үйлчилгээний төвүүд / ресторан, халуун ус, хувцас угаалгын газар

- Нийгэм эдийн засгийн асуудлууд;
 - ажиллах хүчний тоо хэмжээ;
 - ажиллах хүчний эх үүсвэр;
 - Ажилчдын хөдөлмөрийн аюулгүйн байдал;
 - байр, нийгмийн асуудал;
 - хүн амын эрүүл мэндийн асуудал;
 - Олон нийтийн эрүүл мэнд;
 - халдварт өвчний тархалт
 - ажлын байрны нөхцөл байдлаас үүдэлтэй өвчлөлийн түвшин;
 - Хоол хүнсний хангамж;
 - Орон нутгийн орлого нэмэгдэх;
 - Хүн амын орлого нэмэгдэх;
 - Ажлын байр нэмэгдэх;
 - Ядуурал буурах;
 - хүн ам зүйн шилжилт хөдөлгөөн
- Түүх соёлын өв:
 - сүйтгэгдсэн, эвдэрсэн өв
- Археологи, палеонтологийн олдворууд:
 - сүйтгэгдсэн, гэмтсэн олдворууд
- Хог хаягдлын менежмент:
 - хатуу хог хаягдлын хадгалалт, тээвэрлэлт, устгал;
 - шингэн хог хаягдлыг хадгалах, цэвэрлэх, зайлуулах;
 - хог хаягдлыг дахин боловсруулах;
- Тусгай хог хаягдлын менежмент:
 - химийн бодис импортлох, тээвэрлэх, хадгалах, ашиглах, саармагжуулах, идэвхгүйжүүлэх, устгах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;
 - Хог хаягдлыг тээвэрлэх, хадгалах, ашиглах, хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангах;
 - түлш болон тосолгооны материалыг тээвэрлэх, хадгалах, галын даатгал - тэсрэх материалыг тээвэрлэх, хадгалах, хамгаалах, ашиглах, аюулгүйн горим.
- Доройтсон хөрсөнд нөхөн сэргээлт хийх:
 - доройтсон газрын гадаргууг тэгшлэх, нөхөн сэргээх, хөрсний гадаргууг сэргээх, зүлэгжүүлэх, ургамалжуулах

II. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний арга

Хүмүүс, аж ахуйн нэгжүүдийн явуулж буй аливаа үйл ажиллагааны байршил, төлөвлөлт, хамрах хүрээ, технологи, тоног төхөөрөмж, байгалийн нөөц ашиглалт, түүхий эд болон бүрэн боловсруулсан бүтээгдэхүүн зэргүүдээс үүдэн байгаль орчинд нөлөөлөл үзүүлж болно.

Үйл ажиллагааны улмаас дараах нөлөөллийн төрлүүд үүсдэг:

- Эерэг болон сөрөг, шууд болон шууд бус нөлөөлөл;
- Бага, дунд болон их хэмжээний нөлөөлөл;
- Тохиромжтой, тохиромжгүй байршил;
- Богино, урт, дунд хугацааны, үргэлжилсэн хугацааны нөлөөлөл;
- Бүрэн бус болон цогц үнэлгээ;
- Нийгэм, эдийн засгийн хувьд эерэг ба сөрөг нөлөө;
- Орон нутгийн болон бүс нутгийн нөлөөлөл;

Арга зүйг сонгох шалгуур:

- ойлгоход хялбар, үр дүнтэй шийдвэр гаргахад шаардлагатай, системчилсэн мэдээллийг цуглуулдаг;
- үнэлгээний явцад өөрчлөлт, сайжруулалт хийхэд хангалттай уян хатан чанартай;
- өргөн хэмжээний мэдээлэл нь нэгтгэн дүгнэх боломжийг олгодог;
- Нөлөөлөлд тоон дүн шинжилгээ хийхэд илүү нарийвчлалтай мэдээллээр хангасан;
- цуглуулсан мэдээллийг ашиглан дүгнэлт хийх боломжтой;
- дутагдаж буй мэдээллийг орлуулах боломжтой;
- урьдчилан таамаглах боломжтой;
- өвөрмөц шинж чанар, онцлог, олон талт байдлыг тодорхойлсон;
- хугацаа, байршил, хамрах хүрээний дагуу нягт харилцан уялдааг бий болгох боломжтой
- арга зүй нь олон тооны харьцуулалт, сонголт хийх боломжийг олгоно;
- хандлага болон чиглэлийг системчлэх, дүгнэх боломж.

Аливаа үнэлгээний арга нь давуу болон дутагдалтай талтай байдаг учраас үнэлгээний зорилго, хамрах хүрээ, цаг хугацаанаас хамаарч зөв аргуудыг сонгож, өөр хооронд нь хослуулах нь үр дүнтэй.

ХАВСРАЛТ 2.Орон нутгийн Хөгжлийн Сангийн төслүүдэд Хяналт шинжилгээ хийх маягт

Дэд төслийн талаарх мэдээлэл	
Дэд төслийн дугаар	
Дэд төслийн нэр	
Дэд төслийг хэрэгжүүлэгч	
Сумын байгаль орчны байцаагч, холбоо барих утас, хаяг	
Төслийг хэрэгжүүлэх газрын байршил (координатын цэгүүд бүхий)	
Төслийн зориулалт, ангилал (товч тодорхойлолт, барилгын ажил, үйл ажиллагааны тухай. Шаардлагатай бол зураг хавсаргах):	

Хяналтын хуудас “А” маягт

Энэ хэсгийг ОНХСангаас санхүүжилт авах аливаа төслүүд энэхүү хяналтын хуудсыг бөглөх болно.

<i>Асуултууд (Төслийн явцад барих барилга байгууламжийн болон ашиглалтын үе шатыг харгалзан үзэх)</i>	<i>Тийм/Үгүй</i>
A.1 Төслийг хэрэгжүүлэхэд байгалийн нөөц, ус, эрчим хүч их хэмжээгээр ашиглах эсэх?	
A.2 Төслийг хэрэгжүүлэхэд газар шорооны ажил, шинээр газрыг хөндөж ашиглах эсэх?	
A.3 Төсөл хэрэгжүүлэх газар нь экологийн, түүхэн болон соёлын ач холбогдолтой барилга байгууламж, газар нутагтай ойролцоо байдаг эсэх ?	
A.4 Төсөл бүхэлдээ эсхүл аль нэг хэсэг нь хувийн эзэмшлийн газарт хэрэгжих эсэх?	
A.5 Төсөл нь газар, усан орчин, агаар мандалд бохирдол гаргах эсэх?	
A.6 Төсөл нь дуу чимээ, тоос гаргаж оршин суугчдын аж байдалд сөрөг нөлөө үзүүлэх эсэх?	
A.7 Төсөл нь газар тариалан, мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй холбоотой эсэх?	
A.8 Төсөл нь хүмүүсийн ажил, амьдралд сөрөг нөлөө учруулж болзошгүй эсэх?	
A.9 Төсөл нь байгаль дахь усны эргэлт (тухайлбал, усны урсац, шингэц, газрын доорх болон гадаргын усанд) нөлөө үзүүлэх эсэх ?	
A.10 Иргэд нийтийн эзэмшлийн зам талбай, байгууламжид хүрч очиход төсөл нь саад болох эсэх?	
A.11 Төсөл нь нутгийн иргэдийн орлого болон амьжиргаанд сөрөг нөлөө үзүүлэх эсэх ?	
A.12 Төсөл нь аюултай болон бохирдуулагч бодис (химийн бодис , гидрокарбон, пестицид гэх мэт) ашиглах эсэх?	

Тэмдэглэл: Хэрэв дээрх асуултуудын аль нэгэнд “ТИЙМ” гэж хариулах тохиолд хяналтын хуудасны “Б” хэсгийг бөглөх болно. Хэрэв бүх хариултууд “Үгүй” байх тохиолд төсөлд цаашид байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзэж болно.

Хяналтын хуудас “В” хэсэг (Төслийн баримт бичгийн мэдээлэлд тулгуурлана)

Энэхүү маягтыг сумын байгаль орчны ажилтан бөглөж сумын Засаг даргаар батлуулна. Төслийн байгаль орчинд учрах эрсдэл болон болзошгүй нөлөөллийг доорх шалгуур үзүүлэлтүүдийг байгаль орчны ажилтан харгалзан үзнэ. Үүнд:

- Төслийн чухал байдал (их , бага, дунд) хэр зэрэг болох
- Хамрах хүрээ (тухайн газраар, орон нутгийн хэмжээтэй эсвэл аймгийн хэмжээнд эсэх) аль хэр болох
- Үргэлжлэх хугацаа (богино, дунд, урт хугацаанд) хамрах болох
- Үйл ажиллагааны байгаль орчинд үзүүлэх эерэг сөрөг чиг хандлага
- Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл хэр зэрэг болох
- Нөхөн сэргэх чадвар хэр болох

1-р хэсэг – Төслийн хэмжээ ба хамрах хүрээ			
Анхаарах асуудлууд	<i>Товч тодорхойлолт</i>	<i>Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл байгаа эсэх, тийм/үгүй?</i>	<i>Цаашид сайжруулах ямар арга хэмжээ авах шаардлагатай болох?</i>
1.1 Төсөл хэрэгжүүлэх газрын талбайн хэмжээ, зам, дэд бүтцэд хүрэх боломж бий эсэх?			
1.2 Төслийг хэрэгжүүлэхэд их хэмжээний эрчим хүч, ус, байгалийн баялаг шаардагдах эсэх?			
1.3 Төслийг хэрэгжүүлэхэд ихээхэн ажиллах хүч шаардагдах эсэх?			
1.4 Төслийг хэрэгжүүлэхэд (эхлүүлэх, үйл ажиллагаа явуулах, дуусгах үе шатыг хамруулан) цаг хугацааны хүрээг авч үзэх?			

2-р хэсэг – Төслийн төлөв байдал			
Анхаарах асуудлууд	<i>Товч тодорхойлолт (байгаа эсэх?)</i>	<i>Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл байгаа эсэх, тийм/үгүй?</i>	<i>Цаашид сайжруулах ямар арга хэмжээ авах шаардлагатай болох?</i>
2.1 Төслийн хүрээнд ямар барилга байгууламж баригдах болох?			
2.2 Төслийн үйл ажиллагаа нь тухайн орон нутагт цоо шинэ ажил болох эсэх?			
2.3 Төслийн үйл ажиллагаа нь соёлын болон түүх дурсгалтай холбогдох барилга, байгууламж, газар орчинд нөлөө үзүүлэх эсэх?			
2.4 Төслийн үйл ажиллагаа нь байгалийн аялал жуулчлал, амралт зугаалгын бүсэд хамаатай эсэх?			
2.5 Төслийн хүрээнд нийтийн эзэмшлийн дэд бүтцийн барилга байгууламжийг засах, шинэчлэх эсэх?			
2.6 Төслийн үйл ажиллагаа нь аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаатай хэр холбоотой болох?			
2.7 Төслийн хүрээнд хүнс болон ургамлан түүхий эд боловсруулах, үйлдвэрлэх үйл ажиллагааг явуулах эсэх?			
2.8 Төслийн хүрээнд амьтан барих, авлах, ургамал түүж байгалийн баялаг ашиглах ямар нэгэн үйл ажиллагаа явуулах эсэх?			
2.9 Төслийн үйл ажиллагаанд ажиллах хүч олноор авч ажиллуулах, хүнд даацын машин механизм, боловсруулах агрегатуудыг ашиглах эсэх?			
2.10 Төслийн үйл ажиллагаанд нэг болон хэд хэдэн газар эзэмшигч хамтран оролцох эсэх, зориуд анхаарахуйцаар газрын маргаан гарч болох эсэх? Тодорхой зорилтот бүлэг болон эмэгтэйчүүд үр ашгийг нь хүртэх эсэх?			

3-р хэсэг – Төсөл хэрэгжүүлэх газар			
Энэ хэсэгт төслийн хүрээнд барилга байгууламж барьж байгуулахтай холбоотой асуудлууд хамраагдах болно.			
Анхаарах асуудлууд	<i>Товч тодорхойлолт (байгаа эсэх?)</i>	<i>Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл байгаа эсэх, тийм/үгүй?</i>	<i>Цаашид сайжруулах ямар арга хэмжээ авах шаардлагатай болох?</i>
3.1 Төсөл хэрэгжүүлэх газар нь байгалийн гамшигт нэрвэгдэх эрсдэл байгаа эсэх?			
3.2 Төсөл хэрэгжүүлэх газар нь эмнэлэг, сургууль, түүх, соёл, археологийн барилга байгууламж, ямар нэгэн газар нутагт ойролцоо байх эсэх?			
3.3 Төслийн үйл ажиллагаа нь одоогийн газар ашиглалт, усан ашиглалтын харилцаанд нөлөө үзүүлэх эсэх?			
3.4 Төсөл хэрэгжүүлэх газар нь хамгаалалттай бүс нутаг, ойн сангийн газарт байгаа эсвэл ойр зэргэлдээ байх эсэх?			
3.5 Төслийг хэрэгжүүлэх газар нь хувийн эзэмшлийн газар эсэх? Хувийн эзэмшлийн газарт төслийн үйл ажиллагааг явуулж үр дүнд хүрнэ гэж үзэж байна уу? Энэ талаар талууд хэлэлцэн тохиролцсон уу?			
4.6 Төсөл хэрэгжүүлэх газарт газрын сангийн тусгай ангиллын бүсүүд (хамгаалалтын, төв суурины, үйлдвэрлэлийн бүс гэх мэт) шинээр бий болох магадлал бий эсэх?			

4-р хэсэг – Байгаль орчны болон нийгмийн нөлөөллүүд

<i>Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд</i>	Анхаарах асуудлууд	<i>Товч тодорхойлолт (байгаа эсэх?)</i>	<i>Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл байгаа эсэх, тийм/үгүй?</i>	<i>Цаашид сайжруулах ямар арга хэмжээ авах шаардлагатай болох?</i>
4.1 Газрын хэв шинж, геологи ба хөрсний нөхцөл	4.1.1 Төслийн үйл ажиллагаа нь газар нутгийн ландшафтын төрх, геологийн тогтцыг өөрчлөх эсэх?			
	4.1.2 Хөрс бохирдуулах болон урьд өмнө бохирдсон хөрсийг төслийн үйл ажиллагааны явцад хөндөж ухах эсэх?			
	4.1.3 Эвдрэл элэгдэлд амархан орох эмзэг хөрсийг төслийн явцад ухаж хөндөх эсэх?			
	4.1.4 Тогтворшил муутай эгц налуу хажуу гаргах зэрэг арга хэмжээг авах эсэх?			
	4.1.5 Төслийн хүрээнд нуурын ёроол, голын голдирлыг өөрчлөх ямар нэгэн үйл ажиллагаа явуулах эсэх?			
4.2 Ус	4.2.1 Хүн амын усан хангамжийн усны чанар, хэмжээнд сөрөг нөлөө үзүүлэхүйцээр усан ашиглалт, боловсруулалтын үйл ажиллагаа явуулах эсэх?			
	4.2.2 Төслийн үйл ажиллагаа нь усны урсцыг таслан ухаж өрөмдөн хөрсөөр дамжуулан усыг бохирдуулах эсэх?			
	4.2.3 Цэнгэг усны урсац, голдирлыг өөрчлөх ямар нэгэн үйл ажиллагааг явуулах эсэх?			
	4.2.4 Голын усны урсцын хэмжээ, усны шингэлтэд ямар нэгэн өөрчлөлт оруулах уу?			
	4.2.5 Гол горхины усны үерлэлтэд төслийн үйл ажиллагаа нөлөөлөх үү?			
4.3 Агаар	4.3.1 Төслийн үйл ажиллагаанаас агаар орчинд тоос гаргах уу?			
	4.3.2 Төслийн үйл ажиллагаанаас аюултай, хортой бохирдуулагч бодис агаар орчинд ялгаруулах уу?			
	4.3.3 Хүлэмжийн хийн ялгаруулалтад орон нутгийн болон бүс нутгийн хэмжээнд их, бага ямар нөлөө			

<i>Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд</i>	Анхаарах асуудлууд	<i>Товч тодорхойлолт (байгаа эсэх?)</i>	<i>Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл байгаа эсэх, тийм/үгүй?</i>	<i>Цаашид сайжруулах ямар арга хэмжээ авах шаардлагатай болох?</i>
	үзүүлэх ?			
4.4 Дуу чимээ	4.4.1 Хүн ам болон амьтанд сөрөг нөлөө үзүүлэх дуу чимээ хэт нэмэгдэх эсэх?			
4.5 Ургамал	4.5.1 Ургамлан бүрхэвчийг гэмтээх ба устгах үйл ажиллагаа явуулах?			
	4.5.2 Эмийн, гоо сайхны, үйлдвэрлэлийн ач холбогдолтой болон ховор, ховордсон зүйлийн чухал ургамлыг гэмтээх, устгах үйл ажиллагаа явуулах?			
	4.5.3 Газар тариалангийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн бүтээмж бууруулах нөлөө үзүүлэх үйл ажиллагаа явуулах?			
	4.5.4 Гадны уугуул бус төрөл зүйлийн ургамал тарьж ургуулах үйл ажиллагаа явуулах эсэх.			
	4.5.5 Уугуул бус хөнөөлт зүйлийн ургамал тарьж ургуулах үйл ажиллагаа явуулах эсэх.			
4.6 Амьтан	4.6.1 Ховор, ховордсон амьтны төрөл зүйлийн тоо толгойд ямар нэгэн нөлөө үзүүлэх эсэх?			
	4.6.2 Малын тоо толгойн өсөлтөд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэх эсэх?			
	4.6.3 Төсөл хэрэгжүүлэх газар нутгийн амьтны аймгийн амьдрах орчинд ямар нэгэн сөрөг нөлөө үзүүлэх.			
	4.6.4 Төсөл хэрэгжүүлэх газар нутгийн ан амьтдын нүүдэл, шилжилт хөдөлгөөнд саад учруулах.			
	4.6.5 Төслийн хүрээнд гадны уугуул бус амьтдыг үржүүлэх, үйлдвэрлэл явуулах.			
	4.6.6 Гадны хөнөөлт төрөл зүйлийн амьтдыг оруулж ирэх, халдварт өвчин тараах нөхцөл бий болгох.			
4.7 Байгалийн нөөц	4.7.1 Байгалийн нөөц баялаг, модон болон эрдэс түүхий эд, усны нөөцийг ашиглах ба боловсруулах үйл ажиллагаа явуулах.			
	4.7.2 Төсөл хэрэгжих явцад аливаа байгалийн			

<i>Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд</i>	Анхаарах асуудлууд	<i>Товч тодорхойлолт (байгаа эсэх?)</i>	<i>Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл байгаа эсэх, тийм/үгүй?</i>	<i>Цаашид сайжруулах ямар арга хэмжээ авах шаардлагатай болох?</i>
	баялгийн ашиглах хэмжээ эрс нэмэгдэх эсэх?			
	4.7.3 Төсөл хэрэгжих явцад нөхөн сэргэгдэхгүй байгалийн баялгийн нөөц багасах эсэх?			
4.8 Хүн ам	4.8.1 Төслийн хүрээнд суурьшлын бүс болон хувийн эзэмшлийн газарт дэмжлэг үзүүлж буй эсэх?			
	4.8.2 Төсөл хэрэгжүүлэх газар нутагт гаднаас ажиллах хүч шилжүүлэн ирүүлж ажиллуулах эсэх?			
	4.8.3 Гаднаас ажиллах хүч шилжүүлэн ирүүлж ажиллуулахад нэмэлт орон сууц шаардлагатай эсэх?			
	4.8.4 Төсөл хэрэгжсэнээр замын хөдөлгөөн, дуу чимээ, тоос зэрэг аюул эрсдэл нэмэгдэх эсэх?			
	4.8.5 Төсөл хэрэгжих явцад эрчим хүч, усан хангамж харилцаа холбоо, хог хаягдал, цэвэрлэх байгууламж, сургууль, эмнэлгийн үйлчилгээнд сөрөг нөлөөлөх, ачаалал нэмэгдэх эсэх?			
4.9 Албадан суурьшуулах	4.9.1 Төслийн бүхий л ажилд биеийн хүчний ажлууд хийгдэх үү?			
	4.9.2. Төслийн хүрээнд газар ашиглалтын өөрчлөлттэй холбоотойгоор биеийн хүчний ажил хийгдэх үү?			
	4.9.3. Хэрэв нийтийн эзэмшлийн газарт биеийн хүчний ажил хийгдэх тохиолд тэрхүү газрыг хэн нэгэн хүн авч ашиглах болох эсэх?			
	4.9.4. Хувийн эзэмшлийн газар дээр биеийн хүчний ажил хийлгэж болох эсэх? Are any physical works sited on private land? Зах зээлд суурилсан түрээс, худалдан авалт ба хандиваас гадна арга хэрэгсэл ашиглан газрыг авах төлөвлөгөө бий эсэх?			
	4.9.5. Байгалийн нөөц баялаг, газар ашиглахтай холбоотой хориглосон тохиолдлоос бусад нөхцөлд биеийн хүчний ажил төслийн явцад хийлгэх эсэх?			
	4.9.6. Хувийн эзэмшлийн газрын 10-аас илүү хувьд биеийн хүчний хөдөлмөр эрхлүүлэх шаардлага байгаа			

<i>Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд</i>	Анхаарах асуудлууд	<i>Товч тодорхойлолт (байгаа эсэх?)</i>	<i>Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл байгаа эсэх, тийм/үгүй?</i>	<i>Цаашид сайжруулах ямар арга хэмжээ авах шаардлагатай болох?</i>
	эсэх?			
	4.9.7. Төслийн явцад хүн амын суурьшлын болон үйлдвэрлэлийн байгууламжийг буулгаж нураахад биеийн хүчний ажил эрхлүүлэх эсэх?			
4.10 Соёлын өв	4.10.1 Төслийн үр дүнд соёлын өвийн барилга байгууламж, сонирхол татахуйц газрын нөхцөл байдал сайжрах эсэх?			
	4.10.2 Төслийн төлөвлөлт, үйл ажиллагаанд барилга байгууламж, сонирхол татахуйц газрын даац, чадавхыг үнэлж харгалзаж үзсэн эсэх?			
	4.10.3 Төслөөс оюуны өмч, биет бус соёлын өвийн үнэ цэнд ямар нэгэн нөлөө үзүүлэх эсэх?			
4.11 Үндэстний цөөнх	4.11.1 Үндэстний цөөнх хүмүүс төсөл хэрэгжих газарт амьдарч нөөц баялгийг ашиглаж буй эсэх? Тэдгээр нь төслийн үр шимийг хүртэгчид байх уу? Төслийн үр шимийг хүртэгчийн хувьд цөөнх байх уу эсвэл үр шимийг үл хүртэгсэд байх уу?			
	4.11.2 Төсөл хэрэгжүүлэх газарт үндэстний цөөнхүүд газар эзэмшигчид байх уу?			
	4.11.3 Төсөл хэрэгжих явцад үндэстний цөөнхийн соёлын өв, оюуны өмч болон амьдрах онцлог нь эмзэг асуудал байх эсэх?			

5-р хэсэг: Нэгдсэн үнэлгээ

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ шаардлагагүй

Төсөлд Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ хийлгэхээр аймгийн Байгаль орчны газарт өргөн барих

Цаашид төслийг сайжруулах эсвэл ОНХСангийн төсөл хэрэгжүүлэх нэгжээс зөвлөгөө авах.

Аймаг, сумын нэр:

Байгаль орчны ажилтны нэр :

Телефон утасны дугаар :

E-Mail хаяг:

Гарын үсэг :

Он, сар, өдөр:

Зөвшөөрсөн: Сумын Засаг даргын нэр :

Гарын үсэг :

Он, сар, өдөр:

ХАВСРАЛТ 3. Байгаль Орчны Жил Бүрийн Аудит Хийх Ажлын Удирдамж

Даалгагдсан ажлын зорилтууд

Энэхүү даалгагдсан ажил нь Тогтвортой Амьжиргаа 3 төслийн байгаль орчны аудит хийх зорилготой бөгөөд байгаль орчны аудит хийхэд Монгол Улсын Засгийн Газрын шаардлагуудыг хангасан байх шаардлагатай. Тодруулбал:

- ОНХС-ийн хэрэгжилтийг удирдамжид заасан заалт, арга хэмжээ, Байгаль орчны үнэлгээнд тусгагдсан асуудлуудтай уялдуулах;
- Монгол орны сайжирсан болон доройтож буй бэлчээрт үзүүлэх бэлчээрийн мал аж ахуйн эрсдэлийн менежментийн ОНХС-ийн үйл ажиллагааны нөлөөллийн үзүүлэлтүүд.;
- ОНХС-тай холбоотой аймаг, сумдын байгаль орчны байцаагчдын байгаль орчны менежментийн үйл ажиллагаа.

Ажлын Хамрах Хүрээ

Дээрх зорилтыг биелүүлэхийн тулд хийх шаардлагатай үйл ажиллагаанд дараах зүйлс багтах бөгөөд зөвхөн эдгээр үйл ажиллагаануудаар хязгаарлагдахгүй болно:

- ТА 3 төслийн үйл ажиллагааг төлөвлөхөд оролцсон түвшин, уг төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал (байгаа эсэх)-ийг тодорхойлохын тулд аймаг, сумдын байгаль орчны мэргэжилтэн, байцаагчдын төлөөлөл болон Сумын ОНХС-ийн ажлын хэсгийн гишүүдээс ярилцлага авах. Нэмж дурдахад аймгийн байгаль орчны байцаагчийн ОНХС-нд хийсэн судалгааны ажлын тайланг боловсруулж, дүн шинжилгээ хийх.
- Монгол Улсын байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжийн шаардлагыг зохих ёсоор биелүүлэхийн тулд сумдын Засаг даргын Тамгын газраас бүх арга хэмжээг авсан эсэхийг тодорхойлох.
- Тухайлбал БОАЖЯ, Байгаль орчны асуудал хариуцсан ажилтан болон ОНХС-ийн ажилтнуудыг ОНХС-ийн үйл ажиллагаанд ялангуяа яам хоорондын бэлчээрийн менежментийн бүлэгт ямар оролцоотой байсныг тодорхойлохын тулд үндэсний хэмжээнд оролцогч талуудаас ярилцлага авах. Төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал байгаа эсэхийг тодорхойлох.
- Аймгийн байгаль орчны байцаагчдын өгсөн мэдээлэлд үндэслэн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаас үүсэх байгаль орчны сөрөг ба эерэг нөлөөллийг тодорхойлж, тэдгээрийг зохицуулах арга хэмжээг тодорхойлно. Бэлчээрийн газар нутагт худаг барьж байгуулахад гарч буй нөлөөлөлд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй бөгөөд үүнийг Байгаль Орчны талаар Банкны 4.04-т тусгасан "байгалийн амьдрах орчин" -ын нөхцөлийн хүрээнд үнэлэх хэрэгтэй.
- Байгаль орчин, нийгмийн менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, журмыг хэрэгжүүлэхэд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлох. Эдгээр бэрхшээл нь санхүүгийн эсвэл чадавх холбоотой байж болно.
- ТА 3 төслийн менежерүүд, БОАЖЯ-тай ярилцаж дээрх бэрхшээлүүдийг шийдэх практик арга хэмжээнүүдийг тодорхойлж, эдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхийн тулд Дэлхийн Банкны зөвшөөрөлтэйгөөр СОНХС, БОАЖЯ-ны гэрээний дагуу үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах.
- БОНХМТ-ний хэрэгжилтийн жилийн гүйцэтгэлийг үнэлж, ирэх онд сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг санал болгох.

- ТА 3 төслийн одоогийн туршлагад үндэслэн хүрээлэн буй орчны тойм судалгаа, тайлагнах арга хэмжээнүүдийг сайжруулах хувилбаруудыг санал болгох.

Хүлээгдэж Буй Үр Дүн

Зөвлөлдөх уулзалтын үр дүн нь дээрх ажлын хүрээнд тодорхойлсон асуудлууд тус бүрийн санал, дүгнэлтийг танилцуулсан байгаль орчны аудитын тайлан болно. Энэхүү тайлан нь Байгаль орчны тойм судалгаанд зориулсан БОАЖЯ-ны гаргасан удирдамж дээр суурилан гарах болно. Эдгээр тайлангуудыг Англи болон Монгол хувилбараар байлгах шаардлагатай.

Хуваарь болон Тайлан Мэдээ

Ажлын хуваарь:

Арга зүй, үнэлгээний хэрэгслүүдийг ТА төслийн нэгжтэй дотор зөвшилцсөн байх

- Үйл явцын тайлангдотор илгээсэн байх
- Зөвлөх эцсийн тайлангдотор илгээсэн байх
- ТА төслийн нэгж эцсийн тайланг зөвшөөрч, Англи хэлнээдотор орчуулагдсан байх

Тайлан мэдээ

Зөвлөх тайланг ТА төслийн нэгжийн зохицуулагчид өгнө.

Арга зүй

Даалгагдсан ажлыг дараах байдлаар гүйцэтгэнэ: (1) холбогдох төслийн баримт бичгүүдийн тойм болон холбогдох гадаад, дотоодын туршлагыг Улаанбаатар хотноо цуглуулах; (2) ТА төслийн нэгжтэй тохирсны дагуу түүврийн журмаар төлөөлөл болгож төсөлд хамрагдаж буй газруудад дөрвөн долоо хоногийн айлчлал хийж төсөлд хамрагдагчидтай ярилцлага өрнүүлж, оролцогч талуудтай нарийвчилсан зөвлөгөөнүүдийг хийнэ ; (3) Улаанбаатар хотноо төрийн албан хаагчид, төслийн менежерүүд, зөвлөх бүлгийн гишүүд, ТА төслийн нэгжийн ажилтнууд, Дэлхийн банкны ажилтнуудтай ярилцлага өрнүүлэх; (4) дүн шинжилгээ хийх, тайлан бичих; (5) бүх талын оролцогч талуудын санал хүсэлтийг цуглуулах; (6) тайланг боловсруулж дуусгах.

Шаардлагатай материал

Зөвлөх нь төсөлтэй холбоотой бүх баримт бичигтэй танилцах үүрэгтэй. Үүнд:

- ТА 3 төслийн Байгаль Орчин, Нийгэм Хамгааллын Менежментийн Төлөвлөгөө
- ЭМЯ-аас гаргасан байгаль орчны үнэлгээний удирдамж;
- ТА 2 төслийн Байгаль Орчны аудитын тайлан

ТА төслийн нэгж нь эдгээр баримт бичгээр хангана.

Тавигдах шаардлага

Үнэлгээг байгаль орчны болон байгалийн нөөцийн менежмент, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чиглэлээр өмнө нь туршлага хуримтлуулсан, Монгол улсын БОНБУ-ийн бодлого, журам, үйл явц, байгаль орчны менежменттэй холбоотой технологийн талаар мэдлэгтэй үндэсний зөвлөх гүйцэтгэнэ. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжиж байсан төсөл хөтөлбөрт БОУ-г хийж байсан туршлагатай бол давуу тал болно.

Зөвлөх (мэргэжилтэн) нь БОНБУ-ний арга зүйн ур чадвар эзэмшсэн байх ба байгаль орчны шинжлэх ухаан, газарзүй буюу газар ашиглалтын төлөвлөлт, байгалийн нөөцийн менежмент, бэлчээрийн экологи, бэлчээрийн агроном, мал аж ахуй, гидрологи буюу усны нөөцийн менежментийн чиглэлээр эсвэл бусад холбогдох салбарт дор хаяж магистрын зэрэг эзэмшсэн байх шаардлагатай бөгөөд багийн ахлагч холбогдох чиглэлээр 10-аас доошгүй жил ажилласан туршлагатай байх ёстой. Зөвлөх нь англи хэлний зохих мэдлэг чадвартай байх ёстой бөгөөд гэрээний хугацаанд хөдөө орон нутагт тогтмол ажиллах боломжтой байх ёстой.

ХАВСРАЛТ 4. Барилгын ажлын явцад байгаль орчин нийгмийн хамгааллыг сайжруулах талаар тавих шаардлага

Ерөнхий шаардлага

1. Төслийн гүйцэтгэгч болон түүний ажилчид тухайн барилга байгууламж барих явцад орон нутаг болон байгаль орчинд үзүүлж болох харш, сөрөг нөлөөг буруулах, урьдчилан сэргийлэх талаар энэхүү шаардлагад нийцсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.
 - Барилгын ажлыг дуусгах хүлээлгэн өгөхөөс өмнө орчныг нөхөн сэргээхтэй холбоотой аливаа ажлыг дуусган хүлээлгэн өгөх ёстой. Үүнд:
 - Барилгын ажлын үед өртсөн буюу хөндөгдсөн газар, хөрс ургамлыг сэргээн ургамалжуулж, ойжуулан тохижуулж, шаардлагатай нөхөн сэргээлтийн ажлуудыг хойшлуулалгүйгээр хийж дуусган хүлээлгэн өгөх;
 - Барилгын ажилд нөлөөлөгдсөн усны эх үүсвэр, гол горхи, булаг шанд гэх мэтийг хог хаягдлаас цэвэрлэх, урсцыг чөлөөтэй хэвийн болгох;
 - Илүүдэл материал, хог хаягдлыг цэвэрлэн ариутгасан байх;
 - Түр байгууламжуудыг нурааж, орчныг цэвэрлэн тохижуулсан байх.

Барилгын гүйцэтгэгч байгууллага байгаль орчин, барилгын гүйцэтгэлийн талаар мөрдөх дүрэм

1. Үндэсний болон орон нутгийн дүрэм журмуудад нийцүүлэх зорилгоор дараах асуудлуудыг зааварчилга болгоно. Гэрээт байгууллага нь барилгын ажил эхлэхээс өмнө, барилгын төлөвлөлтийн талаар болон холбогдох шаардлагуудын талаар төслийн инженер танилцуулж ойлгуулсан байх. Төслийн инженер, эдгээр төлөвлөгөө болон шаардлагуудыг хүлээн зөвшөөрсний дараа барилгын ажлыг эхэлж болно.

Хориглох зүйлс

2. Барилгын талбай болон түүний орчимд дараах зүйл хориотой:
 - Барилга барихыг зөвшөөрснөөс гаднах талбайн модыг огтлох;
 - Ан агнах, барих, загасчлах, ургамал түүх;
 - Зөвшөөрөгдөөгүй хортой материал ашиглах, ялангуяа хар тугалга агуулсан будаг, асбест гэх мэтийг ашиглах;
 - Архитекторын болон түүхийн ховор, үнэ цэнтэй зүйлийг нураах, сүйтгэх;
 - Гал гаргах;
 - Галт зэвсэг хэрэглэх (зөвшөөрөгдсөн харуул хамгаалалтаас бусад);
 - Архи согтууруулах ундаа хэрэглэх.

Тээвэр

3. Гэрээт байгууллага нь барилгын талбарт болон түүнд хүрэхэд зориулан барилгын талбайн инженертэй тохиролцон тусгайлан тогтоосон замыг ашиглах ба тухайн замын ангилалд тохирсон тээврийн хэрэгслийг ашиглана, түүнчлэн орон нутгийн зам, гүүрийг гэмтээхээс сэргийлж тэдгээрийн ачааллын тогтоосон, зөвшөөрөгдөх хэмжээг дагаж мөрдөнө. Гэрээт байгууллага нь тээвэрлэлтийн болон өөрийн буруу үйлдэл, ачаалал хэтрүүлснээс болж орон нутгийн зам, гүүр бусад байгууламжид учруулсан аливаа хохирлыг хариуцах ба тэдгээрийг засах, төлж өгөх үүрэгтэй.
4. Гэрээт байгууллага нь тогтоосон хэмжээнээс хэтэрсэн даацын болон илүү их дуу чимээ гаргадаг, утаа ялгаруулдаг тээврийн хэрэгслийг ашиглах ёсгүй. Барилга байшин ихтэй, оршин суугчид төвлөрсөн газарт хүнд мөнанизм, тээврийн хэрэгсэл ашиглахдаа дуу намжаагчийг зохих ёсоор хэрэглэх шаардлагатай.
5. Барилгын гүйцэтгэгч байгууллага нь гэрээт хугацаанд авто замын хяналтыг төслийн инженерийн зөвшөөрч баталсны дагуу зохих ёсоор зохион байгуулж ажиллах ёстой.

Ажиллагсад ба тэдний амьдрах байр орчин

6. Барилгын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь ажиллагсдын дийлэнх олонхыг орон нутгийн иргэдээс бүрдүүлэх ба тэдгээрийг шаардлагатай сургалтад хамруулан чадваржуулсан байна.
7. Барилгын гэрээт гүйцэтгэгч байгууллага нь барилгын талбай дээр ажиллах хүмүүсийн тоонд тохирсон бие засах газар, ариун цэврийн байгууламжийг байгуулж барилгын хугацаанд ашиглана. Бие засах газар нь халуун хүйтэн ус, саван болон гар хатаах төхөөрөмж зэрэг тоноглолоор бүрэн хангагдсан байх ёстой.
8. Гэрээт гүйцэтгэгч нь бие засах газраас гарах бохироор ойролцоох усны эх үүсвэрийг бохирдуулахгүйн тулд бохир хадгалан ариутгагч түр зуурын нөөцлөгчийг суурилуулж ашиглана

9. Гэрээт гүйцэтгэгч нь ажилчдын байр болон бие засах газраас гарах хатуу хог хаягдлыг хадгалан, зайлуулж устгах арга, системийг бий болгож ашиглана.
10. Гэрээт гүйцэтгэгч нь ажилчдын гал тогоонд болон халаалт, материал боловсруулахдаа модыг түлшинд зориулан ашиглахгүй бөгөөд шатдаг хий зэрэг түлшний өөр төрлийг ашиглах ёстой.
11. Гэрээт гүйцэтгэгч нь төслийн инженерийн зөвшөөрөлтэйгөөр барилгын талбайд албан контор, агуулах, засварын газрыг байгуулах бөгөөд эдгээр нь хүмүүс оршин суудаг суурин газраас 500м-ээс багагүй зайд байрших ёстой.
12. Гэрээт гүйцэтгэгч нь барилгын талбайд албан контор, агуулах, засварын газрыг байгуулах бөгөөд шатахуун, дизель түлш, асфальт, битум хадгалах агуулахыг гол, усны эх үүсвэрээс 500 метрээс хол байрлуулах ба бороо үерийн ус болон шүүрэлтээр дамжин усны эх үүсвэр лүү аливаа бохирдол оруулахааргүй нөхцөлийг хангаж ажиллах ёстой
13. Гэрээт гүйцэтгэгч нь ямар нэгэн материал бэлтгэх халаах явцад модыг түлш болгон ашиглах ёсгүй.

Хог хаягдал болон газрын эвдрэлээс сэргийлэх ажил:

14. Эрүүл ахуйн, хатуу болон аюултай хог хаягдлыг хатуу хяналт дор дараах арга хэмжээг авч зайлуулах арга хэмжээ авах ёстой. Үүнд:

Хог хаягдлын боловсруулалт:

15. Хог хаягдал гаргахгүй байх арга хэмээ авах.
16. Гарч байгаа хог хаягдлыг ялган ангилах. Хэрэв ямар нэг аюултай хог хаягдал гарч байгаа бол, тэдгээрийг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, устгах ажлыг нягт нямбай зохион байгуулах хэрэгтэй.
17. Хог хаягдлыг устгах газрыг тусгайлан тогтоож, тэмдэгжүүлж, устгах материалыг тодорхой тэмдэглэж нэг бүрчлэн булж устгана.
18. Барилгын явцад гарах бүх төрлийн хог, метал, ашиглагдсан тос, илүүдэл материалыг тодорхой батлагдсан газарт булах бөгөөд хог хаягдлыг булах батлагдсан газар нь гол, нуурын эрэг, намгархаг газраас 300 метрээс их зайд байрлах ёстой. Түүнчлэн хог хаягдлыг дахин ашиглах, боловсруулах арга техникийг аль болох ашиглахыг дэмжих хэрэгтэй.

Газрын элэгдэл эвдрэлээс сэргийлэх:

19. Аль болох бага хэмжээтэй газрыг хөндөх хэрэгтэй бөгөөд, тухайн газрыг аль болох хурдан сэргээх шаардлагатай ба үерийн хамгаалалтын дренаж, хагшаас тунадас барих далан сувгийг байгуулах шаардлагатай.
20. Барилгад ашиглагдах газрын өнгөн хөрсийг өвс, навчны хаягдал болон органик материалуудтай нь авч орон нутгийн эвдэрсэн газрыг нөхөн сэргээхэд ашиглана.
21. Барилгын орчин тойрны эвдэрсэн, элэгдсэн газрын нөхөн сэргээхэд орон нутгийн унаган төрөл зүйлийн ургамал, үрийг ашиглаж

22. Хөрсний эвдрэлээс хамгаалах арга хэмжээг барилга барих ажил дуусахад хэрэгжүүлж дуусгах шаардлагатай.
23. Барилгын бүх талбайд, үерийн усыг зайлуулах, сааруулах байгууламж барих, үерээр зөөгдөж ирэх шавар, шороо, чулууг тогтоох хамгаалах суваг шуудууг барина.
24. Барилгын талбай эсвэл ухагдсан газар урсах усны урсгалыг суваг, мод, байгууламж, өвс, чулуу гэх мэт зүйлсээр хянах.
25. Ургамалан давхарга ургаж сэргэх хүртэлх хугацаанд элэгдлээс хамгаалах арга хэмээг тогтмол хэрэгжүүлэх хэрэгтэй.
26. Шороон зам, ухсан газар, овоолсон шороо гэх мэт зүйлс дээр ус цацаж салхинаас үүсэх газрын элэгдлийг багасгах.

Засвар үйлчилгээ:

27. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх газрыг тусгайлан тодорхойлж тусгаарлах (гол, горхи, нуур, намгархаг газраас 15 м зайтай) шаардлагатай. Шатахууны агуулахыг зохих газарт байрлуулж, байрлалыг төслийн инженерээр батлуулна.
28. Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх, машин механизмын тос солих зэрэг ажлуудыг засвар үйлчилгээний хязгаарлалтын хэсэгт хийж гүйцэтгэнэ; хэрэглэсэн тосыг газар, усны суваг, ус зайлуулах суваг, бохир усны системд хаяж болохгүй.
29. Ашигласан шатах тослох материалыг байгаль орчны стандарт журамын дагуу хаях. Шатахуун хадгалах, түгээх газрыг ус зайлуулах байгууламж болон усны эх үүсвэрээс дор хаяж 300 м зайд буюу инженерийн зааврын дагуу байрлуулна.

Газар шорооны ажлын үед анхаарах асуудлууд

32. Барилга байгууламж барихтай холбоотой бүх төрлийн газар шорооны ажлуудад нарийн хяналт тавьж ажиллах ёстой.
33. Гэрээт гүйцэтгэгч нь газар ухах тэгшлэх ажлыг тухайн орчны унаган төрхийг алдагдуулахааргүйгээр хийхийг хичээх ёстой бөгөөд барилгын зөвшөөрөгдсөн талбайгаас гаднах талбайн газрыг хөндөх ёсгүй.
34. Гэрээт гүйцэтгэгч нь газар ухах аливаа ажлыг хур бороо орохоос өмнө амжуулж дуусгахаар төлөвлөж хэрэгжүүлэх хэрэгтэй ба үүнтэй холбоотойгоор үүсэж болох газрын элэгдэл эвдрэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх ёстой.

35. Газар шорооны үед гарсан овоолгыг элэгдэл эвдрэлээс хамгаалахын тулд зураг төслийн дагуу налууны дээд ба доод хэсэгт борооны уснаас хамгаалсан шуудуу татах ба ухалга овоолгын гадаргууг ургамалжуулна.
36. Барилгын талбайгаас ухаж авсан илүүдэл шороог төслийн инженерийн тогтоож өгсөн газарт хийж тэгшлээд нөхөн сэргээлт хийнэ.
37. Ухалгаас гарсан шороог овоолох газар нь усны урсгалд автахааргүй, газар тариалан, хөдөө аж ахуйн болон бусад эдэлбэрт нөлөөлөхөөргүй байх ба булж тэгшилсэн газар нь цаашид элэгдэл эвдрэлд орохооргүйгээр нягтруулагдсан байх ёстой.

Овоолго, карьер гаргах үед анхаарах асуудал

38. Барилгын ажилд хөрс шороо өөр газраас шинээр авч ашиглах тохиолдолд төслийн инженерийн зөвшөөрлийг авч түүний зааварчилгааны дагуу ашиглана. Шороо чулуу авч ашиглах газар нь голын голдирол, усны горимыг өөрчлөхөд нөлөөлөхөөргүй байх ёстой. Хэрэв гол мөрний эрэг эвдрэх, эсвэл гол мөрөнд чухал ач холбогдолтой материалыг авах тохиолдолд гол мөрний хэсгээс хайрга шороо авахыг хориглоно.
39. Гэрээт гүйцэтгэгч нь шороо чулуу авсан газрыг цэвэрлэж, хэвийн байдалд оруулсан байх ба уг газар нь тэгшлэгдсэн ус намаг тогтохооргүй, шумуул, хорхой шавж үүрлэхээргүй болсон байх ёстой.
40. Голын сав газраас чулуу хайрга авсан тохиолдолд ухсан нүхний гүн нь голын өргөний 10-ны 1-ээс бага хэмжээтэй байх ёстой ба голын урсгалыг өөрчлөх, сав газарт ямар нэг сөрөг нөлөө үзүүлээгүй байх шаардлагатай.
41. Хайрга чулуу бутлах төхөөрөмж ашиглах тохиолдолд төслийн инженерийн зөвшөөрөл, зааварчилгааг заавал авах ба бутлах төхөөрөмж нь хүн ам суурьшдаг газраас хол зайтай, тоос шороо, дуу чимээний нөлөө үзүүлэхээргүйгээр байрласан байвал зохино.
42. Чулуу шороо авах газарт гүйцэтгэгч:
 - Тухайн газрыг урьдчилан тогтоож тэмдэгжүүлсэн байх, энэ газар нь эгц налуу, элэгдэлд өртөмхий газар, усны эх үүсвэрээс наанадаж 15 метрээс их зайтай байх.
 - Тухайн газраас авах материалын хэмжээнд хязгаар тогтоосон байх.
 - Тухайн газраас авсан өнгөн хөрсийг тусад нь нөөцлөн хадгалж чулуу шороо авч хэрэглэсний дараа нөхөн сэргээлтэд буцаан ашиглаж уг газрыг тэгшилж зассан байх. Налуу, зам дагуу байрлалтай газарт элэгдэл эвдрэлээс хамгаалах тусгайлсан арга хэмжээг авч хэрэгжүүлнэ..
 - Тухайн газрын байгалийн даацыг хэтрүүлэлгүйгээр авч ашиглах ба дараа нь ухсан газарт органик гаралтай хаягдал хийж газрыг тэгшилж, ургамалжуулна. Ургамалжуулалтанд аль болох байгалийн ургамлын үр суулгац ашиглах шаардлагатай.
 - Хэрэв тухайн газарт ус зайлуулах, уснаас хамгаалах зорилготой судаг шуудуу байсан бол тэдгээрийг хэвийн байдалд оруулж үлдээх ёстой.

- Барилгын ажил дуусахад талбайд байгаа хог хаягдал, үлдэгдлийг бүрмөсөн цэвэрлэж орчныг тохижуулна.

Барилгын болон тээврийн хэрэгслээс гарсан хог хаягдлыг зайлуулах, устгах

43. Гэрээт гүйцэтгэгч нь барилгын талбайг цэвэрлэхэд өдөр тутам мөрдөх дүрэм гаргаж мөрдүүлэх ба үүнд барилгын ажлаас гарах хог хаягдал тэдгээрийг зайлуулах устгах байгууламж, аргачлалыг тусгасан байна.
44. Хуучин байсан барилгыг буулгах тохиолдолд түүнээс гарах материалуудыг шинэ барилгын ажилд боломжийн хэмжээгээр эргүүлэн ашиглах (тухайлбал: далан, ухсан газрыг дүүргэх гэм мэт). Үлдсэн хаягдлыг төслийн инженерийн зөвшөөрсөн, тодорхой газарт булж зайлуулна. Гэрээт гүйцэтгэгч нь хог хаягдал булж зайлуулах газрыг сонгохдоо (а) ойгоос хол; (б) байгалийн судаг жалгыг таглахааргүй; ба (в) ховор болон нэн ховор ургамалд сөрөг нөлөөлөхөөргүй газрыг сонгоно. Гэрээт гүйцэтгэгч нь барилгын материалын хог хаягдлыг ямар ч нөхцөлд байгалийн эмзэг бүс, орчинд хаяж булж болохгүй.
45. Барилгын материалын хог хаягдал барилгын орчны газарт хаягдсан тохиолдолд гэрээт гүйцэтгэгч эдгээр хог хаягдлыг яаралтай цэвэрлэж, газрыг Төслийн инженерийн тавьж буй шаардлагад нийцүүлэн нөхөн сэргээж хэвийн байдалд оруулж өгнө.
46. Барилгын явцад хийгдэх тээврийн ажлын нарийн хуваарь төлөвлөгөөг гарган Төслийн Инженерээр батлуулан хэрэгжүүлэх ба үүнд тээврийн хэрэгслийн хангамж хэрэгцээ, засвар үйлчилгээ, хийх, тэдгээрээс гарах хог хаягдлыг зайлуулах зэрэг бүхий л ажил асуудлыг тусгасан байна.

Барилгын ажлын үед мөрдөх аюулгүй ажиллагаа

47. Гэрээт гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагад барилгын талбайд ажиллах хүмүүсийн аюулгүй байдал болон ойролцоох өмч хөрөнгийг аливаа ослоос хамгаалах үүргийг тусгаж өгнө. Гэрээт гүйцэтгэгч нь үндэсний болон орон нутгийн түвшинд мөрдөгдөх ёстой аюулгүйн ажиллагааны дүрмийн шаардлагыг биелүүлэн, аливаа осол аваараас сэргийлэх, арга хэмжээг авах ба дараах зүйлсийг анхаарч ажиллана:
- Явган хүний замыг аль болох аюулгүй байдлаар тогтоож нягт нямбай тэмдэгжүүлсэн байх ёстой;
 - Хэрэв барилгын ойр орчимд сургууль байгаад, сургуулийн хүүхдүүд аюулд өртөж болзошгүй байвал замын хяналт хариуцсан ажилтныг ажиллуулж сургуулийн цагаар замын зохицуулалт хийлгэх ёстой;
 - Замын хөдөлгөөний тэмдэг тэмдэгжүүлэлтийг тодорхой хийж, явган хүмүүсийн аюулгүй байдлыг хангах эргүүл хяналтыг барилгыг барьж дуусах хүртэлх хугацаанд тогтмол ажиллуулах ёстой;
 - Барилгын ажил эхлэхээс өмнө ажиллагсдыг аюулгүйн ажиллагааны сургалтуудад хамруулах ёстой;
 - Ажиллагсдыг хувийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцсаар хангаж хэрэглээнд байнгын хяналт тавьж ажиллана;

- Химийн материал хэрэгсэл, бодис тус бүрээр аюулгүйн мэдээллийн жагсаалт гарган бүтгэж ажиллана;
- Бүх ажиллагсад дээрх аюулгүйн мэдээллийн жагсаалтыг уншиж танилцах ёстой ба тэдэнд болон хамтран ажиллагсдад нь тухайн бодис, хэрэгслээс үүдэн гарах нөлөөлөл, эрсдэлийн талаар тодорхой танилцуулсан байх ёстой;
- Асбестийн найрлагатай материал болон бусад хортой бодисуудыг тусгай сургагдсан ажилчаар устгуулах буюу ариутгуулах ба гүйцэтгэлд нь байнгын хяналт тавьж ажиллана;
- Их хэмжээний бороотой үед буюу аюултай нөхцөл байдал тохиолдсон үед барилгын ажлыг түр зогсоох.
- Барилгын ажлын үед газар хөдлөлтийн чичирхийллийн үед бүх цахилгаан болон механик тоног төхөөрөмжүүдийг яаралтай унтраах, зогсоох.

Дуу чимээ болон тоос шороог бууруулах арга хэмжээ

48. Дуу чимээ болон тоос шороог бууруулахын тулд гэрээт байгууллага нь:

- Барилгын ажилтай холбоотой тээврийн хөдөлгөөний хурдыг барилгын талбайн орчимд буюу 200 метрийн тойрог дотор 20км/цаг байхаар тогтоох;
- Барилгын талбай доторх бүх тээврийн хөдөлгөөнийг 15км/цаг байхаар тогтоох.
- Барилгын ажилд ажиллаж байгаа тээврийн хэрэгсэл, машин механизмууд, тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээг 90 дицбалл буюу түүнээс доош байхаар зохицуулж ажиллана.
- Эмзэг, өртөмхий газруудад (гэр хороолол, эмнэлэг, амралтын газар, гэх мэт.) илүү хатуу дэг журам тогтоох ба тогтоосноос илүү хэмжээний дуу чимээ гаргахыг хатуу хориглоно.
- Тоос шороо, тоосонцор үүсгэх аливаа үйлдвэрлэлийг багасгах, ойролцоох айл өрхүүд болон албан газруудад нөлөө үзүүлэхээс зайлсхийх, ба ялангуяа хүүхэд хөгшид бүхий орчинд илүү анхаарч ажиллах.
- Хөрс хуулах ажиллагааг тодорхой үе шаттайгаар, бага багаар гүйцэтгэх ба салхинд шороо босох, тоосонцор үүсэхээс сэргийлнэ.
- Барилгын талбайн эргэн тойронд тоос барих хаалт босгох, гэр хороолол, худалдааны төв, амралт сувиллын орчимд илүү анхаарал тавьж ажиллана.
- Шороон зам, газар ухалга, овоолго, чулуу шороо авч буй газруудад ус цацаж тоос шороог дарах, тоосонцор үүсэхээс хамгаална.
- Барилгын ажлаас үүдэлтэй чичирхийлэл, дуу чимээ гаргахыг бууруулах зохистой арга хэмжээг байнга авч хэрэгжүүлэх

Ашиглагдахгүй барилга, дэд бүтцийг буулгах үед баримтлах журам

49. Гүйцэтгэгч нь аливаа ашиглагдахгүй барилга байгууламжийг нурааж буулгахдаа ажиллагсад болон олон нийтийг дээрээс унах хог хаягдал, эмтэрхий хэлтэрхийд цохиулахаас хамгаалах сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авсан байх ёстой. Эдгээр арга хэмжээнд:

- Хог хаягдал унаж болзошгүй бүсийг тогтоож, барилгын дээд давхраас хог хаягдлыг аюулгүйгээр буулгах хоолой байгуулах
- Буулгах ажиллагааг бага багаар хэсэгчлэн гүйцэтгэх /хөрөөдөх, таслах, цүүцдэх гэх мэт/
- Хүнд даацын машиныг сул хог хаягдлыг дайрахаас сэргийлж замыг цэвэр байлгах
- Барилгын эмтэрсэн хэсгүүд унахаас хамгаалах тор, түр зуурын хамгаалалтын арга хэмжээг тавцан булан бүрд байгуулах, хамгаалалтын хаалтуудыг байгуулах.
- Тэсэлгээний ажлын явцад бүх ажлын байр талбайг чөлөөлөх, хэрэв ойр орчинд хүн, оршин суугчид барилга байгууламж байвал тэсэлгээнээс үсэрч болзошгүй чулуу болон хэлтэрхийнээс сэргийлж зориулалтын халхавч тор зэргийг хэрэглэх.
- Ажилчдыг хамгаалах хувцас хэрэгсэл, малгай, гутал, нүдний шил гэх мэтээр хангах

Олон нийттэй харилцах

50. Олон нийттэй харилцах харьцааг дээшлүүлэхийн тулд гүйцэтгэгч нь:

- Тухайн сум орон нутгийн иргэд олон нийтэд барилгын ажлын хуваарь, олон нийтийн үйлчилгээ, замын хөдөлгөөнийг түр хугацаагаар саатуулах хуваарь, шалтгаан, газар ухах, хуучин барилга нураах гэх мэтийн талаар тохиромжтой байдлаар урьдчилан мэдээлэх.
- Шөнийн цагаар барилгын ажил гүйцэтгэхийг хязгаарлах. Хэрэв шөнийн цагаар ажил гүйцэтгэх шаардлага гарвал нарийн хуваарь гарган олон нийтэд мэдээлэх шаардлагатай.
- Барилгын ажилтай холбоотойгоор аливаа үйлчилгээг /ус хангамж, цахилгаан, телефон холбоо таслах, автобусны хөдөлгөөн маршрут өөрчлөх гэх мэт/ саатуулах тохиолдолд наанадаж 5 хоногийн өмнөөс олон нийтэд мэдээлж тэднийг ажил амьдралаа зохицуулах боломж олгоно..

Байгаль, Түүх, Соёлын Дурсгал илрүүлэх тохиолдолд анхаарах асуудлууд:

51. Гүйцэтгэгч нь газар шорооны ажил хийх явцдаа ямар нэг архелогийн олдвор, түүхийн дурсгал, шарил бүхий газар, илрүүлсэн тохиолдолд:

- Тухайн илэрц бүхий газарт барилгын ажил явуулахыг тодорхой хугацаагаар зогсоох;
- Илэрц бүхий газрыг зааглан тусгаарлах;
- Тухайн зүйлсийг зохих журмын дагуу зөөх хүртэл хугацаанд түүний бүрэн бүтэн байдлыг хамгаалах. Эртний болон ховор эд зүйл олдсон тохиолдолд түүнийг хариуцах түүх соёлын байгууллага, эсвэл орон

нутгийн захиргааны байгууллагад мэдээлж хүлээлгэн өгөх хүртэл харуул хамгаалалтыг хариуцан гүйцэтгэнэ.

- Орон нутгийн захиргаа болон түүх соёлын асуудал хариуцсан байгууллагад мэдэгдэх үүргийг барилгын талбайн хяналтын инженер хариуцах ба тэрээр дээрх байгууллагуудад энэ тухай 24 цагийн дотор мэдээлэх үүрэгтэй байна;
- Тухайн асуудлаар үүрэг хариуцлага хүлээсэн байгууллага, орон нутгийн захиргаа нь тухайн түүх, соёлын дурсгалт зүйлийг хэрхэх тухай зохих шийдвэр гарах хүртэлх хугацаанд тэдгээрийн хамгаалалт, хадгалалтын асуудлыг хариуцна. Тухайн асуудал хариуцсан мэргэжлийн байгууллага олдсон эд зүйлд урьдчилсан үнэлгээ өгнө. Олдсон эд зүйлийн ач холбогдол, үнэ цэнийг түүх, соёл, шинжлэх ухаан, нийгэм эдийн засгийн ач холбогдлоор нь үнэлнэ;
- Олдворыг хэрхэх тухай шийдвэрийг тухайн асуудал хариуцсан байгууллага гаргана. Энэ шийдвэрт тухайн газрыг хамгаалах, тухайн зүйлийг шилжүүлэх, эсвэл барилгын талбайн зураглалд өөрчлөлт оруулах зэрэг асуудлыг тусгана;
- Олдворыг хэрхэх талаар эрх бүхий байгууллагын гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх асуудлыг орон нутгийн захиргааны албан бичгээр баталгаажуулна;
- Тухайн олдворыг аюулгүй баталгаатай байдлаар зохицуулах тухай шийдвэр гарч түүнийг хэрэгжүүлсний дараа тухайн эрх бүхий байгууллагын өгсөн шийдвэрээр барилгын ажлыг сэргээн үргэлжлүүлнэ.

Аюултай материалын талаар авах арга хэмжээ

52. Хэрэв барилгын талбайд ямар нэг хортой, аюултай материал (асбест агуулсан хаягдал материал гэх мэт) байгаа нь ажиглагдсан тохиолдолд гэрээт гүйцэтгэгчээс Аюултай Хог Хаягдлын Боловсруулалтын Төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхийг шаардах ба энэхүү төлөвлөгөөг Төслийн инженер батлан мөрдүүлнэ. Энэ төлөвлөгөө нь барилгын болон тээврийн бүх ажилд оролцож байгаа ажилчдад мэдээлэгдэж танилцуулагдсан байх ёстой. Аюултай хог хаягдлыг зайлуулах, устгах ажлыг зөвхөн тусгайлан сургагдсан ажилчид үндэсний болон олон улсын хэмжээнд тавигддаг шаардлагын дагуу гүйцэтгэнэ.

Эрүүл мэндийн үйлчилгээ, ХДХВ / ДОХ-ын талаар сургалт

53. Гэрээт гүйцэтгэгч нь ажиллагсдынхаа анхны тусламж үзүүлэх, барилгын ажилтай холбоотой үүсэж болох осол аваарын үед хэрэглэх хувийн хэрэгцээний эм, эмнэлгийн зүйлсээр хангах ёстой.

54. Гүйцэтгэгч ажилчдын дунд бэлгийн замын халдварт өвчнийг, ялангуяа ХДХВ / ДОХ-ын халдвар илрүүлэх шинжилгээ хийх хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэгтэй.

55. Гүйцэтгэгч өөрийн саналд Эрүүл мэндийн төлөвлөгөөний оруулна. Төслийн инженер нь Барилга угсралтын ажил эхлэхээс өмнө Гүйцэтгэгчид үүнтэй холбоотой гэрчилгээ олгоно.

Барилгын ажлын явц дахь байгаль орчны хяналт удирдлага

56. Төслийн инженер байгаль орчинтой холбоотой аливаа асуудлын гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана. Хэрэв аливаа нэг шаардлагыг хэрэгжүүлэхгүй биелүүлэхгүй байгаа тохиолдолд, Төслийн Инженер нь торгох, тухайн шаардлага хангаагүй ажлыг засаж сайжруулах хүртэл ажлыг түр ба тодорхой хугацаагаар зогсоох арга хэмжээ авна. Гэрээт байгууллага нь үндэсний болон тухайн аймаг сумын захиргаанаас байгаль орчин эрүүл мэнд аюулгүй байдлын талаар гаргасан аливаа зааварчилга шаардлагыг биелүүлэх шаардлагатай.